- Харьяа 7 байгууллага цахим төлбөрийн системд шивээгүй, цахим и-баримтгүй 460.7 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан /Дорноговь АЗЗА ТӨХК 256.0 сая төгрөг, Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын харьяа байгууллагууд 192.3 сая төгрөг, Төв АЗЗА ТӨХК 6.5 сая төгрөг, Баянчандмань АЗЗА ТӨХК 3.6 сая төгрөг, Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХК 1.2 сая төгрөг, Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ 1.1 сая төгрөг/
- Иргэний нисэхийн үндэсний төв-Улаанбаатар хот дахь харьяа байгууллагууд тайлант оны эцэст салбарын хэмжээнд мөнгөн хөрөнгийн заавал байлгах нөөцийн хэмжээ 8,819.1 сая төгрөгөөр буурсан;

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 144,434.3 сая төгрөг болж, 7,083.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	26.9	11.5	(15.4)
Төлбөртэй үйлчилгээний авлага	32,020.9	24,414.9	(7,606.0)
Татаас, санхүүжилтийн авлага	2,201.9	-	(2,201.9)

Зээлийн хүүгийн авлага	-	23.8	23.8
Дансны авлага /ТӨҮГ/	21,015.8	44,860.0	23,844.2
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	43,870.4	53,097.0	9,226.6
Бусад авлага	38,214.5	22,027.1	(16,187.4)
Дүн	137,350.4	144,434.3	7,083.9

Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Авлага дансны үлдэгдэл 7,083.9 сая төгрөгөөр өсөхөд Монголын төмөр зам ТӨХК-ийн ачаа тээврийн болон өөрийн эзэмшлийн вагон түрээстэй холбоотой 15,569.0 сая төгрөг, МИАТ ТӨХК-ийн борлуулалтын авлага болон НӨАТ-ын буцаалтын авлага 14,975.4 сая төгрөгөөр өссөн зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Төлбөртэй үйлчилгээний авлагад ИНЕГ-ын гадаад, дотоодын агаарын тээвэрлэгчидтэй холбоотой үйлчилгээний төлбөрийн 24,414.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Дансны авлагад МИАТ ТӨХК-ийн олон улсын нислэг тээвэрлэлтийн борлуулалтын авлагын 23,766.0 сая төгрөг, Монголын төмөр зам ТӨХК-ийн орон нутгийн болон олон улсын ачаа тээврийн, өөрийн эзэмшлийн вагон болон шилжүүлэн ачих цогцолборын түрээсийн авлагын 15,633.7 сая төгрөг, Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын эмульсийн үйлдвэрийн урьдчилгаа төлбөрийн болон тоног төхөөрөмжийн түрээсийн, төлбөртэй үйлчилгээний авлагын 558.0 сая төгрөг, Авто-Импэкс ХК-ийн түрээсийн авлагын 337.8 сая төгрөг, бусад 19 байгууллагын 4,564.5 сая төгрөг, нийт 44,860.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Татвар, НДШ-ийн авлагын үлдэгдэлд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих бүтээн байгуулалтын төслийн гэрээт ажлын худалдан авалтын НӨАТ-ын буцаалт 41,056.1 сая төгрөг, МИАТ ТӨХК-ийн агаарын хөлгийн шатахуун худалдан авалтын НӨАТ-ын буцаалт 6,275.3 сая төгрөг, ИНЕГ-ын бусад худалдан авалтын НӨАТ-ын буцаалт 5,254.4 сая төгрөг, бусад 9 байгууллагын 511.2 сая төгрөгийн НӨАТ-ын буцаалтын авлага байна.

Бусад авлагад ИНЕГ-ын өөрийн хөрөнгөөр өмнөх онуудад болон он дамжин хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын ажлын 18,544.5 сая төгрөг, МИАТ ТӨХК-ийн бусад авлагын 2,056.1 сая төгрөг, Далайн захиргааны хөлөг онгоцны бүртгэлийн орлоготой холбоотой 539.1 сая төгрөг, бусад 10 байгууллагын 887.4 сая төгрөг, нийт 22,027.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- МИАТ ТӨХК-ийн Агаарын тээврийн зорчигчийн тийз борлуулалтын үйл ажиллагаа эрхлэн явуулах борлуулагч агентын гэрээний үүргийг Зэт хорин дөрөв ХХК нь хангаж ажиллаагүйгээс тийз борлуулалтын орлогоос үүссэн 993.2 сая төгрөг төгрөгийн авлагыг барагдуулах ажиллагаа удаашралтай байгаа нь найдваргүй авлага болж, авлагын үлдэгдэлд өндөр эрсдэлийг бий болгосон;
- МИАТ ТӨХК харилцагчийн нэр, баримтын дугаар болон гүйлгээний утгыг анхан шатны баримтад үндэслэн ерөнхий журналд бүрэн шивдэггүйгээс орлогоор хүлээн зөвшөөрсөн 32,820.0 сая төгрөг төгрөгийн ачаа тээврийн борлуулалтын орлогын авлага, өглөгийн хаалтыг харилцагч тус бүрээр тулган баталгаажуулж чадаагүй;
- МИАТ ТӨХК-ийн агаарын хөлгийн 2 дугаар нисгэгчээр ажиллаж байсан ажилтны ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ Берлин хотын "Adina" зочид буудалд учруулсан 139.6 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй;
- Багануур АЗЗА ТӨХК тайлант онд 413.0 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, өмнөх онд үүссэн 153.4 сая төгрөгийн авлага барагдуулаагүй, мал амьтан борлуулсны 9.2 сая төгрөгийн орлогыг гэрээний дагуу хүлээн аваагүй, авлагаар бүртгээгүй;
- Үйл ажиллагаагаа зохистой удирдаагүйгээс нийт 278.2 сая төгрөгийн насжилт ихтэй авлага үүсгэн, барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй; /Өвөрхангай АЗЗА ТӨХК 224.8 сая төгрөг, Талын зам ТӨХК 27.6 сая төгрөг, Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ 23.9 сая төгрөг, Увс АЗЗА ТӨХК 2.0 сая төгрөг/
- ИНҮТ-ийн хэмжээнд 8,794.6 сая төгрөгийн дансны авлага бүртгэлтэй байгаагаас МИАТ ТӨХК-аас авах 1,125.5 сая төгрөг, Аеромонголиа ХХК-аас авах 1,852.3 сая төгрөг, Хүннү эйр ХХК-аас авах 4,216.3 сая төгрөг, нийт 7,194.3 сая төгрөгийн авлагын эргэлт удааширсан нь агаарын навигацийн болон нисэх буудлуудын үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангах санхүүгийн эх үүсвэр бүрдэхэд сөргөөр нөлөөлж байна;
- АТҮТ ТӨҮГ-ын харьяа байгууллагууд татварын e-tax программын тооцооллоор суутган татвар 22.0 сая төгрөг, НӨАТ-ын алданги 1.3 сая төгрөг, ААНОАТ 6.2 сая төгрөг, нийт 29.5 сая төгрөгийн авлагыг тус төвийн тайланд тусгаагүй;

- Харьяа 4 байгууллага нийт 400.6 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй /МИАТ ТӨХК 256.8 сая төгрөг, Булган АЗЗА ТӨХК 213.6 сая төгрөг, Хэнтий аймгийн Харгуй ТӨХК 2.2 сая төгрөг гэх мэт/
- Увс АЗЗА ТӨХК баримтгүйгээр 47.4 сая төгрөгийн гүйлгээ хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн;

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 105,674.4 сая төгрөг болж, 27,600.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	133,274.7	105,674.4	(27,600.3)
Дүн	133,274.7	105,674.4	(27,600.3)

Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Урьдчилгаа дансны үлдэгдэл 27,600.3 сая төгрөгөөр буурсан нь Монголын төмөр зам ТӨХК-ийн Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих төслийн гэрээт ажилд өгсөн урьдчилгааг дуусаагүй үйлдвэрлэл дансанд шилжүүлсэн, ИНЕГ-ын үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгааг тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэн зэргээс шалтгаалсан байна.

3.4.4 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 664,260.9 сая төгрөг болж, 159,435.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Бусад санхүүгийн хөрөнгө /ТӨҮГ/	-	5,000.0	5,000.0
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	504,789.3	659,224.4	154,435.1
БЗЭБуй эргэлтийн хөрөнгө	36.5	36.5	-
Дүн	504,825.8	664,260.9	159,435.1

Бусад эргэлтийн хөрөнгийн дансны 664,260.9 сая төгрөгийн үлдэгдэлд ЗТХЯ-ны хөрөнгө оруулалтын концессын гэрээгээр гүйцэтгэсэн Хандгайт өртөөний 34 км төмөр зам, ачиж буулгах терминалын болон авто замын барилгын ажлын 630,915.7 сая төгрөг, ИНЕГ-ын Улаанбаатар хотын шинэ нисэх буудал барих төслийн хүрээнд хийсэн зарим ажлын 24,835.1 сая төгрөг, МИАТ ТӨХК-ийн арилжааны банкин дахь хадгаламжийн дансанд байршуулсан 5,000.0 сая төгрөг, Улсын авто замын сангийн улсын чанартай авто замын дагуу барих амрах талбай, зогсоолын 3,473.6 сая төгрөг, Ховд АЗЗА ТӨХК-ийн олон жилийн насжилттай авлагыг барагдуулахаар авсан ачигч машины 36.5 сая төгрөг тус тус эзэлж байна.

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 159,435.1 сая төгрөгөөр өссөн нь тус яамны хөрөнгө оруулалтын орон нутагт эрх шилжүүлэн хийгдсэн авто замын барилгын ажлууд болон төслийн дотоод эх үүсвэрээр хийсэн үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэх хөрөнгийн зардлыг хуримтлуулан бүртгэсэнтэй холбоотой байна.

3.4.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын данс нь 742,418.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 6. Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Үнэт цаас	693,767.5	693,767.5	-
Урт хугацаат зээл	48,651.4	48,651.4	-
Дүн	742,418.9	742,418.9	-

Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Урт хугацаат хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэлд Монголын төмөр зам ТӨХК-ийн Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын төсөлд оруулсан хөрөнгийн 693,767.5 сая төгрөгийн үнэт цаас, Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХК-нд Засгийн газрын 2018 оны 175 дугаар тогтоолоор Монгол-Японы хамтарсан хуулийн этгээд Улаанбаатар хотын шинэ нисэх онгоцны буудлын менежмент төслийг хэрэгжүүлэх хоёр дахь ээлжийн хөрөнгө оруулалтын 48,407.4 сая төгрөг, Далайн захиргаа ТӨҮГ Засгийн газрын 2015 оны 180 дугаар тогтоолоор БНСУ-д бүртгэлтэй далайн тээврийн "Монгол-Саммок ложистик" хамтарсан компани байгуулж, хөрөнгө оруулалтын 190.3 сая төгрөг, Авто-Импэкс ХК-ийн далайн тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан компанид оруулсан хөрөнгийн 53.7 сая төгрөгийн үлдэгдэл тус тус бүртгэлтэй байна.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн цэвэр үлдэгдэл 6,817,221.0 сая төгрөг болж, 352,367.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая төгрөг/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Газар	13,227.0	13,376.9	149.9
Барилга, байгууламж, орон сууц	1,321,491.8	1,274,421.0	(47,070.8)
Авто-тээврийн хэрэгсэл	124,945.1	124,825.7	(119.4)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	251,448.9	255,337.2	3,888.3
Тавилга, аж ахуйн эд хогшил	4,580.7	4,865.9	285.2
Зам, гүүрийн байгууламж	3,504,040.4	3,012,686.7	(491,353.7)
Бусад үндсэн хөрөнгө	106,254.1	93,763.5	(12,490.6)
Дуусаагүй барилга, байгууламж	1,118,106.7	1,250,311.7	132,205.0
Биет бус хөрөнгө	703,069.6	739,958.8	36,889.2
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	22,423.8	47,673.6	25,249.8
Дүн	7,169,588.1	6,817,221.0	(352,367.1)

Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгийн цэвэр үлдэгдэл 352,367.1 сая төгрөгөөр буурахад тайлант онд нийт 22,429.5 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, 224,122.3 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн авч, данс бүртгэлд тусгаж, 61,925.9 сая төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 1,633.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хасаж, 39,283.4 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлж, 1,450.2 сая төгрөгийн хөрөнгийн дахин үнэлгээний хорогдол тооцож, 621,125.8 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсон зэргээс шалтгаалсан байна.

ИНЕГ-т ТӨБЗГ-ын 2019 оны 382 дугаар тогтоолоор Нью Улаанбаатар интернейшнл эйрпорт ХХК-ийн ашиглаж буй Шинэ нисэх буудлын 1,255,754.3 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн бүртгүүлснээс тайлант оны элэгдлийн зардалд 66,183.5 сая төгрөгийг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь байгууллагын үр дүнд нөлөөлж байна.

Монголын төмөр зам ТӨХК-ийн үндсэн хөрөнгө 133,326.4 сая төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2022 оны 10 дугаар тогтоолоор 1.5 км салаа төмөр замыг, бүс нутгийн логистикийн төвийн хашаа, оффисын байрыг тус тус орлогод авсан, Хилийн боомтын үндэсний зөвлөлийн 2021 оны 12 дугаар тогтоолын дагуу 30 ширхэг ачааны хагас вагон, 2 ширхэг авто чингэлэг өргөгч, 1 ширхэг автомашин худалдан авсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Иргэний нисэхийн үндэсний төв-Улаанбаатар хот дахь харьяа байгууллагууд эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр, өмнөх онд бүтцээр шилжсэн 107,718.3 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст нөхөн бүртгэсэн;
- Дорноговь АЗЗА ТӨХК ТӨБЗГ-аас баталсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг мөрдөж ажиллаагүй, техникийн хувийн хэргийг хөтлөөгүй, тээврийн хэрэгсэлд сэлбэг, эд анги, аккумулятор, дугуй солиход зөвлөлийн шийдвэр гаргаагүй;

60

- ИНЕГ тайлант онд Засгийн газрын авто баазад хүлээлгэн өгсөн 39.3 сая төгрөгийн анхны өртөгтэй автомашиныг данс, бүртгэлээс хасаагүй, мөн тус газрын дансанд бүртгэлтэй 35.8 сая төгрөгийн авто машин биетээр байхгүй, Зам, тээврийн хөгжлийн яаманд ашиглуулсан;
- Монголын төмөр зам ТӨХК Таван толгой-Зүүн баян чиглэлийн төмөр замын Хулангийн шанд зөрлөг дээр Монголиан транс ложистик ХХК-ийн хөдлөх бүрэлдэхүүн замаас гарч осол гаргасан. Үүний улмаас тус компанид үүссэн дохиолол холбооны тоног төхөөрөмжийн бодит хохирлыг БНСУ-н Солонгосын үндэсний төмөр зам компаниас тооцон ирүүлснийг нөхөн төлүүлээгүй;
- Улсын авто замын сан Азийн хөгжлийн банкны МОН-3129 зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслийн хүрээнд нийлүүлсэн 4 төрлийн тусгай зориулалтын авто замын засвар, арчлалтын техникийг үндсэн хөрөнгөд бүртгээгүй, тушаал шийдвэрт хөрөнгийн өртөг, зээлийн хүү, ханшийн алдагдлын талаарх мэдээлэл тодорхойгүй;
- Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна / Баянчандмань АЗЗА ТӨХК 47 нэр төрлийн 255.4 сая төгрөг, Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ 20 нэр төрлийн 218.1 сая төгрөг, Орхон АЗЗА ТӨХК 80 нэр төрлийн 855.6 сая төгрөг, Талын зам ТӨХК 36 нэр төрлийн хөрөнгө/;
- Багануур АЗЗА ТӨХК зарлагын баримт, шаардах хуудсаар баталгаажуулан 6.0 сая төгрөгийн авто замын хашлагыг нотлох дэмжих баримтгүй данснаас хассан;
- Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв биет бус хөрөнгийн шинжтэй 4.8 сая төгрөгийн видео контентыг бараа материалын дансанд бүртгэж, өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрээр данс бүртгэлээс хассан;
- Далайн захиргаа ТӨҮГ-ын бэлтгэсэн 4.1 сая төгрөгийн өртөгтэй "notebook"-ийг данс бүртгэлд тусгасан боловч хүлээн аваагүй, ЗТХЯ-нд ашиглаж байна;
- ИНҮТ ААТҮГ нь Нью Улаанбаатар интернейшнл эйрпорт ХХК-ийн ашиглаж буй үндсэн хөрөнгийн тайлант оны элэгдлийн зардал 66,183.5 сая төгрөгийг ИНЕГ-ын салбарын зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэж, ашиглаж эхэлсэн 2019 оноос нийт 105,023.7 сая төгрөгийг элэгдлийн зардалд бүртгэсэн;

3.4.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 2,226,000.6 сая төгрөг болж, 190,738.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Өр төлбөрийн үлдэгдэл

/ сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	337,091.4	350,528.8	13,437.4
Богино хугацаат зээлийн өглөг	45,317.2	46,221.8	904.6
Өглөг	238,227.0	222,463.6	(15,763.4)
Урьдчилж орсон орлого	53,547.2	81,843.4	28,296.2
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,698,170.5	1,875,471.8	177,301.3
Урт хугацаат үнэт цаас	1,153,405.3	1,273,405.3	120,000.0
Урт хугацаат зээл	544,765.2	602,066.5	57,301.3
Дүн	2,035,261.9	2,226,000.6	190,738.7

Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Нийт өр төлбөрийн үлдэгдэл нэмэгдэхэд богино хугацаат зээлийн өглөг 904.6 сая төгрөг, урьдчилж орсон орлого 28,296.2 сая төгрөг, урт хугацаат үнэт цаас 120,000.0 сая төгрөг, урт хугацаат зээлийн үлдэгдэл валютын ханшийн зөрүүгийн алдагдлаас шалтгаалан 57,301.3 сая төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд бараа, ажил үйлчилгээний 51,801.0 сая төгрөг, богино хугацаат зээлийн 46,221.8 сая төгрөг, хөрөнгө оруулалтын барьцааны 26,086.3 сая төгрөг, үндсэн хөрөнгө бэлтгэхтэй холбоотой 2,460.4 сая төгрөг, зээлийн хүүгийн 323.5 сая төгрөг, ажилчидтай холбоотой 69.1 сая төгрөгийн өглөгүүд байна.

Мөн бусад өглөгийн дансанд төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын 84,927.0 сая төгрөг, татвар, НДШ-ийн 28,064.3 сая төгрөг, хувь хүн, байгууллагад төлөх 21,396.9 сая төгрөг, ногдол ашгийн 7,335.1 сая төгрөг, төлбөртэй үйлчилгээний урьдчилж орсон орлогын 81,843.4 сая төгрөгийн өглөгүүд тус тус бүртгэлтэй байна.

Урт хугацаат ер төлбөр дансны үлдэгдэл 1,875,471.8 сая төгрөг болж, 177,301.3 сая төгрөгөөр өссөн нь Монголын төмөр зам ТӨХК-ийн “Эрдэнэс таван толгой” ХК-д төлөх Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих төслийн тайлант оны санхүүжилт болох 120,000.0 сая төгрөгөөр үнэт цаасны ер төлбөр нэмэгдсэн, БНХАУ-ын Экспорт импортын банкнаас “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн нийлүүлэх төсөл”-ийн хүрээнд зээлээр худалдан авсан тоног төхөөрөмж, Азийн хөгжлийн банкны Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх төсөл хөтөлбөрийн валютын зээлийн ханшийн зөрүүний алдагдал 59,070.0 сая төгрөг тус тус нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт:

- МИАТ ТӨХК Монгол Улс дахь нисэх буудлын үйлчилгээг үзүүлж буй Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК-тай МИАТ ХК-ийн зүгээс хамтран ажиллаж байгаа ба тайлант хугацаанд нийт 8,468.5 сая төгрөгийн ер төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, аудитын явцад ирүүлсэн тулган баталгаажуулалтын захидлаас харахад энэхүү үлдэгдэл нь харилцагч байгууллагын үлдэгдлээс 2,765.1 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн;
- МИАТ ТӨХК ажилтан, үйлдвэрчний эвлэлийн 3 талт "Хамтын гэрээ"-ний дагуу тус компани нь тэтгэвэрт гарч буй ажилтнуудаа тэтгэмж олгох үүрэг хариуцлагыг хүлээсэн боловч ирээдүйд хүлээх өнөөгийн үүрэг хариуцлагын нөөц ер төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөөгүй байна. Энэ нь санхүүгийн тайланд үлэмж хэмжээгээр нөлөөлөх, материаллаг дүн бүхий хөрөнгө, ер төлбөрийг санхүүгийн тайланд үүсгэхээр байна;
- Хархорин АЗЗА ТӨХК Кувейтийн сангийн хөрөнгөөр ирсэн машин, техник хэрэгслийг 2009 онд урт хугацаат ер төлбөрөөр бүртгэсэн ч өнөөг хүртэл барагдуулаагүй, хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй;
- Баянчандмань АЗЗА ТӨХК тайлант хугацаанд 2 байгууллагын 5.6 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн-актаар баталгаажуулаагүй;
- АТҮТ ТӨҮГ-ын харьяа байгууллагууд тэмдэгтийн хураамжийн 1.1 сая төгрөгийн өглөгийг тус төвийн тайланд тусгаагүй;

3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 6,525,419.2 сая төгрөг болж, 372,530.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	2,267,364.6	2,274,874.8	7,510.2
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	92,091.0	93,245.9	1,154.9
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	532.9	-	(532.9)
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	32.6	32.6	-
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	806,089.6	806,317.7	228.1
Хуримтлагдсан үр дүн	1,474,788.7	1,071,110.2	(403,678.5)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,256,936.9	2,279,724.6	22,787.7
Хяналтын бус хувь оролцоо	113.4	113.4	-
Дүн	6,897,949.7	6,525,419.2	(372,530.5)

Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 372,530.5 сая төгрөгөөр буурсан нь төрийн өмчит үйлдвэрийн газрын эздийн өмчийн бусад хэсэг болон хуримтлагдсан үр дүнгээс голлон шалтгаалжээ. Үүнд:

- Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдэл 2,274,874.8 сая төгрөг болж, 7,510.2 сая төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2022 оны А-1/2340 дугаар албан бичгийн дагуу ИНҮТ-ийн эзэмшлийн 11.9 га газрыг 7,538.6 сая төгрөгөөр үнэлж, биет бус хөрөнгөнд бүртгэсэнтэй холбоотой;
- Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 403,678.5 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан;
- Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны үлдэгдэл өсөхөд ТӨБЗГ-ын 2022 оны 520, 627 дугаар тогтоолын дагуу ИНҮТ-ийн 9961 ширхэг хөрөнгийг 22,820.3 сая төгрөгөөр дахин үнэлж данс бүртгэлд тусгасан нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг ирүүлэхээр заасан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд хамаарах тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл /нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр/, тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/, нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулгыг хавсаргаж ирүүлсэн байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 879,552.2 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 138,108.4 сая төгрөгөөр бүрдүүлж, урсгал зардалд 20,651.3 сая төгрөг, хөрөнгийн зардалд 997,009.3 сая төгрөгийг зарцуулахаар тооцон төлөвлөж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, хөрөнгийн зардлыг 546,238.2 сая төгрөг, урсгал зардлыг 6,329.7 сая төгрөг, нийт 552,567.9 сая төгрөгөөр бууруулсныг УИХ-аас 465,092.7 сая төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд хийсэн төсвийн тодотголоор 172,983.0 сая төгрөгөөр бууруулан 292,109.7 сая төгрөгөөр баталсан байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 267,109.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 25,000.0 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Зам, тээврийн хөгжлийн сайдаас 2022 онд улсын төсөвт 138,108.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад төсвийн төсөл хүргүүлснийг 37,121.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 175,230.0 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 29,775.2 сая төгрөг төвлөрүүлж, гүйцэтгэл 17.0 хувьтай байна.

Хүснэгт 10. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэл

/сая төгрөг/

Д/д	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Навигацийн орлого /ИНЕГ/	150,000.0	16,000.0	134,000.0	10.7
2	Монгол Улсын Төрийн далбаа мандуулж ашигласны орлого /Далайн захиргаа ТӨҮГ/	230.0	230.0	-	100.0
3	Төлбөр хураах цэгийн орлого /УАЗС/	25,000.0	13,545.2	11,454.8	54.2
Нийт дүн		175,230.0	29,775.2	145,454.8	17.0

Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТЕЗ-ийн тайлант онд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 145,454.8 сая төгрөгөөр тасарсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

а) Иргэний нисэхийн ерөнхий газрын улсын төсөвт төвлөрүүлэх навигацийн орлогын төлөвлөгөө 89.3 хувиар тасарсан нь олон улсын геополитикийн тогтворгүй нөхцөл байдалтай холбоотой нислэгийн өнгөрөлтийн тоо буурснаас шалтгаалсан;

б) Улсын авто замын сангийн төлбөр хураах цэгийн орлого 45.8 хувиар тасарсан нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар түлхүүр гардуулах нөхцөлтэй "Төлбөр авах цэг барих" ажлыг хугацаандаа гүйцэтгээгүйгээс төлбөр хураах цэгийн орлого 9-24 сараар тасалдсан, төлбөр хураах цэгийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулаагүй, дотоод хяналт хангалтгүй, цар тахалтай холбоотой дамжин өнгөрөх автомашины тоо буурсан зэрэгтэй холбоотой;

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарцуулалт

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 267,041.6 сая төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлого 13,545.3 сая төгрөгийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 280,546.0 сая төгрөг буюу 96.0 хувьтай байгаа нь тус яамны хөрөнгө оруулалтын санхүүжилтийг ажлын гүйцэтгэлээр олгосноос бусад зардлын төсвийг 11,389.5 сая төгрөг, Улсын авто замын сангийн орлогын төлөвлөгөө тасарсантай холбоотой үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 123.9 сая төгрөг, байр ашиглалтын төсвийг 0.4 сая төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын төсвийг 32.8 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71107	Зам тээврийн бодлого, удирдлага	292,109.7	280,546.0	11,563.7	96.0
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	13,255.1	13,114.1	141.0	98.9
1.2	80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	71.3	71.3	-	100.0
1.3	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	160.1	159.7	0.4	99.8
1.4	80509	ОУ-ын байг-ын гишүүнчлэл хураамж	156.8	156.8	-	100.0
1.5	80704	Ахмад дайчин, алдар цолтой ахмадад	172.5	172.5	-	100.0
1.6	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	222.5	189.7	32.8	85.3
1.7	80918	Бусад	278,071.4	266,681.9	11,389.5	95.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 280,586.9 сая төгрөгийн санхүүжилт олгосноос урсгал үйл ажиллагаанд 13,707.3 сая төгрөг, гадаад урсгал шилжүүлэгт 156.8 сая төгрөг, хөрөнгийн болон бусад зардалд 266,681.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар Засгийн газрын нөөц хөрөнгөөс төсвийн захирагчид хуваарилсан орлого 4,780.0 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,473.6 сая төгрөг, нийт 8,253.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал зардалд зарцуулжээ. Үүнд:

1. Засгийн газрын 2022 оны 233 дугаар "Хөрөнгө гаргах тухай" тогтоолоор уул уурхайн хүнд машин механизмын нөлөөгөөр эвдэрсэн Мандалговь-Даланзадгад чиглэлийн 305.1 км авто замыг сэргээн засах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад шаардагдах хөрөнгийг нийгмийн хариуцлагын хүрээнд Эрдэнэс тавантолгой ХК-аас гаргуулахаар шийдвэрлэсний дагуу Эрдэнэс тавантолгой ХК-тай 2022 оны А/190 дугаар санхүүжилтийн гэрээг байгуулан 3,412.3 сая төгрөгийг хүлээн авч, авто замын засварын ажилд бүрэн зарцуулсан;

СН

2. Засгийн газрын 2022 оны 238 дугаар "Агаарын тээврийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолоор МИАТ ТӨХК-ийн цар тахлын үед нэмэлтээр хийсэн нислэгийн татаас, санхүүжилтийн 4,780.0 сая төгрөгийг тус компанийн 2022 оны 01/1114 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Монгол Улсын Хөгжлийн банкны зээл, зээлийн хүүгийн төлбөрт шилжүүлсэн;
3. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас "Сургуулийн насны хүүхдийн замын хөдөлгөөнд оролцох мэдлэг, хандлагыг сайжруулах сургагч багш бэлтгэх" төслийн санхүүжилтэд 61.3 сая төгрөгийг хүлээн авч, зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэлд Авто замын сангийн санхүүжилтээр 2018 онд Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төвийн хэсэгчилсэн 2.4 км хатуу хучилттай авто замын барилгын ажил гүйцэтгэх гэрээт ажлын үлдэгдлийн 226.6 сая төгрөг байршиж байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3 Тухайн жилийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд 278,071.4 сая төгрөгийг төлөвлөж баталснаас, гүйцэтгэлээр 266,681.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

ЗТХЯ-ны хөрөнгө оруулалтаар 137 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд яамны хөрөнгө оруулалтад 135,238.4 сая төгрөгийг, улсын авто зам засвар, арчлалтын ажилд 50,710.6 сая төгрөгийг зарцуулж, 80,732.9 сая төгрөгийн 68 арга хэмжээг холбогдох бусад байгууллагуудад эрх шилжүүлсэн ба гүйцэтгэл 92.5 хувьтай байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 134,538.4 сая төгрөгийн 135 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер сонгон шалгаруулалтын журмаар, шинээр баригдах авто замын зураг төсвийн 700.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмаар тус тус зохион байгуулжээ.

Аудитын илрүүлэлт:

- МИАТ ТӨХК шинэ нисэх буудал дахь Ангарын оффиссын барилга бариулах 4,309.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендерт техникийн тодорхойлолт, баримт бичгийн шаардлага хангаагүй, ижил төстэй ажлын туршлагагүй, үндсэн тоног төхөөрөмж, машин механизмгүй, ажиллах хүн хүчний нөөцгүй Далу ХХК-ийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан, гүйцэтгэлийг үнэлэлгүйгээр 409.4 сая төгрөгийн урьдчилгаа олгосон байна. Энэ нь тус компанид үр ашиггүй байдлыг бий болгож, үргүй зардал гарах нөхцлийг бүрдүүлсэн;
- Зам тээврийн хөгжлийн яам Эрдэнэс таван толгой ХК-аас санхүүжүүлсэн Мандалговиос Даланзадгадын чиглэлийн 305.1 км замын сэргээн засах 3,412.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нэмэлт ажлыг шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн;
- Дорноговь АЗЗА ТӨХК худалдан авалтын төлөвлөгөөг бодитой, үндэслэлтэй батлуулаагүй, тендерийн материалыг баримтжуулан хавтаст хэрэг бүрдүүлээгүй, батлагдсан худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй сэлбэг, шатахуун, асфальт, битум, тэмдэг, тэмдэглэгээ, техник түрээс зэрэг 524.8 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээг 14 компани, 1 иргэнтэй шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн;
- Говь-Алтай аймаг дахь нисэх буудал шатахуун худалдан авах 45.3 сая төгрөгийн тендерийг харьцуулалтын аргаар 2 удаа цахимаар зарласан боловч "санал ирүүлсэн оролцогч байхгүй" шалтгаанаар шууд гэрээ байгуулсан;
- Орхон АЗЗА ТӨХК 672.7 сая төгрөгийн 35 ажилд гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй төлбөрийг олгосон, 24 иргэнтэй байгуулсан гэрээнд техникийн тодорхойлолт хавсаргаагүй, харьцуулалт хийгээгүй шууд гэрээ байгуулсан;
- Бараа, ажил, үйлчилгээний худалдан авах тендерийн баримт бичигт "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл", Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, дүгнэлтэд зарим гишүүд гарын үсэг зураагүй, тендер шалгаруулалтын хавтаст хэрэгт гэрээ дүгнэсэн актыг хавсаргаагүй;
- Улсын авто замын сан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар түлхүүр гардуулах нөхцөлтэй "Төлбөр авах цэг барих" ажлыг хугацаандаа гүйцэтгээгүйгээс төлбөр хураах цэгийн орлого 9-24 сараар тасалдсан байна. Мөн барилгын ажлыг гүйцэтгэх гэрээнд гүйцэтгэгч тал нь барилгын чанар, ажлын технологийн алдаанаас үүдэн гарсан эвдрэл, гэмтлийг өөрийн хөрөнгөөр 3 жил засварлахаар тогтоох ёстой байсан боловч ашиглалтын хугацааг 1 жилээр тооцсон;

- ЗТХЯ төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэлгүй 50.7 сая төгрөгийн өртөгтэй техник тоног төхөөрөмж худалдан авсан;
- ЗТХЯ нэмэлтээр гүйцэтгүүлсэн автозамын засварын ажилд 1 жилийн баталгаат хугацаа тогтоосон боловч гүйцэтгэлийн баталгааг гаргуулаагүй санхүүжилтийг 100.0 хувь тооцож, 170.6 сая төгрөгийг олгосон.

3.5.4 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар баталсан тус төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 онд хэрэгжүүлэх 6 хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд 19 арга хэмжээний зорилтот түвшнийг тусгажээ. Хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүн нь зорилтот түвшиндээ хүрээгүй 3 арга хэмжээг тодруулбал:

- а) Лабораторийн туршилт, шинжилгээний дүгнэлт хийх,
- б) Олон улсын нислэгийн тоо төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй,
- в) Батлагдсан хуваарийн дагуу төвлөрүүлэх навигацийн орлого тасарсан зэрэг нь тус тус гадаад хүчин зүйлсээс шалтгаалжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төрийн өмчийн хөрөнгийн үр ашгийг сайжруулах, мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор О.Баярмаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Энхжавхлан, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2023 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 03/1499 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнгээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 821,279.6 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,212.8 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор энэ хуулийн хүрээнд харьяа байгууллагын дэд дарга, орлогчийн орон тоо хэмнэж 130.3 сая төгрөг, цалин нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 61.7 сая төгрөг, түрээсийн зардал 484.5 сая төгрөг, шатахууны зардал 771.1 сая төгрөг, томилолтын зардал 6.2 сая төгрөг, бичиг хэргийн зардал 3.2 сая төгрөг, шуудан холбооны зардал 6.6 сая төгрөг, удирдлагын зардал 204.6 сая төгрөг, гэрэл цахилгаан 7.0 сая төгрөг, нийт 1,675.2 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд гүйцэтгэсэн аудитын горим сорилын үр дүнд илрүүлсэн зөрчлийг хавсралтаар оруулав.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн аудитын асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд Төсвийн ерөнхийлөн захирагчийн мэдээлбэл зохих 10347 мэдээллээс 239 мэдээллийг хугацаа хоцроож, 10108 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудлаар 5,716.7 сая төгрөгийн 26 зөрчил илэрснээс 3,985.9 сая төгрөгийн 11 албан шаардлага хүргүүлж, 1,730.8 сая төгрөгийн 15 зөвлөмж өгсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 2 орлогын гүйлгээг хугацаа хоцроож, 1,111.6 сая төгрөгийн 1 орлогын гүйлгээг мэдээлээгүй,
- Төлбөр хураах цэг цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлогын 110.4 сая төгрөгийн 8 гүйлгээ, 697.4 сая төгрөгийн 14 зарлагын гүйлгээг мэдээлээгүй,
- Булган АЗЗА ТӨХК өмнөх оны аудитаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэхээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй,
- Завхан АЗЗА ТӨХК шилэн дансны цахим хуудаст 287.8 сая төгрөгийн 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан,
- Хэнтий аймгийн "Харгуй" ТӨХК худалдан авах ажиллагааны тендерийн 245.1 сая төгрөгийн мэдээллийг дутуу мэдээлсэн,
- Увс АЗЗА ТӨХК "шилэн дансны цахим хуудаст 239.1 сая төгрөгийн 2 тендер, худалдан авах ажиллагааны мэдээллийг байршуулаагүй,
- Говь-Алтай аймаг дахь Нисэх буудал шилэн дансны цахим хуудаст 203.1 сая төгрөгийн гүйлгээг дутуу мэдээлсэн,
- Төв АЗЗА ТӨХК Шилэн дансны цахим хуудаст 15 мэдээлэл хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 58.3 сая төгрөгийн орлогын гүйлгээг дутуу мэдээлсэн, бусад 70.4 сая төгрөгийн орлогын, 45.1 сая төгрөгийн зарлагын 2, 6.1 сая төгрөгийн хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг байршуулаагүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Төрийн өмчийн хөрөнгийн үр ашгийг сайжруулахтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Авто-Импэкс ХК-ийн 51.0 хувийг төр эзэмшдэг боловч ТӨБЗГ-аас зорилтот түвшнийг батлаагүй, төрийн өмчид тавих хяналт хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.5 өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах; 14.2.10 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 54 дүгээр зүйлийн 54.2 "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тус хувьцаат компанийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, төрийн өмчийн хөрөнгийн үр ашгийг сайжруулах арга хэмжээг авч ажиллах зөвлөмж өгөх.

Аудитын илрүүлэлт:

- Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 2 орлогын гүйлгээг хугацаа хоцроож, 1,111.6 сая төгрөгийн 1 орлогын гүйлгээг мэдээлээгүй,
- ИНҮТ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т заасны дагуу Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын ангилалд хамрагдаж байгаа ч тусдаа санхүүгийн тайлан гаргадаг үйлдвэрлэл үйлчилгээний 9, орон нутгийн 15, нийт 24 нэгжийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан ижил цаглабарт хугацаанд нэгэн зэрэг нэгтгэж тайлагнаж байгаа нь цаг хугацааны давхцал үүсгэж, аудитын хяналтын эрсдэл үүсгэх нөхцөл бүрдүүлж байгаа;
- Харьяа байгууллагаас салбарын гэрчилгээ, томилогдсон удирдлага, хүний нөөц бүхий 4, томилогдсон удирдлагагүй 1, нийт 5 байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг ИНҮТ-ийн дарга болон ерөнхий нягтлан бодогч нар давхар эрхэлж, санхүүгийн тайланд гарын үсэг зурж баталгаажуулж байна;

64

- Далайн захиргаа ТӨҮГ төсвөөс санхүүжилт авдаггүй, төрийн өмчид тулгуурлан үйл ажиллагаа явуулж, баталсан төсвийн дагуу төсөвт орлого төвлөрүүлдэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15.2 "Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр, өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж, бие даан иргэний гүйлгээнд оролцдог" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статуст нийцэж байх боловч Улсын бүртгэлийн гэрчилгээнд "төрийн байгууллага, албан газар" гэж бүртгүүлсэн;
- МТЗ ТӨХК нь холбогдох хууль тогтоомжийг зөрчин хамтран ажиллах гэрээгээр Монголиан Порт групп ХХК-ийг үүсгэн байгуулж, нийт 1.7 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг Монголиа уул уурхайн үйлдвэрийн хөрөнгийн менежмент ХХК оруулсан боловч 51.0 хувийг МТЗ ТӨХК оруулсан гэсэн бичиг баримт үйлдсэн;
- Мөн Монголиан Порт Групп ХХК-ийн үйл ажиллагаа нь тодорхой бус, Засгийн газрын тогтоолын болон гэрээний хэрэгжилтийг тайлагнах, түүнд хяналт тавих ажил хийгдээгүй, цаашид гарах үр ашиг тодорхойгүй;
- Иргэний нисэхийн үндэсний төвийн бүтэц, орон тоонд 2020 онд 4, 2021 онд 6, 2022 онд 3 удаа сүүлийн 3 жилийн дотор нийт 13 удаа өөрчлөлт оруулсан байна. Бүтцэд орсон өөрчлөлтөөр санхүүгийн тайлан гаргадаг салбарын тоо өссөнөөс, харьяа 24 нэгжийн хөрөнгийн хөдөлгөөн, санхүүжилт, хоорондын тооцоо нэмэгдэж, санхүү бүртгэлийн ажлын ачаалал өсөх, ажил гүйлгээ давхар бүртгэгдэх нөхцөл бүрдсэн;
- ИНҮТ бүтэц, орон тооны өөрчлөлт нь хүний нөөцийн тогтворгүй байдлыг бий болгож, 2016-2021 оны хооронд ажлаас үндэслэлгүй халагдсан 37 иргэнд 823.3 сая төгрөг, 2022 онд 25 иргэнд 327.8 сая төгрөгийн ажилгүй байх хугацааны цалинг олгох тухай шүүхийн шийдвэр гарснаас, 6 иргэнд 215.4 сая төгрөгийг олгосон ба ИНЕГ-ын харьяалах албадаас 259.0 сая төгрөгийн зардлыг төлж барагдуулах тухай мэдүүлгийг шийдвэр гаргасан этгээдэд хүргүүлсэн боловч 8.9 сая төгрөгийн зардлыг буруутай албан тушаалтнаар төлүүлсэн;
- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны "Бүтэц шинэчлэн батлах тухай" 387 дугаар тушаалаар Иргэний нисэхийн үндэсний төвийн үйл ажиллагаа, чиг үүргийг шинэчлэн зохион байгуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5-д заасантай нийцэхгүй;
- Төрийн 100.0 хувийн хөрөнгийг ашиглан үйл ажиллагаа явуулж буй Нью Улаанбаатар интернейшнл эйрпорт ХХК-ийн 49.0 хувийг Монгол Улсын Засгийн газрын эрх бүхий этгээд эзэмшдэг байтал жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийг концессын гэрээг үндэслэн тус компанийн ТУЗ-өөс сонгон шалгаруулж аудит хийлгэж байгаа зэрэг зөрчлүүд илэрсэн.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 8,797.3 сая төгрөгийн 188 алдаа, зөрчил илрүүлснээс 678.0 сая төгрөгийн зөрчилд 28 төлбөрийн акт тогтоож, 3,526.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 63 албан шаардлага хүргүүлж, 2,430.8 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 92 зөвлөмж өгч, зөрчлийг давтан гаргасан 2,162.2 сая төгрөгийн 5 зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага өгснөөс, 27 төлбөрийн акт, 59 албан шаардлага, 91 зөвлөмж, 5 хариуцлага тооцох албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж, биелэлт 87.6 хувьтай байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	28	678.0	27	564.4	83.2
Албан шаардлага	63	3,526.3	59	3,018.7	85.6
Зөвлөмж	92	2,430.8	91	1,982.1	81.5
Хариуцлага тооцох	5	2,162.2	5	2,162.2	100.0
Нийт дүн	188	8,797.3	182	7,726.4	87.6

Өмнөх оны акт, албан шаардлагын хэрэгжилтийг шалгахад дараах төлбөрийн акт, албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.Үүнд:

- Иргэний нисэхийн ерөнхий газар: Төрд учруулсан хохирлыг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх 113.6 сая төгрөгийн 2 төлбөрийн актыг барагдуулаагүй, гадаадад суралцагчдын болон барилга угсралтын ажлын гэрээний үүргийн биелэлт, хөрөнгийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлэх, авлага барагдуулах зэрэгтэй холбоотой албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй;

- МИАТ ТӨХК: Өмнөх оны аудитаар агаарын хөлгийн 2 дугаар нисгэгчээр ажиллаж байсан ажилтны ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ Берлин хотын "Adina" зочид буудалд учруулсан 139.6 сая төгрөгийн авлага, МИАТ ТӨХК-ийн агаарын тээврийн зорчигчийн тийз борлуулалтын үйл ажиллагаа эрхлэн явуулах борлуулагч Зэт хорин дөрөв ХХК нь агентын гэрээний үүргийг биелүүлээгүйгээс тийз борлуулалтын орлогоос шамшигдуулсан 993.2 сая төгрөгийн авлагыг барагдуулах албан шаардлагын хэрэгжилт ажил хангалтгүй;
- Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ: харьяа 28 салбарын санхүүгийн тайланг бэлтгэж гаргах тухай УАГ-ын 2022 оны 455/АО160067 дугаар албан шаардлагаар сахилгын хариуцлагыг оногдуулсан боловч, зөрчлийг давтан гаргасан;
- Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ: Драгон холдинг ХХК-тай 2016 онд байгуулсан ХХАГ16/020 дугаар гэрээний дагуу хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд байршуулсан албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй, уг хөрөнгийг Драгон холдинг ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээнээс хасаж төрийн өмчид бүртгэх тухай 2022 оны 1/1444 дугаар хүсэлтийг ТӨБЗГ-т хүргүүлсэн боловч хариу ирээгүй;
- Авто тээврийн үндэсний төв: Урьдчилгаа дансны үлдэгдэлд өмнөх болон тайлант онд хэрэгжиж дууссан зураг төслийн 4 ажлын нийт 91.0 сая төгрөг бүртгэлтэй байна. Зураг төслийн ажил хийгдэж дууссан боловч барилгын ажил эхлээгүй, ТӨБЗГ-т асуудлыг шийдэх талаар хүсэлт явуулаагүй;
- Завхан АЗЗА ТӨХК: Авлагын 175.2 сая төгрөгийн үлдэгдлийг барагдуулах албан шаардлага хүргүүлснээс 57.6 сая төгрөгийн авлагыг барагдуулж, үлдэгдэл 117.5 сая төгрөгийн авлага шүүхийн шатанд байгаа, мөн 2021 онд 250.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан ба алдагдлыг бууруулах албан шаардлага өгсөн боловч үйл ажиллагаа явуулахад шаардлагатай түүхий эд материалын үнийн өсөлт нөлөөлж хэрэгжилт хангалтгүй байгаа;
- Хөвсгөл АЗЗА ТӨХК: Урт хугацаат өр төлбөрөөр тайлагнасан 448.7 сая төгрөгийг Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын 2009 оны 284 дүгээр тогтоолоор Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны урт хугацааны хөнгөлөлттэй зээлийн хүрээнд өр төлбөрийг барагдуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. ЗТХЯ-ны хөрөнгө оруулалтын төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт, төлөвлөгөө, гүйцэтгэлийг цаг хугацааны хязгаарлагдмал нөхцөл байдал, хамрах хүрээнээс шалтгаалан төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлээгүй тул дараагийн аудитаар авч үзэх;

2. Иргэний нисэхийн салбарын хэмжээний төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт, гүйцэтгэлийг Иргэний нисэхийн үндэсний төвд зохион байгуулан ажилладаг бөгөөд ИНЕГ-т аудитыг хийж гүйцэтгэсэн цаг хугацааны хязгаарлагдмал нөхцөл байдал, хамрах хүрээнээс шалтгаалан дараагийн аудитаар худалдан авах ажиллагааг авч үзэх шаардлагатай гэж үзлээ.



5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар харьяа байгууллагуудын санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 85,252.2 сая төгрөгийн 82 алдаа¹ илэрснээс 84,694.7 сая төгрөгийн 73 алдааг аудитын явцад залруулж, 557.5 сая төгрөгийн 9 алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Аудитаар нийт 142,972.5 сая төгрөгийн 268 зөрчил² илэрснээс, 196.1 сая төгрөгийн зөрчилд 42 төлбөрийн акт тогтоож, 138,510.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 94 албан шаардлага хүргүүлж, 4,106.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 124 зөвлөмж өгч, эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцуулах 6 албан шаардлага хүргүүлж, 160.0 сая төгрөгийн 2 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Аудитаар илэрсэн 142,972.5 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 8,212.8 сая төгрөгөөс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

Харьяа байгууллагууд

Харьяа байгууллагуудад нийт 142,972.5 сая төгрөгийн 265 алдаа, зөрчил илрүүлснээс 196.1 сая төгрөгийн 42 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 138,510.3 сая төгрөгийн 92 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 4,106.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 124 зөвлөмж өгч, эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцуулах 5 албан шаардлага хүргүүлж, 160.0 сая төгрөгийн 2 асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 1 төсвийн төвлөрүүлэн захирагчийн, 28 төрийн өмчит аж ахуйн нэгжийн, 3 төсвийн шууд захирагчийн, 1 засгийн газрын тусгай сангийн, нийт 33 санхүүгийн тайланг нэгтгэснээс Авто-Импэкс ХК, хөрөнгө оруулалт, их засварын санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан эрхлэх асуудлын хүрээний 31 байгууллагад дүгнэлт гаргаснаас 12 байгууллагад "хязгаарлалттай" дүгнэлт өгсөн байна. Үүнд:

1. Иргэний нисэхийн ерөнхий газар,
2. Иргэний нисэхийн үндэсний төв,
3. Монголын төмөр зам ТӨХК,
4. Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ,
5. Далайн захиргаа ТӨҮГ,
6. Булган АЗЗА ТӨХК,
7. Говь-алтай АЗЗА ТӨХК,
8. Орхон АЗЗА ТӨХК,
9. Увс АЗЗА ТӨХК,
10. Эрдэнэсант АЗЗА ТӨХК,
11. Зам, тээврийн хөгжлийн яам ТШЗ,
12. Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв.

Төсвийн ерөнхийлөн захирагч

5.1 Төлбөрийн акт

1. Орлогын үлдэгдлийг төвлөрүүлэхтэй холбоотой асуудал /Улсын Авто замын сан/

Улсын Авто замын сангийн орлогын 23.8 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 "Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээсийн орлого,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

торгуулийн орлого, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төвлөрүүлээгүй орлогын үлдэгдлийг улсын төсөвт нөхөн төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Өөрийн эзэмшлийн газрыг бүртгэлд тусгах, түрээсийн төлбөртэй холбоотой асуудал

а) Авто-Импэкс ХК-ийн Сонгинохайрхан дүүрэгт байрлах 054497 дугаар бүртгэлтэй, 8028/0056 дугаар нэгж талбарын 41972 м.кв контор, аж ахуйн зориулалттай өөрийн эзэмшлийн газрыг данс бүртгэлд тусгаагүй,

б) Авто-Импэкс ХК нь агуулахын зориулалтаар Жем интернейшнл ХХК-д 4100 м.кв талбайтай объектыг 1 м.кв талбайг 1,800.00 төгрөгөөр тооцож, сарын нийт 7.4 сая төгрөгөөр түрээслүүлсэн, 2016 оноос хойш түрээсийн гэрээг сунгаагүй, мөн эрх бүхий байгууллагаас тогтоосон жишгийг мөрдөөгүй байна.

- Төмөр зам, далай ашиглалт болон усан замын тээврийн салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Иргэний нисэхийн салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Зам, тээврийн салбарын хөгжлийн нэгдсэн болон хүний нөөцийн бодлого, төсөл, хөтөлбөр боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих, салбар хоорондын уялдаа холбоог хангах, үйл ажиллагааг зохицуулах, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, салбарын стандарт, норм, норматив, техник, технологи, судалгаа шинжилгээг хөгжүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого, хөтөлбөр боловсруулах;
- Зам, тээврийн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх;
- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх.

Улсын Их Хурлын 2022 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх 4 зорилго, 24 арга хэмжээний хэрэгжилт 72.5 хувьтай байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-д Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 4 зорилтын 43 төсөл, арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө гарган ажиллаж, биелэлтийг 60.0 хувиар дүгнэсэн байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газар хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар холбохыг нэн тэргүүнд чухалчилж, тээвэр логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд онцгой анхааран ажилласны үр дүнд Монгол Улс 2023 онд Дэлхийн банкнаас гаргасан логистикийн индексээр 30 байраар урагшилж 97 дугаар байрт орсон;

- Бүх төрлийн тээврээр 2023 онд нийт 107.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 76.6 хувиар өссөн байна. Үүнээс авто тээврийн ачаа 71.3 сая тонн болж өмнөх оноос 2.1 дахин, төмөр замын тээврийн ачаа 36.1 сая тонн болж өмнөх оноос 30.3 хувиар тус тус өссөн;
- Хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, ачаа тээврийн терминалуудыг байгуулах хүрээнд Гашуунсухайт боомтод жилд 10 сая.тн нүүрс шилжүүлэн ачих хүчин чадалтай чингэлэг тээврийн терминал ашиглалтад орсон. Мөн тус боомтод жолоочгүй автомат удирдлага бүхий AGV тээврийг нэвтрүүлж, өдөрт 80 гаруй чингэлэг ачааг экспортод гаргаж байна;
- Цар тахлын үетэй харьцуулахад бүх төрлийн тээврийн зардал 8-20 дахин буурсан;
- Монгол Улс дэлхийн 42 улстай агаарын харилцааны хэлэлцээртэй болж, дэлхийн 115 цэгт шууд нислэг үйлдэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсэн байна. Мөн Ерөнхий сайдын АНУ-д хийсэн айлчлалын үеэр OPEN SKY хэлэлцээрт гарын үсэг зурснаар Монгол Улс АНУ-ын хооронд шууд нислэгтэй болох асуудал шийдэгдсэн;
- БНСУ-тай агаарын харилцаа хэлэлцээр хийж, Монгол Солонгосын хооронд 7 хоногт нийт 70 нислэг буюу өдөрт дунджаар 10 нислэг үйлдэх эрх зүйн боломжийг бүрдүүлж, аялал жуулчлалын оргил ачааллын үед өдөртөө 12 хүртэлх нислэг хийгдсэн байна. Монгол Японы хооронд 7 хоногт 61, Монгол Туркийн хооронд 7 хоногт 28 нислэг үйлдэх эрх зүйн боломжийг бүрдүүлж, агаарын харилцааны хэлэлцээрийг тус тус шинэчилсэн нь зорчигч урсгалыг нэмэгдүүлж, аялал жуулчлал, худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэхэд бодит үр дүнгээ өгсөн байна. 2024 онд үндэсний агаарын тээвэрлэгч МИАТ компани дэлхийн хамгийн сүүлийн үеийн технологиор бүтээгдсэн Бойнг 787-9 агаарын хөлөг хүлээн авч нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж эхэлснээр Монголоос дэлхийн аль ч цэг рүү шууд нисэх боломж бүрдсэн;
- Орон нутгийн 8 чиглэлд нислэг сэргээж, онгоцны тийгийг 2-оос 2.5 дахин хямдруулсан. МИАТ ТӨХК-ийг 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс орон нутгийн 9 чиглэлд зохих нөхөн олговортойгоор нислэг үйлдүүлэхээр шийдвэрлэсэн. Энэ дагуу МИАТ ТӨХК нь Өлгий, Ховд, Улиастай, Улаангом, Алтай, Мөрөн, Чойбалсан, Даланзадгад чиглэлд амжилттай нислэг үйлдсэн байна;
- Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 1820 км төмөр зам барихаар төлөвлөснөөс одоогийн байдлаар 960 км төмөр замын барилгын ажлыг бүрэн дуусгасан байна. Үлдсэн 860 км төмөр замын төслийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх ажил хийгдэж байна.

“Шинэ сэргэлтийн бодлого”-д Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 4 зорилт 43 төсөл, арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө гаргаснаас хэрэгжсэн ажлуудын үр дүн, онцлох дараах байдалтай байна. Үүнд:

- “Шинэ сэргэлтийн бодлого”, үндэсний төмөр замын сүлжээг өргөжүүлэх хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 233 км, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 415 км, нийт 648 км төмөр замыг байнгын ашиглалтад оруулсан байна;
- Мөн Шинэ сэргэлтийн бодлогын боомтын сэргэлтийн хүрээнд Монгол-БНХАУ хоорондын хилийн Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхэ, Бичигт-Зүүнхатавч төмөр замын боомтуудыг холбох хил дамнасан төмөр замын төслүүдийг эхлүүлсэн байна;
- Шинэ сэргэлтийн таван цагираг хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд бүх аймгийн төвийг хооронд нь авто замаар холбох, урд хойд хөрш, Ази Европыг холбосон авто замын босоо таван коридортой болох ажлыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаагаас тус хөтөлбөрийн хүрээнд Бага илэнх-Шивээхүрэн, Бургастай-Арцсуурь, Эрээнцав-Бичигт гэсэн авто замын 3 шинэ коридорыг нэмж байгуулах, хэвтээ чиглэлд Цагааннуур-

Сүмбэр, Цагааннуур-Ульхан боомтыг хөндлөн холбосон хэвтээ чиглэлийн 2 коридортой болохоор бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж, бодлого, чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга;
- Төмөр замын тээврийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт;
- Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоол “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай”;
- Засгийн газрын 2023 оны “Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэх батлах тухай” 80 дугаар тогтоол.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд санхүү төсөв, нягтлан бодох бүртгэлд тавих дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

Зам, тээврийн хөгжлийн яамны хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар салбарын бодлого хөтөлбөр, хууль тогтоомж, төлөвлөгөө, олон улсын гэрээ хэлэлцээрийн биелэлтэд хяналт шинжилгээ хийх, салбарын төсвийн орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж, санхүүгийн үйл ажиллагааг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2023 оны Б/55 дугаар тушаалаар Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь 12 орон тоотойгоор батлагдсан байна. Тайлант онд харьяа 8 байгууллагад санхүү болон шилэн дансны үйл ажиллагаанд дотоод аудит хийж, илрүүлсэн алдаа, зөрчлийг арилгах 32.8 сая төгрөгийн 4 албан шаардлага, 13 зөвлөмж өгсөн бөгөөд хэрэгжилт 87.0 хувьтай байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 58,506.0 сая төгрөгөөр буюу 0.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	157,843.9	197,608.0	39,764.1
Авлага	144,434.3	259,239.1	114,804.8
Урьдчилгаа	105,674.4	57,556.6	(48,117.8)
Бараа материал	119,565.6	89,173.9	(30,391.7)
Нөөцийн бараа	0.8	0.8	-
Бусад эргэлтийн хөрөнгө	664,260.9	962,301.4	298,040.5
Үндсэн хөрөнгө	6,817,221.0	6,501,628.9	(315,592.1)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	742,418.9	742,417.1	(1.8)
Нийт хөрөнгө	8,751,419.8	8,809,925.8	58,506.0
Өр төлбөр	2,226,000.6	2,492,297.6	266,297.0
Засгийн газрын хувь оролцоо	6,525,419.2	6,317,628.2	(207,791.0)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,751,419.8	8,809,925.8	58,506.0

Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бусад эргэлтийн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий материаллаг өөрчлөлт гарсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 197,608.0 сая төгрөг болж, 39,764.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	201.8	454.3	252.5
Банканд байгаа бэлэн мөнгө	157,610.4	197,152.6	39,542.2
Замд яваа мөнгөн хөрөнгө	31.7	1.1	(30.6)
Дүн	157,843.9	197,608.0	39,764.1

Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд 32 байгууллагын арилжааны банканд 151,255.7 сая төгрөг, төрийн санд хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд 45,896.9 сая төгрөг, кассад бэлнээр 22 байгууллагын 454.3 сая төгрөг байна.


Үүнээс ИНЕГ-ын 2,661.9 сая төгрөгийн үлдэгдэл нь Чингис хаан банк төлбөрийн чадваргүй болсноос өнөөг хүртэл барагдаагүй байна.

Замд яваа мөнгөн хөрөнгөнд Улсын Авто замын сан, Иргэний нисэхийн ерөнхий газрын 1.1 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 39,764.1 сая төгрөгөөр өсөхөд Эрдэнэс Тавантолгой ХК-иас Монголын төмөр зам ТӨХК-д олгосон төмөр замын төслийн санхүүжилтээс гүйцэтгэгч нарт он дамжуулан олгох 24,000.0 сая төгрөгийн үлдэгдэл голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Харьяа 11 байгууллагад анхан шатны бүрдэл дутуу баримтаар нийт 79.0 сая төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан, /Архангай АЗЗА ТӨХК 9.3 сая төгрөг, Шивээ хүрэн төмөр зам ХХК 18.3 сая төгрөг, Булган АЗЗА ТӨХК 24.1 сая төгрөг, ИНЕГ 18.0 сая төгрөг, Иргэний нисэхийн үндэсний төв-Улаанбаатар хот дахь харьяа байгууллагууд 9.3 сая төгрөг/;



Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Авто тээврийн үндэсний төв тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дуудлага худалдаанаас 6,604.9 сая төгрөгийн орлого олж, Хүүхдийн төлөө санд 5,943.5 сая төгрөгийг төвлөрүүлэхээс 4,971.8 сая төгрөгийг төвлөрүүлж, 971.8 сая төгрөгийг тайланд онд багтан төвлөрүүлээгүй, 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр төвлөрүүлсэн;
- Шивээ хүрэн төмөр зам ХХК нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж уулзалт, томилолтын зардлаас 0.8 сая төгрөгийг зарцуулсан, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 12 удаагийн 12.0 сая төгрөгийн гүйлгээ, нягтлан бодогчийн хувийн дансаар дамжуулан кассад гэсэн гүйлгээний утгатайгаар 6.3 сая төгрөг, нийт 18.3 сая төгрөгийн зарцуулалт хийсэн байна.

3.4.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 259,239.1 сая төгрөг болж, 114,804.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	11.5	25.6	14.1
Төлбөртэй үйлчилгээний авлага	24,414.9	28,615.2	4,200.3
Татаас, санхүүжилтийн авлага	-	5,650.5	5,650.5
Зээлийн хүүгийн авлага	23.8	-	(23.8)
Дансны авлага /ТӨҮГ/	44,860.0	74,255.4	29,395.4
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	53,097.0	62,887.6	9,790.6
Бусад авлага	22,027.1	87,804.8	65,777.7
Дүн	144,434.3	259,239.1	114,804.8

Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Авлагын дансны өсөлтөд дараах өөрчлөлтүүд голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Монголын төмөр зам ТӨХК нь төмөр замын төсөлтэй холбоотой Зэвсэгт хүчний Жанжин штабт 2019 онд олгосон 67,119.0 сая төгрөгийг урьдчилгаа дансанд бүртгэлтэй байсныг авлагаар бүртгэсэн, Монголиан транс ллайн ХХК-аас авах тарифын зөрүү 15,723.3 сая төгрөг төлөгдөөгүй, мөн бусад 1 жилээс дээш насжилттай урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэлтэй 371.1 сая төгрөгийг авлагын дансанд тус тус шилжүүлэн бүртгэсэн,
- МИАТ ТӨХК Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК-ийн үйлчилгээний орлогоос НӨАТ тооцож 11,671.5 сая төгрөг авлага бүртгэсэн, арилжааны банкуудад байршуулсан хадгаламжийн хүүгийн авлага 516.5 сая төгрөг, хэрэгжээгүй НӨАТ-ын авлага данс 222.2 сая төгрөг, бусад авлага данс АТҮТ-д шилжүүлсэн газрын үнийн 400.9 сая төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлсөн
- ЗТХЯ нь авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ (RFID tag)-ний загвар боловсруулах, тээврийн хэрэгсэлд ашиглах цогц ажлын санхүүжилтийн үлдэгдэл 5,650.5 сая төгрөг татан төвлөрүүлснийг Сангийн яамнаас авах санхүүжилтийн авлагаар тооцоо нийлж бүртгэсэн;
- Өнгөрөлтийн нислэг 2022 оны мөн үетэй харьцуулахад 94.0 хувиар өсөж ИНЕГ-ын төлбөртэй үйлчилгээний авлага 4,200.3 сая төгрөгөөр нэмэгдсэн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- Авто тээврийн үндэсний төв 2016 онд үүссэн 2 хувь хүнээс авах 7 жилийн насжилттай 15.4 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн, он дамжсан авлагатай, Татварын авлага, өр төлбөрийн тооцоог хянаж, тайлант үе бүрийн эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- МИАТ ТӨХК авлагын дансанд бүртгэлтэй 1,446.3 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, олон жилийн насжилттай 12 харилцагчийн 79.0 сая төгрөгийн авлагыг хуулийн байгууллагад шилжүүлээгүй, хэрэгжээгүй НӨАТ-ын авлага дансанд 2017-2022 онуудад үүссэн 673.2 сая төгрөгийн авлагыг тухай бүр тооцоолж тайлагнаагүй, үүссэн зөрүүг бэлтгэн нийлүүлэгч харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, НӨАТ-ын авлага данснаас тохируулж бүртгэсэн 406.6 сая төгрөгийн тооцооллын задаргаа тайлбарыг ирүүлээгүй;

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

30

- Монголын төмөр зам ТӨХК тайлант оны эцсийн байдлаар 39 харилцагчтай холбоотой 2,931.3 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулав.
- МИАТ ТӨХК авлагын дансны үлдэгдэлд олон жилийн насжилттай дампуурлаа зарлаж гэрчилгээ нь гарсан 2 харилцагчийн 3,173.7 сая төгрөг, дайны нөхцөлтэй байгаа орны 1 харилцагчийн 190.6 сая төгрөг, Ковидын үеийн нислэгийн зардал 2 харилцагчийн 415.7 сая төгрөг, нийт 3,780.0 сая төгрөгийг ТУЗ-д танилцуулан шийдвэрлүүлээгүй, шүүхийн шийдвэр гарсан 3 харилцагчийн 1,403.3 сая төгрөгийн авлагыг барагдуулах ажиллагаа удаашралтай;
- ИНЕГ гадаадын агаарын тээвэрлэгч нэр бүхий 10 компанийн 2001 оноос 2004 онуудад үүссэн 1,987.3 сая төгрөгийн олон жилийн насжилттай авлагыг барагдуулаагүй, найдваргүй болох эрсдэл үүссэн.
- Иргэний нисэхийн үндэсний төвийн 2005 оноос 2019 онуудад үүссэн 37 иргэн, хуулийн этгээдтэй холбогдох 810.4 сая төгрөгийн он удаан жил болсон авлагыг барагдуулаагүй.
- Авто импекс ХК нь тайлант онд түрээслэгч хувь хүн, хуулийн этгээдээс авах болон бусад авлагын 341.5 сая төгрөгийн үлдэгдлийг барагдуулаагүй.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны үлдэгдэл 57,556.6 сая төгрөг болж 48,117.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/ сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	105,674.4	57,556.6	(48,117.8)
Дүн	105,674.4	57,556.6	(48,117.8)

Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Урьдчилгаа дансны үлдэгдэлд дараах байгууллагуудын ажил гүйлгээ голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Монголын төмөр зам ТӨХК-аас Зэвсэгт хүчний Жанжин штабт 2019 оноос эхлэн олгосон 67,119.0 сая төгрөгийн төмөр замын төслийн санхүүжилтийг урьдчилж төлсөн төлбөрөөр бүртгэсэн байсныг аудитын зөвлөмжийн дагуу авлагаар залруулан бүртгэсэн, бусад 1 жилээс дээш насжилттай урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэлтэй 371.1 сая төгрөгийг авлагын дансанд тус тус шилжүүлэн бүртгэсэн;
- МИАТ ТӨХК нь гэрээний дагуу 18,900.0 сая төгрөгийн шатахууны, 2,700.0 сая төгрөгийн агаарын хөлгийн багаж, сэлбэг хэрэгслийн төлбөрийг урьдчилан шилжүүлсэн байна.

3.4.4 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 962,301.4 сая төгрөг болж, 298,040.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бусад санхүүгийн хөрөнгө /ТӨҮГ/	5,000.0	27,260.7	22,260.7
Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	659,224.4	935,004.2	275,779.8
БЗЭБуй эргэлтийн хөрөнгө	36.5	36.5	
Дүн	664,260.9	962,301.4	298,040.5

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 298,040.5 сая төгрөгөөр өссөн нь орон нутагт эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын болон гадаад, дотоодын төслийн эх үүсвэрээр гүйцэтгэсэн, ашиглагч байгууллагуудад шилжүүлэхээр хүлээгдэж буй 271,125.6 сая төгрөгийн авто замын барилгын ажлууд нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

ЗТХЯ хөрөнгө оруулалтын концессын гэрээгээр 183,608.6 сая төгрөгийн Төмөртэйн Хандгайт өртөөний 22.9 км төмөр зам, ачиж буулгах терминал, авто замын барилгыг Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 491 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2015 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 02/18/15 дугаар "Барилга байгууламжийг

ашиглалтад оруулах акт"-аар байнгын ашиглалтад оруулсан ч, шүүхийн маргаантай байгаа тул хөрөнгийн бүртгэл өнөөг хүртэл тодорхойгүй байна.

3.4.5 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл 742,417.1 сая төгрөг болж, 1.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Үнэт цаас	693,767.5	693,765.7	(1.8)
Урт хугацаат зээл	48,651.4	48,651.4	-
Дүн	742,418.9	742,417.1	(1.8)

Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Урт хугацаат хөрөнгө оруулалтын дансанд дараах үлдэгдлүүд бүртгэлтэй байна. Үүнд:

- Монголын төмөр зам ТӨХК-ийн Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн төмөр замын төсөлд оруулсан 693,765.7 сая төгрөгийн үнэт цаас;
- Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-д Засгийн газрын 2018 оны 175 дугаар тогтоолоор Монгол-Японы хамтарсан хуулийн этгээд Улаанбаатар хотын шинэ нисэх онгоцны буудлын менежмент төслийг хэрэгжүүлэх хоёр дахь ээлжийн хөрөнгө оруулалтын 48,407.4 сая төгрөг;
- Далайн захиргаа ТӨҮГ Засгийн газрын 2015 оны 180 дугаар тогтоолоор БНСУ-д бүртгэлтэй далайн тээврийн "Монгол-Саммок логистик" хамтарсан компани байгуулахад оруулсан 190.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт;
- Автоимпэкс ХК-ийн далайн тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Монгол Хятадын хамтарсан далайн тээвэр эрхлэх Тинжин хот дахь Эс Эм Эн ХХК-д оруулсан 53.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт тус тус бүртгэлтэй байна.

3.4.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны цэвэр үлдэгдэл 6,501,628.9 сая төгрөг болж, 315,592.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Газар	13,376.9	-	(13,376.9)
Барилга, байгууламж, орон сууц	1,274,421.0	1,229,031.7	(45,389.3)
Авто-тээврийн хэрэгсэл	124,825.7	114,656.6	(10,169.1)
Машин тоног төхөөрөмж(компьютер)	255,337.2	228,911.5	(26,425.7)
Тавилга, аж ахуйн эд хогшил	4,865.9	4,348.5	(517.4)
Зам, гүүрний байгууламж	3,012,686.7	2,549,189.8	(463,496.9)
Бусад үндсэн хөрөнгө	93,763.5	89,849.8	(3,913.7)
Дуусаагүй барилга, байгууламж	1,250,311.7	1,327,608.3	77,296.6
Биет бус хөрөнгө	739,958.8	926,113.9	186,155.1
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	47,673.6	31,918.8	(15,754.8)
Дүн	6,817,221.0	6,501,628.9	(315,592.1)

Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгийн цэвэр үлдэгдэл буурсан нь дараах өөрчлөлтүүдээс голлон шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн болон төрийн өмч хөрөнгөөр 9,577.4 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэн нийлүүлж, холбогдох байгууллагын шийдвэрээр 361,966.7 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлэн орлого авч, хандиваар өгсөн 8,740.1 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн авч, данс бүртгэлд тусгасан;

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Хөрөнгийн дахин үнэлгээ 586.9 сая төгрөгөөр нэмэгдэж, 1,082.9 сая төгрөгийн хорогдсон;
- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2,086.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох байгууллагын шийдвэрээр акталж, 57,843.5 сая төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлж, 63.9 сая төгрөгийн хөрөнгийг худалдан борлуулсан;
- Тайлант онд нийт 628,660.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсон байна.

Аудитын илрүүлэлт:

- МИАТ ТӨХК байгууллагын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй ачаа шуудангийн барилгыг 2008 онд ТӨХ-оос ИНЕГ-ын нэр дээр тогтоол гарган, барилгыг өмчлөгчид мэдэгдэлгүй буулгасан;
- МИАТ ТӨХК авто тээврийн үндэсний төвийн лавлагааны жагсаалтад тус компанийн үндсэн хөрөнгөнд бүртгэлгүй 10 ширхэг авто тээврийн хэрэгсэл байгаагаас 6 нь тус компанид өмнө нь бүртгэлгүй байсан;
- Хөвсгөл АЗЗА ТӨХК үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 3.0 сая төгрөгийн үнэтэй 1 ширхэг GPU төхөөрөмж, 20.2 сая төгрөгийн үнэтэй 1 ширхэг дизель генератор биетээр байхгүй;
- Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна /ЗТХЯ-ны 225 нэр төрлийн 729.0 сая төгрөг, Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах нэгдсэн төв 65 нэр төрлийн 169.2 сая төгрөг, ИНЕГ 207 нэр төрлийн 300.8 сая төгрөг, ИНҮТ 934 нэр төрлийн 5,130.7 сая төгрөг, Хөвсгөл нисэх буудал 13 нэр төрлийн 330.9 сая төгрөг, Улсын авто замын сан 34 нэр төрлийн 530.0 сая төгрөг/.

3.4.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны үлдэгдэл 2,492,297.6 сая төгрөг болж, 266,297.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Өр төлбөрийн үлдэгдэл

/ сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	350,528.8	414,711.0	64,182.2
Богино хугацаат зээлийн өглөг	46,221.8	38,205.0	8,016.8
Өглөг	222,463.6	290,286.2	(67,822.6)
Урьдчилж орсон орлого	81,843.4	86,219.9	4,376.5
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,875,471.8	2,077,586.5	202,114.7
Урт хугацаат үнэт цаас	1,273,405.3	1,336,123.2	62,717.9
Урт хугацаат зээл	602,066.5	741,463.3	139,396.8
Дүн	2,226,000.6	2,492,297.6	266,297.0

Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл


Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл өсөхөд Монголын төмөр зам ТӨХК-ийн НӨАТ болон үл хөдлөх хөрөнгийн татварын өр 48,943.2 сая төгрөгөөр, МИАТ ТӨХК-ийн богино хугацаат өр төлбөр, урьдчилж орсон орлого 40,625.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 2,077,586.5 сая төгрөг болж, 202,114.7 сая төгрөгөөр өссөн нь дараах ажил гүйлгээнээс шалтгаалсан байна. Тухайлбал:

- МИАТ ТӨХК-ийн урт хугацаат түрээсийн өр төлбөр 147,756.7 сая төгрөгөөр нэмэгдсэн;
- Монголын төмөр зам ТӨХК-ийн Эрдэнэс таван толгой ХК-д төлөх Таван толгой-Зүүн баян чиглэлийн төмөр зам барих төслийн тайлант оны санхүүжилт 52,430.0 сая төгрөгийг бүртгэсэн;
- Монголын төмөр зам ТӨХК-д Зүүнбаян төмөр зам ХХК-ийг нэгтгэсэнтэй холбоотойгоор 10,334.9 сая төгрөгийн өр төлбөр нэмэгдсэн байна.

Аудитын илрүүлэлт:

СНАГ-2024/08/НА-СТА-ТЕЗ



Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

- Монголын төмөр зам ТӨХК тайлант оны эцсийн байдлаар 39 харилцагчтай холбоотой 2,931.3 сая төгрөгийн авлага, 52 харилцагчтай холбоотой 6,791.2 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,
- Төв АЗЗА ТӨХК тайлант онд харилцагч 3 байгууллагад төлөх 36.4 сая төгрөгийн өглөгийг барагдуулаагүй,
- МИАТ ТӨХК Монгол Улс дахь нисэх буудлын үйлчилгээг үзүүлж буй Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт ХХК-тай МИАТ ТӨХК-ийн зүгээс хамтран ажиллаж байгаа ба тайлант хугацаанд нийт 8,468.5 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй, аудитын явцад ирүүлсэн тулган баталгаажуулалтын захидлаас харахад энэхүү үлдэгдэл нь харилцагч байгууллагын үлдэгдлээс 2,765.1 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн;
- ИНУТ татваруудын ногдлын үлдэгдлийг болон татварын тодорхойлолтоор зэрэгцүүлэн тулгахад зөрүүтэй, татварын системд татварын ногдлоо тулгаж баталгаажуулаагүй байна. Тайлант онд 386 татварын нэхэмжлэлийн 567.3 сая төгрөгийн үлдэгдлийг тооцоо нийлж залруулаагүй, татварын 32 нэхэмжлэлд ногдуулсан 35.0 сая төгрөгийн татварын орлогыг өглөгөөр тусган, татварын орлогын дансанд төвлөрүүлээгүй.

3.4.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 6,317,628.2 сая төгрөг болж, 207,791.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	2,274,874.8	2,288,684.4	13,809.6
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	93,245.9	93,809.1	563.2
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	-	0.5	0.5
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	32.6	32.6	0.0
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	806,317.7	805,231.2	(1,086.5)
Хуримтлагдсан үр дүн	1,071,110.2	867,043.9	(204,066.3)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,279,724.6	2,262,713.1	(17,011.5)
Хяналтын бус хувь оролцоо	113.4	113.4	0.0
Дүн	6,525,419.2	6,317,628.2	(207,791.0)

Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл буурсан нь дараах ажил гүйлгээтэй холбоотой байна. Үүнд:

- ЗТХЯ-ны хөрөнгө оруулалт их засварын хуримтлагдсан үр дүн 187,475.3 сая төгрөгөөр буурсан нь улсын төсвөөс 276,021.7 сая төгрөгийн хөрөнгийн санхүүжилт авч, 463,496.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэл тооцсон;
- Концессын гэрээний дагуу Нью Улаанбаатар интернейшнл эйрпорт ХХК-ийн ашиглаж, үйл ажиллагаа явуулж буй Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлын хөрөнгийг ТӨБЗГ-ын 2019 оны 382 дугаар тогтоолын дагуу ИНЕГ-т бүртгэдэг бөгөөд тайлант онд 1,255,754.3 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлд 66,391.7 сая төгрөгийн элэгдлийн зардал тооцсон, үл хөдлөх хөрөнгийн албан татварт 8,508.1 сая төгрөгийг төлсөн;
- Монголын төмөр зам ТӨХК-ийн 2017-2021 оны үйл ажиллагаанд Татварын ерөнхий газраас шалгалт орж 47,770.6 сая төгрөгийн акт алданги, торгуулийг төлж хуримтлагдсан үр дүнг бууруулсан, өмнөх үеийн үр дүнд 795.1 сая төгрөгийн залруулга хийсэн байна.

ТӨБЗГ-ын шийдвэрийн дагуу балансаас баланст хөрөнгө шилжүүлсэн, данс бүртгэлээс хассанаас шалтгаалан хөрөнгийн дахин үнэлгээ дансны үлдэгдэл ИНЕГ-т 12,055.1 сая төгрөгөөр, МИАТ ТӨХК-д 5,066.0 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгийг ирүүлэхээр заасан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд хамаарах тухайн жилийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийг нийт дүнгээр, хөтөлбөрөөр, төсвийн захирагчаар, хөрөнгө оруулалтын арга хэмжээ бүрээр, тухайн жил худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга, нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулгыг хавсаргаж ирүүлсэн байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,061,346.6 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 25,000.0 сая төгрөг бүрдүүлж, урсгал зардалд 23,694.3 сая төгрөг, хөрөнгийн зардалд 1,062,652.3 сая төгрөгийг зарцуулахаар тооцон төлөвлөж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг хянаж 604,265.3 сая төгрөгөөр буюу 55.6 хувиар бууруулж Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсвийн ерөнхийлөн захирагчийн 1 хөтөлбөр 7 арга хэмжээг санхүүжүүлэхэд улсын төсвөөс нийт 482,081.3 сая төгрөгөөр баталснаас урсгал зардалд 16,786.2 сая төгрөг, хөрөнгийн зардалд 465,295.1 сая төгрөг тус тус баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Зам, тээврийн хөгжлийн сайдаас 2023 онд улсын төсөвт 25,230.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тооцон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад төсвийн төсөл хүргүүлснийг 150,000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 175,230.0 сая төгрөгөөр баталсан. Гүйцэтгэлээр 16.6 хувь буюу 29,089.0 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Энэ нь олон улсын геополитикийн тогтворгүй нөхцөл байдалтай холбоотой нислэгийн өнгөрөлтийн тоо буурсан, төлбөр хураах цэгийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулаагүй, төлөвлөлтийг бодитой төлөвлөөгүй зэрэгтэй холбоотой.

Хүснэгт 10. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэл

/сая төгрөг/

Д/д	Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Навигацийн орлого /ИНЕГ/	150,000.0	5,000.0	145,000.0	3.3
2	Монгол Улсын Төрийн далбаа мандуулж ашигласны орлого /Далайн захиргаа ТӨҮГ/	230.0	250.0	(20.0)	109.0
3	Төлбөр хураах цэгийн орлого /УАЗС/	25,000.0	23,839.0	1,161.0	95.3
Нийт дүн		175,230.0	29,089.0	146,141.0	16.6

Эх сурвалж: ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарцуулалт

Тайлант онд улсын төсвөөс 444,873.1 сая төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлого 23,839.0 сая төгрөгийг бүрдүүлэн 468,651.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны "Журам шинэчлэн батлах тухай" 444 дүгээр тогтоол батлагдсантай холбоотой өөрийн үйл ажиллагааны орлогоос төвлөрүүлсэн 40.8 сая төгрөгийг

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зөвхөн зардалд тайлагнаж, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 20.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 468,651.3 сая төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь тус яамны хөрөнгө оруулалтын зардлыг 13,413.5 сая төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны зардлыг 11.5 сая төгрөгөөр, тээврийн үйлчилгээний зардлыг 3.2 сая төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 1.8 сая төгрөгийг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 11. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71107	Зам тээврийн бодлого, удирдлага	482,081.3	468,651.3	13,430.0	97.2
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	15,809.9	15,798.4	11.5	99.9
1.2	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	333.4	333.4	-	100.0
1.3	80239	Тээврийн үйлчилгээ	4.2	1.0	3.2	23.8
1.4	80509	ОУ-ын байг-ын гишүүнчлэл хураамж	167.2	167.2	-	100.0
1.5	80704	Ахмад дайчин, алдар цолтой ахмадад	206.6	206.6	-	100.0
1.6	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	265.0	263.1	1.9	99.2
1.7	80918	Бусад	465,295.2	451,881.6	13,413.6	97.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3. Тухайн жилийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын 120 төсөл арга хэмжээний зардалд 465,295.1 сая төгрөгийг төлөвлөж баталснаас, гүйцэтгэлээр авто замын барилгын ажилд 362,131.0 сая төгрөг, их засварын ажилд 34,497.6 сая төгрөг, улсын чанартай авто замын засвар, арчлалтын ажилд 55,252.9 сая төгрөгийг тус тус нийт 451,881.6 сая төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 97.1 хувьтай гарсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Шивээ хүрэн төмөр зам ХХК: Шивээхүрэн-Сэхэ боомтын бүтээн байгуулалтын ажлын хөрөнгө оруулалтын анхны ТЭЗҮ 207,700.0 сая төгрөгөөр баталсныг тодотгож 269,400.0 сая төгрөг болгож нэмэгдүүлсэн үндэслэл хангалттай хийгдсэн эсэхэд хяналт хэрэгжүүлээгүй байна. Мөн ТЭЗҮ батлагдсан эсэх тодорхойгүй, төмөр замын суурь бүтэц шинээр барих ажлын гүйцэтгэлд мэргэжлийн болон захиалагчийн хяналт тавих үүргийг хэрхэн хийж байгаа талаар мэдээлэл хангалтгүй;
- ЗТХЯ-ны хөрөнгө оруулалт : Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл"-ийн хүрээнд Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.1 км авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажлын Багц 2 болон Багц 4 дүгээр хэсгийн гүйцэтгэгчээр ажиллаж байсан БНХАУ-ын "Чайна Стэйт Констракшн, Шинжиан Констракшн Инженеринг Групп" компанитай байгуулсан гэрээг 2020 онд цуцалсан боловч гүйцэтгэлийн баталгааны төлбөр болох 2,548,849.45 ам.доллар тус төслийн дансанд байршиж байна. Тухайн гүйцэтгэлийн баталгааны төлбөрийг төсөвт төвлөрүүлээгүй, автозамын төсөлд зарцуулах талаар тооцоолол хийгдээгүй;
- Орхон АЗЗА ТӨХК Тайлант онд зорилтот түвшний төлөвлөгөөгөөр 1.1 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 510.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан. Мөн хөрөнгө оруулалтын ажил 117.6 сая төгрөгөөр батлагдсанаас тайлант онд хөрөнгө оруулалтын ажил хийгдээгүй;
- Зам, тээврийн хөгжлийн төв ТӨБЗГ-ын даргын 2022 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 560 дугаар тогтоолоор 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын

төлөвлөгөөг баталсан байна. Эрдэм шинжилгээ, судалгаа, стандарт, норм дүрэм боловсруулах ажил бүрэн хэрэгжээгүй, тус орлогын төлөвлөгөөний хэрэгжилт 62 хувьтай байна;

- Монгол Улсын далайн захиргаа: ЗТХС-ын 2023 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн А/228 дугаар тушаалаар баталсан Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хүрээнд Бага оврын усан замын тээврийн хэрэгслийн зогсоолын төсөл хэрэгжиж, Архангай, Өгийнуурын хяналтын пост барих ажил, Улаанбаатар хотод байгуулах бага оврын усан замын тээврийн хэрэгслийн зогсоолын ажил, Хөвсгөл болон Хатгал суманд барих усан замын зогсоолын ажил хэрэгжээгүй, биелэлт 18.8 хувьтай байна.


3.5.4 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Зам, тээврийн хөгжлийн сайдын багцын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 16 арга хэмжээний биелэлт 72.5 хувьтай байна.

Хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	
Авто зам				
24.1	24.1.1	Байнгын ашиглалтад оруулах авто замын нийт хүчин чадал /км/	450	381.4
	24.1.2	Байнгын ашиглалтад оруулах гүүрний нийт хүчин чадал /урт метр/	120	841.7
	24.1.3	Урсгал засвар, арчлалт хийх авто замын нийт хүчин чадал /км/	14,891.40	14,981.4
	24.1.4	Урсгал засвар, арчлалт хийх гүүрний нийт хүчин чадал /урт метр/	15,989.40	15,989.4
	24.1.5	Эрдэм шинжилгээ, туршилт, судалгааны тоо	3	3
	24.1.6	Лабораторийн туршилт, шинжилгээний дүгнэлтийн тоо	1,100	2,050
	24.1.7	Улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын нийт замд эзлэх хувь	52	52
Авто тээврийн хяналт, зохицуулалт, нийтийн тээвэр				
24.2	24.2.1	Авто тээврийн хэрэгслийн үзлэг оношилгооны хамрагдалтын хувь	70	72.2
	24.2.2	Зорчигч эргэлт /өмнөх оны суурь үзүүлэлтээс өсгөх хувь/	3	5.3
	24.2.3	Ачаа тээврийн эргэлт /өмнөх оны суурь үзүүлэлтээс өсгөх хувь/	3	309.7
Төмөр зам				
24.3	24.3.1	Зүүнбаян-Ханги чиглэлийн 226 км төмөр замын ажлын хувь	100	95
	24.3.2	"Богдхан төмөр зам" төслийн ажлын хувь	100	10
Агаарын тээвэр				
24.4	24.4.1	Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо /мянга/	400	43.5
	24.4.2	Буулт, хөөрөлтийн тоо /мянга/	14	20
	24.4.3	Ачаа тээвэрлэлтийн хэмжээ нэмэгдүүлэх /мянган тонн/	14	8.6
	24.4.4	Зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо /мянга/	1,000	1731.3

Зорилтот түвшиндээ хүрээгүй дараах арга хэмжээнүүд байна. Тухайлбал:

- Цагааннуур-Зэлтэрийн 120 км замын зарим ажил цаг агаарын нөхцөл байдлын улмаас хойшлогдож ашиглалтад ороогүй;
- Орон нутгийн зорчигч тээврийн чиглэлд агаарын тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн чиглэлийн нислэгийг 8 болгон нэмэгдүүлснээр хот хоорондын авто тээврийн зорчигчийн тоо буурсан;
- Орос-Украины геополитикийн хямралт нөхцөл байдлаас шалтгаалан олон улсын нислэг багассантай холбоотой навигацийн орлого болон олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо буурсан байна.



3.5.5. Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар Засгийн газрын нөөц хөрөнгөөс төсвийн захирагчид хуваарилсан орлого 2,439.0 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 16,851.7 сая төгрөг, нийт 19,290.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал зардалд 6,817.5 сая төгрөгийг зарцуулж, Автозамын санд 6,823.0 сая төгрөгийг шилжүүлж, үлдэгдэл 5,650.2 сая төгрөгийг төсөвт татан төвлөрүүлжээ. Үүнд:

- Монгол улсын засгийн газрын 2023 оны 343 дугаар тогтоолоор Засгийн газрын нөөц хөрөнгөөс Улаанбаатар-Мандалговь чиглэлийн авто замын 208-250 километрт авто замын хучилтад үүссэн эвдрэлийг засварлахад шаардагдах 400.0 сая төгрөг олгож Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/258 дугаар тушаалаар Дундговь авто зам ХХК-тай гэрээ байгуулж авто замын засварын ажлыг хийж гүйцэтгэсэн;
- Монгол улсын засгийн газрын 2023 оны 490 дүгээр тогтоолоор Засгийн газрын нөөц хөрөнгөөс олон удаа их хэмжээтэй орсон цас болон цасан шуурганы улмаас хаагдсан улсын чанартай авто зам, давааг нээж тээврийн хэрэгсэл зорчих боломжийг бүрдүүлэх, замд үүссэн халтиргааг арилгаж хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд зарцуулахаар 2,039.0 сая төгрөгийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/258 дугаар тушаалын дагуу 23 зам хариуцагчтай гэрээ байгуулан гүйцэтгэлийн дагуу санхүүжилтийг олгосон;
- Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас шилжүүлсэн Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2022 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 210/МА2022/00930 магадлалын дагуу Чайна гео инженеринг корпораци ХХК-ны нөхөн төлбөрийн 6,823.0 сая төгрөгийг Налайх АЗЗА ТӨХК, Ховд АЗЗА ТӨХК, Харгуй АЗЗА ТӨХК, Архангай АЗЗА ТӨХК-уудтай байгуулсан гэрээний дагуу Улсын Автозамын санд шилжүүлсэн;
- Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2022 оны 04 дүгээр тогтоолоор Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ (RFID tag)-ны загвар боловсруулах, худалдан авах, тээврийн хэрэгсэлд байрлуулах цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Жолоочийн даатгалын сангаас 10,000.0 сая төгрөгийн санхүүжилт олгож Бодь-электроникс ХХК, Монкабель системс ХХК, Вертексмон ХХК, ДАЗО ХХК, Дэлхийн стандарт нэг монгол нийгэмлэг ТББ-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, гүйцэтгэлийн дагуу 4,349.8 сая төгрөгийг олгож, санхүүжилтийн үлдэгдэл 5,650.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн дараа онд зарцуулахаар татаас санхүүжилтийн авлага үүсгэн бүртгэсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэлд Авто замын сангийн санхүүжилтээр 2018 онд Сүхбаатар аймгийн Дарьганга сумын төвийн хэсэгчилсэн 2.4 км хатуу хучилттай авто замын барилгын ажил гүйцэтгэх гэрээт ажлын үлдэгдлийн 226.7 сая төгрөг байршиж байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

74

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсвийн ерөнхийлөн захирагч, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төрийн өмчийн хөрөнгийн үр ашгийг сайжруулах, мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэзул, аудитор Д.Эрдэнэчимэг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2024 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн 03/1424 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнгээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 805,440.4 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,054.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд 13,437.2 сая төгрөгийг хэмнэж ажилласан байна. Тухайлбал:

- Иргэний нисэхийн ерөнхий газар цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлын төсвөөс 948.7 сая төгрөг, орон байраар хангах зардлын төсвөөс 1,000.0 сая төгрөг, бусад зардлын төсвөөс 2,582.1 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна;
- Монголын төмөр зам ТӨХК ТӨБЗГ-ын 379 дүгээр тогтоолоор орон тоог 119 хүнээр бууруулснаас 3,565.5 сая төгрөгийн цалин, 445.7 сая төгрөгийн НДШ-ийн зардал, түрээсийн зардлыг 214.8 сая төгрөгөөр, түрээсээр ашигладаг 14 машиныг 9 болгон бууруулж 260.4 сая төгрөгөөр, шатахуун ашиглалт болон тос тосолгооны материалын ашиглалт дээр хяналт тавьж ажилласнаас 75.6 сая төгрөгөөр буюу нийт 4,562.0 сая төгрөг хэмнэсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн аудитын асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Харьяа байгууллагууд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудлаар 234,142.9 сая төгрөгийн 20 зөрчил илэрснээс 13,227.1 сая төгрөгийн 7 албан шаардлага хүргүүлж, 182,910.8 сая төгрөгийн 11 зөвлөмж, 38,005.0 сая төгрөгийн 2 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.5 "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 14.2.10 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын илрүүлэлт:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулбал зохих мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан /ЗТХЯ 19 мэдээлэл, Архангай АЗЗА ТӨХК 5 мэдээлэл, Төв АЗЗА ТӨХК 9 мэдээлэл, Ховд АЗЗА ТӨХК 4 мэдээлэл, Хархорин АЗЗА ТӨХК 17 мэдээлэл, Налайх АЗЗА ТӨХК 12 мэдээлэл, Булган АЗЗА ТӨХК 29 мэдээлэл, Багануур АЗЗА ТӨХК 22 мэдээлэл, Сүхбаатар аймаг Талын зам АЗЗА ТӨХК 2 мэдээлэл, Хөвсгөл аймаг АЗЗА ТӨХК 15 мэдээлэл, Сэлэнгэ АЗЗА ТӨХК 5 мэдээлэл, Дорноговь АЗЗА ТӨХК 4 мэдээлэл/;
- АТҮТ ТӨҮГ: Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 91, зарлагын 218 нийт 309 гүйлгээний 9,090.8 сая төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн;
- Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ: орлого, зарлагын 190 гүйлгээний 9,401.4 сая төгрөгийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна;
- Монголын төмөр зам ТӨХК: Өмнөх аудитаар хүргүүлсэн "Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлж байх" албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд 28,603.6 сая төгрөгийн зөрчил гаргаснаас 51 удаагийн мөнгөн гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй, 152 удаагийн орлогын, 437 удаагийн зарлагын гүйлгээг хугацаа хоцроосон;
- МИАТ ТӨХК: Дараа жилийн төсвийн төсөл, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн. арга хэмжээний тайлан, Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө нийт 182,910.8 сая төгрөгийн 3 мэдээ хоцроосон;
- Монгол улсын Далайн захиргаа ТӨҮГ 1,277.8 сая төгрөгийн 77 гүйлгээг хугацаа хоцроосон байна.
- Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулбал зохих мэдээллийг байршуулаагүй байна. Тухайлбал: Төв Эрдэнэсант АЗЗА ТӨХК 12 мэдээлэл, Өвөрхангай АЗЗА ТӨХК 1,703.4 сая төгрөгийн тендерийн баримт бичиг, шалгаруулалт, байгууллагын захирлын хөрөнгө зарцуулах шийдвэрийг,

- Хархорин АЗЗА ТӨХК: Захирлын гаргасан хөрөнгө зарцуулах тухай 58.7 сая төгрөгийн 17 шийдвэрийг тус тус байршуулаагүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Харьяа байгууллагууд

Илрүүлэлт: Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 15 байгууллагад холбогдох хууль, журмыг мөрдөөгүйгээс нийт 26,261.1 сая төгрөгийн 28 зөрчил илэрч, 0.04 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 114.2 сая төгрөгийн 4 албан шаардлага, 26,147.0 сая төгрөгийн 22 зөвлөмж, хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 14.2.5 "өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах", 14.2.10 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын илрүүлэлт Тухайлбал:

- Увс АЗЗА ТӨХК Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалыг мөрдөөгүй 144.9 сая төгрөгийн, АТУТ ТӨҮГ албан томилолт, шатахууны зардал, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй 167.3 сая төгрөгийн, Налайх АЗЗА ТӨХК борлуулалтын орлогыг дутуу тайлагнасан, худалдан авалтад журам мөрдөөгүй 305.7 сая төгрөгийн зөрчил тус тус илэрсэн;
- Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах нэгдсэн төв: Инкон ХХК-ийн хөдлөх бүрэлдэхүүний гэрчилгээгүй, дугааргүй 2 вагоныг хөдөлгөөнд оруулан тээвэрлэлт хийлгэж, төмөр замын тээврийн аюулгүй байдал, стандартын шаардлага, технологийн горимыг зөрчсөн;
- Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах нэгдсэн төв Нийслэлийн Засаг Даргын 2017 оны А/878 дугаар шийдвэрээр Баянгол дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвд "Орон сууцны конторын" зориулалтаар олгосон 0.1261 га газар дээр Ди Ди Эм Ти ХХК-тай "Барилгын ажлын гэрээ"-г байгуулж, батлагдсан зураг төсөлгүйгээр барилгын ажлыг эхлүүлсэн;
- Улсын авто замын сан: 2019 онд шинэчлэн батлагдсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу "Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"-д заасантай нийцэхгүй, шинэчлэн батлаагүй;
- ИНЕГ: ЗТХЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 24 дүгээр тушаалаар баталсан журмыг үндэслэн харьяа яамны нэр бүхий ажилтнуудад гадаад томилолтын 266.7 сая төгрөгийн зардлыг олгосон;
- Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны А/05 дугаар тушаалаар баталсан дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.7-д ажлаас чөлөөлөгдөх үндэслэл нь ялгаатай байхад тэтгэмжийг ижил тогтоон олгож байна. Мөн тус тэтгэмж авсан ажилтанд иргэний нисэхийн салбартаа дахин томилогдвол өндөр насны тэтгэвэрт гарахад нь ажилласан хугацааг нь дахин тооцож тэтгэмж давхардуулан олгох эрсдэлтэй байна;
- ИНЕГ: Тайлант онд ЗТХС-ын А/224, А/299 дүгээр тушаалын дагуу зохион байгуулалтын бүтцийн шинэчлэлтийг 2 удаа хийсэнтэй холбогдуулан нийт орон тоо хасагдаагүй, өөр ажлын байранд шилжүүлэн ажиллуулах боломжтой 6 ажилтанд орон тоо хасагдсан үндэслэлээр 5-36 хүртэл сарын тэтгэмж бодож 283.2 сая төгрөгийг олгосон;
- ИНҮТ: Өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийг олгохдоо хамтын гэрээ болон ИНЕГ-ын даргын тушаалыг үндэслэн дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээгээр тооцож өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 53 ажилтанд 4,782.5 сая төгрөг олгосон нь үндсэн цалингаас тооцсон дүнгээс 2,102.2 сая төгрөг буюу 82.0 хувиар өндөр байна;
- ИНҮТ: Буянт Ухаа Олон улсын нисэх буудлын хамгаалалтын талбай дахь тусгай хэрэгцээний газартай хил нийлүүлэн /1781310951/ нэгж талбарын дугаартай газрыг Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-д орон сууцны ашиглалтын төрлөөр эзэмших эрхтэйгээр олгосон, мөн хамгаалалтын хашааны 3 метрийн зайд Ай ти зон ХХК, Ситибылдинг ХХК, Бүрэн Хайрхан Ээж Трэйд

ХХК, Иргэн ХХК, Буянт Бумба Эрдэнэ ХХК, Могул групп ХХК, Зэмэдү ХХК зэрэг компаниуд барилга байгууламж болон хашаа тулган барьж байгаа нь Аэродромын хөдөлгөөний бүсэд мал амьтан, гаднын этгээд санаатай болон санамсаргүйгээр нэвтрэх гэх мэт нисэхийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаанд нөлөөлж нисэх буудлын үйл ажиллагаанд хүндрэл учруулах эрсдэлтэй байна;

- ИНҮТ: Иргэний нисэхийн үндэсний төвийн 2023 оны А/80 дугаар тушаалаар баталсан агаарын тээврийн үйлчилгээний шинэчлэн баталсан тарифыг мөрдөөгүйгээс орон нутгийн нисэх буудлуудын орлогыг нэмэгдүүлэх, алдагдал бууруулах боломжийг алдсан байна;
- ИНҮТ: Ажилтнуудын ажлын үр дүнг үнэлэхдээ ажилласан хугацаа, ажлын бүтээмжийг харгалзан үнэлэх үзүүлэлт тодорхойгүй, үр дүнгийн нэмэгдлийг хавтгайруулан олгосноос 2023 онд шинээр орсон 88 ажилтныг түүвэрлэн үзэхэд сар бүр 40.0 хувийн нэмэгдэл тооцон 179.1 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 180,435.8 сая төгрөгийн 340 алдаа, зөрчил илрүүлснээс 196.1 сая төгрөгийн зөрчилд 42 төлбөрийн акт тогтоож, 155,646.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 129 албан шаардлага хүргүүлж, 24,593.2 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 169 зөвлөмж өгснөөс 42 төлбөрийн акт, 117 албан шаардлага, 112 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, биелэлт 79.7 хувьтай байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	42	196.1	42	196.1	100
Албан шаардлага	129	155,646.5	117	152,129.0	90.7
Зөвлөмж	169	24,593.2	112	23,961.0	66.3
Нийт дүн	340	180,435.8	271	176,285.0	79.7

Өмнөх оны акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад дараах албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

Албан шаардлага

- МИАТ ТӨХК: Шинэ олон улсын нисэх буудалд “Ангарын оффисын барилга” бариулах ажил гүйцэтгэх гэрээг Далу ХХК-тай 2021 онд байгуулсныг тендерийн техникийн шаардлага хангаагүй, үүргээ биелүүлээгүй үндэслэлээр гэрээг хүчингүй болгосонтой холбоотой гүйцэтгэлийг үнэлж баталгаажуулаагүй;
- ИНЕГ: “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент”-ийн концессын гэрээгээр зохицуулснаар үл хөдлөх хөрөнгийн албан татвар, хөрөнгийн элэгдлийн зардлыг Концесс эзэмшигчээр төлүүлж, гэрээг бүрэн хэрэгжүүлэх;
- Далайн захиргаа ТӨҮГ: Тус байгууллагын хөрөнгөөр бэлтгэгдсэн 4.1 сая төгрөгийн зөөврийн компьютерыг байгууллагын хөрөнгийн бүртгэлд бүртгэсэн ч, тухайн хөрөнгө нь хэнд хаана байгаа нь тодорхой болгох;
- Булган АЗЗА ТӨХК: “Автомашин, механизмын сэлбэг, материалыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэх;
- Булган АЗЗА ТӨХК: “Тайлант онд 14 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас авах 213.6 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах;
- Булган АЗЗА ТӨХК: “Автомашинуудын километрийн спидометр ажилладаггүй, явсан км тодорхой бус, шатахууны тооцоо, тайлан хангалтгүй, зарцуулалтад хяналт тавих албан шаардлагыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Зөвлөмж

- Улсын авто замын сан: Авто замын зөвлөлийн ажиллах журмыг шинэчлэн боловсруулах;

7/6

- Далайн захиргаа ТӨҮГ: Байгууллагын статусыг тодорхой болгох;
- Монголын төмөр зам ТӨҮГ: БНХАУ-ын Экспорт-импорт банкнаас авсан дамжуулан зээлийн үндсэн өр 279,623.0 сая төгрөг, зээлийн хүүгийн төлбөр 5,014.1 сая төгрөг, ханшийн зөрүүгийн алдагдалд 57,441.6 сая төгрөг үүссэн. Энэ нь тус компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, төлбөрийн чадварыг бууруулж, ханшийн зөрүүнээс алдагдал хүлээж байна гэсэн зөрчилд “Дээд шатны байгуулагад хандан зээлийн эргэн төлөлтийн чадварыг дахин хянуулах”;
- Далайн захиргаа ТӨҮГ: Авто машинд учруулсан бодит хохирлын дүнг тогтоож, хохирлыг холбогдох этгээдээр барагдуулах;
- Булган АЗЗА ТӨХК: ЗТХЯ-аас хүлээлгэж өгсөн Усны машин МАЗ /3505/, Нөхөөсний машин БИС /310М/ маркийн машин нь тооллогын бүртгэлд байгаа ч үнэ тодорхойгүй шалтгаанаар үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусгах зөвлөмжийг тус тус хэрэгжүүлээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд тайлант онд гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 7 төсөл хэрэгжүүлж, хэрэгжилт нь 76.5 хувьтай байна. Дараах төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, үр дүнг гүйцэтгэл-нийцлийн аудитаар нарийвчлан үзэх шаардлагатай байна. Үүнд:

- Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын гүйцэтгэгчийн гэрээний хугацааг сунгасан, гэрээний үнэ өссөн, Урьханаас Сүмбэрийн уулзвар хүртэлх 45.74 км авто замын ажил нь төлөвлөгөөнөөс 39.0 хувийн хоцрогдолтой;
- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замд нэмэлтээр асфальт бетон хучилт хийх ажил нь 2 дугаар багц буюу “Хар модот давааны араас Урьхан хүртэлх 45.5 км авто зам барих төсөл”-ийн хувьд төлөвлөгөөнөөс 39.9 хувийн хоцрогдолтой;
- “Чайна Гео Инженеринг Корпораци” ХХК-тай байгуулсан 4 дүгээр багцын гэрээний хэрэгжилт хангалтгүйн улмаас 2021 онд гүйцэтгэх гэрээг цуцлах шийдвэр гаргасан, “Улсын комиссын акт”-ыг өнөөг хүртэл баталгаажуулаагүй;
- Хүйтний хөндий-Арвайхээр чиглэлийн 57.56 км авто замд мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон зөвлөх компани, зураг төслийн компаниас 2022 онд хийсэн шалгалтаар Онги гол гүүр нурах, улмаар замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх өндөр магадлалтай, гүүрэнд их засвар хийх шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан;
- Баянгол дүүргийн 20 дугаар хороонд байрлах 4000 м.кв газар дээр Бүгд найрамдах Солонгос Улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА), ЗТХЯ, Сангийн яам хамтран “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төвийн барилга барих, үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх замаар Монгол Улсын төмөр замын тээврийн өрсөлдөх чадварыг сайжруулах” төслийн гүйцэтгэл 35.0 хувьтай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 544,258.2 сая төгрөгийн 52 алдаа¹ илэрснээс 544,242.8 сая төгрөгийн 47 алдааг аудитын явцад залруулж, 15.4 сая төгрөгийн 5 алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Аудитаар нийт 35,926.4 сая төгрөгийн 195 зөрчил² илэрснээс, 384.1 сая төгрөгийн зөрчилд 31 төлбөрийн акт тогтоож, 30,859.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 57 албан шаардлага хүргүүлж, 4,682.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 106 зөвлөмж, 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн байна.

Аудитаар илэрсэн 35,926.4 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

Харьяа байгууллагууд

Аудитаар нийт 35,926.4 сая төгрөгийн 192 зөрчил³ илэрснээс, 384.1 сая төгрөгийн зөрчилд 31 төлбөрийн акт тогтоож, 30,859.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 55 албан шаардлага хүргүүлж, 4,682.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 105 зөвлөмж 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 34 байгууллагын санхүүгийн тайланг нэгтгэснээс 29 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэсэн тайлан гаргах цаглабарт хугацаанд Авто-Импекс ХК, Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХК, Зам, тээврийн хөгжлийн яамны хөрөнгө оруулалт, их засварын санхүүгийн тайлан, Авто замын норм нормативын сангийн санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн хэрэгжүүлсэн. Мөн Мишээл од аудит ХХК нь Шивээ хүрэн төмөр зам ХХК-ийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж гүйцэтгэсэн.

Аудитад хамрагдсан эрхлэх асуудлын хүрээний 29 байгууллагад дүгнэлт гарснаас 23 байгууллагад "өөрчлөлтгүй", 5 байгууллагад "хязгаарлалттай" дүгнэлт, 1 байгууллагад "сөрөг" дүгнэлт өгсөн байна.

Хязгаарлалттай, Сөрөг санал дүгнэлт өгсөн байгууллагууд

№	Байгууллагын нэр	№	Байгууллагын нэр
Хязгаарлалттай дүгнэлт		Сөрөг дүгнэлт	
1	Иргэний нисэхийн ерөнхий газар	1	Булган АЗЗА ТӨХК
2	Иргэний нисэхийн үндэсний төв		
3	Монголын төмөр зам ТӨХК		
4	Зам, тээврийн хөгжлийн яам		
5	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв		

Булган АЗЗА ТӨХК нь 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг шинж чанартай, өргөн тархсан зөрчил илэрч "Сөрөг" дүгнэлт авсан тул Булган Авто зам засвар

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Гу

арчлалт ТӨХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2024 оны 3 дугаар тогтоолоор гүйцэтгэх захирлыг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч

5.2.1 Албан шаардлага

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 5 байгууллага төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж сургалт, томилолт болон бусад зардалд 722.3 сая төгрөгийг зарцуулж, үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "үр ашигтай байх", 5 дугаар зүйлийн 5.4 "Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно", 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.4 "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх", 15.2.3 "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх", 15.2.6 "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

5.2.2 Албан шаардлага

Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул байгаагаас тайлант онд санхүүгийн тайлангийн аудитын нийт 35,926.4 сая төгрөгийн, нийцлийн аудитын 26,261.1 сая төгрөгийн материаллаг хэмжээний зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2.10 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 14.3 "Төсвийн ерөнхи
, 2йлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", 69 дүгээр зүйлийн 69.1 "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах, харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих, дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг 20-иос доошгүй хувиар бууруулж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

Түүврийн байгууллагууд

5.3 Албан шаардлага

Авто импекс ХК нь тайлант онд 148.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, Сангийн яаманд төлөх хугацаа хэтэрсэн, шүүхийн шийдвэртэй 4,289.5 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, өмнөх оны аудитаар өгсөн 2 зөвлөмж, 1 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, түрээсийн орлогын 87.6 сая төгрөгийг гүйцэтгэх захирлын хувийн дансаар, 26.8 сая төгрөгийг бичиг хэргийн ажилтны хувийн дансанд төвлөрүүлсэн, түрээслэгчээс авах болон бусад авлагын 341.5 сая төгрөгийн үлдэгдлийг барагдуулаагүй, санхүүгийн тайланг хугацаа хоцроож ирүүлсэн зэрэг зөрчлүүд илэрсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", 83 дугаар зүйлийн 83.1 "Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19 дүгээр зүйлийн 19.1 "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах", 19.2 "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад санал хүргүүлэн шийдвэрлэх албан шаардлага хүргүүлэх.

5.4 Зөвлөмж

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Авто замын норм нормативын сангаас "Чанартай зам, чансаатай засвар арчлалт" сэдэвт уулзалт, цахим ажлыг сурталчлах ажлыг 8 компанитай шууд гэрээ байгуулж, 68.0 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 "энэ хуулийн 52.1.12-т дурдсан цахим хуудсанд тендерийн урилгыг зарлан мэдээлэх бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн доод хязгаар", мөн хуулийн 8.5 "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.4 "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын ...шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг

санхүүжүүлэх", 15.2.3 "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилот болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах, төрийн өмчийн хөрөнгийн үр ашгийг сайжруулах

2. Хөрөнгө оруулалтын зарцуулаагүй үлдэгдлийг төвлөрүүлэхтэй холбоотой асуудал */Хөрөнгө оруулалт, их засвар/*

Илрүүлэлт 1:

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл"-ийн хүрээнд Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.1 км авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажлын Багц 2, 4 дүгээр хэсгийн гүйцэтгэгчээр ажиллаж байсан БНХАУ-ын "Чайна Стэйт Констракшн, Шинжиан Констракшн Инженеринг Групп" компанитай байгуулсан гэрээг 2021 онд цуцалсан боловч гүйцэтгэлийн баталгааны төлбөр болох 2,548,849.45 ам.доллар тус төслийн дансанд байршиж байна. Тухайн гүйцэтгэлийн баталгааны төлбөрийг төсөвт төвлөрүүлээгүй, автозамын төсөлд зарцуулах талаар тооцоолол хийгдээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4 "төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 14 дүгээр зүйлийн 14.3 "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", 43 дугаар зүйлийн 43.3 "Төсвийн жил дуусахад Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан эргэлтийн сангийн үлдэгдэл хөрөнгийг төсөвт татан төвлөрүүлэх асуудлыг энэ хуулийн 18.6-д заасны дагуу шийдвэрлэх бөгөөд тухайн хөрөнгийг дараагийн жилийн батлагдсан төсвийн дагуу зарцуулна", Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар баталсан "Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам"-ын 10.5. "Салбарын хэмжээнд гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлан, дүгнэлт зөвлөмжийг хэлэлцэх, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авч биелэлтэд хяналт тавих, удирдлага зохицуулалтаар хангах, нэгтгэн тайлагнах үйл ажиллагааг харьяалах төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ. ...", гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тухайн гүйцэтгэлийн баталгааны төлбөрийг төсөвт төвлөрүүлээгүй, өмнө дутуу хэрэгжсэн төсөлд зарцуулах талаар үндэслэлтэй тооцоолол хийгээгүй зөрчлийг арилгаж, гүйцэтгэлийн баталгааны төлбөрийг дутуу хэрэгжсэн төсөлд зарцуулах бол гүйцэтгэгчийг нээлттэй сонгон шалгаруулж, дотоод хяналт хэрэгжүүлэх.

3. Төрийн өмчийн хөрөнгийн үр ашгийг сайжруулахтай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК нь авто замын засвар арчлалтын үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчит 20 компанийн нийт 37,785.0 сая төгрөгийн дүрмийн санг нэгтгэн улсын бүртгэлд бүртгүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа боловч зорилтот түвшний төлөвлөгөө батлуулаагүй, дүрмийн сан нь орон нутгийн АЗЗА компаниудын дүрмийн сантай давхардсан, чиг үүрэг тодорхойгүй байна. Мөн тус ТӨХК нь эхлэлтийн тайлан гаргаагүй учир төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тайлангаа нэгтгүүлээгүй.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.2 "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6 "Төрийн өмчийн төлөөлөгч болон төлөөлөн удирдах зөвлөлийн төрийг төлөөлөх гишүүнээр томилогдсон этгээд нь төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчээс баталсан удирдамж, зааврыг баримтлан ажиллана. Удирдамж, зааврыг зөрчсөн буюу зохих ёсоор биелүүлээгүй нь түүнийг томилсон шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн авто замын засвар арчлалтын үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчит компаниудын талаар тооцоолол судалгаа явуулж, бүтэц зохион байгуулалтын талаар холбогдох газруудаас санал авч, чиг үүрэг, дүрмийн санг давхардуулан бүртгэсэн зөрчлийг арилгах

Илрүүлэлт 2: Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК нь тайланд онд 229.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд хүндэт зочны танхимаар нийт 7,953 иргэнд үйлчилж 1,180.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн боловч 3,111 иргэнд 747.8 сая төгрөгийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлсэн нь алдагдалтай ажиллахад нөлөөлсөн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2 "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, гадаад харилцааны сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд нарын 2020 оны 33А/24А/101 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Чингис хаан" Олон улсын нисэх буудлын "Төрийн хүндэт зочны танхимаар үйлчлүүлэх журам"-д өөрчлөлт оруулан хөнгөлөлт, чөлөөлөлтийг бууруулах, компани өөрийн үйл ажиллагааны хүрээнд алдагдалгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөг/

№	Байгууллагын нэр	Нийт алдааны дүн		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн өмчит үйлдвэрийн газар													
1	Иргэний нисэхийн үндэсний төв	6	552.1			6	552.1	3	536.9	3	15.2	3	15.2
2	МИАТ ТӨХК	2	527,912.9			2	527,912.9	2	527,912.9				
3	Монголын төмөр зам ТӨХК	11	150.8	6	49.8	5	101.0	9	150.6	2	0.2	2	0.2
4	Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ	1	35.7			1	35.7	1	35.7				
5	Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	2	538.5			2	538.5	2	538.5				
6	Монгол улсын Далайн захиргаа ТӨҮГ	1	386.5			1	386.5	1	386.5				
7	Төв Эрдэнэсант АЗЗА ТӨХЗ	2	29.6			2	29.6	2	29.6				
8	Завхан АЗЗА" ТӨХК	1	235.7			1	235.7	1	235.7				
9	Өвөрхангай АЗЗА ТӨХК	1	38.0			1	38.0	1	38.0				
10	Дархан-Уул АЗЗА ТӨХК	1	1.0			1	1.0	1	1.0				
11	Баян-чандмань АЗЗА ТӨХК	2	2.0			2	2.0	2	2.0				
12	Булган АЗЗА ТӨХК	1	65.9			1	65.9	1	65.9				
13	Талын зам АЗЗА ТӨХК	4	554.0			4	554.0	4	554.0				
14	Сэлэнгэ АЗЗА ТӨХК	4	854.7			4	854.7	4	854.7				
15	Налайх АЗЗА ТӨХК	1	16.2			1	16.2	1	16.2				
16	Багануур АЗЗА ТӨХК	7	19.1			7	19.1	7	19.1				
	Дүн	47	531,392.7	6	49.8	41	531,342.9	42	531,377.3	5	15.4	5	15.4
Төсвийн шууд захирагч													
17	Зам, тээврийн хөгжлийн яам	4	12,857.1			4	12,857.1	4	12,857.1				
18	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах нэгдсэн төв	1	8.4			1	8.4	1	8.4				
	Дүн	5	12,865.5	-	0.0	5	12,865.5	5	12,865.5	-	0.0	-	0.0
	Нийт дүн	52	544,258.2	6	49.8	46	544,208.4	47	544,242.8	5	15.4	5	15.4



Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан санхүүгийн зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс											
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага, тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн ерөнхийлөн захирагч															
1	Зам, тээврийн хөгжлийн яам	3	-			2	-	1	-						
	Дүн	3	-			2	-	1	-						
Төсвийн төвлөрүүлэн захирагч															
2	Иргэний нисэхийн ерөнхий газар	7	2,729.7	1	49.7	2	18.0	4	2,662.0						
	Дүн	7	2,729.7	1	49.7	2	18.0	4	2,662.0						
Төрийн өмчит үйлдвэрийн газар															
3	Иргэний нисэхийн үндэсний төв	21	2,452.9	4	107.6	6	2,272.1	11	73.2						
4	МИАТ ТӨХК	10	5,258.9			4	5,258.9	6	-						
5	Монголын төмөр зам ТӨХК	13	22,830.3	1	8.4	7	22,038.0	5	783.9						
6	Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ	5	17.5			1	0.9	4	16.6						
7	Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ-ын харьяа байгууллагууд	15	696.1	1	0.1	1	0.5	13	695.5						
8	Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	5	91.0			1	74.4	4	16.6						
9	Монгол улсын Далайн захиргаа ТӨҮГ	8	24.2			2	6.8	6	17.4						
10	Төв Эрдэнэсант АЗЗА ТӨХЗ	1	1.8			1	1.8								
11	Өвөрхангай АЗЗА ТӨХК	2	18.6			2	18.6								
12	Дархан-Уул АЗЗА ТӨХК	2	1.3	2	1.3			3	0.5						
13	Баян-чандмань АЗЗА ТӨХК	6	18.8	2	2.4	1	15.9	3	0.5						
14	Булган АЗЗА ТӨХК	16	463.8	9	37.0	2	329.8	5	97.0	1					
15	Талын зам АЗЗА ТӨХК	3	26.2			1	4.8	2	21.4						
16	Сэлэнгэ АЗЗА ТӨХК	7	23.7	1	0.5	3	2.8	3	20.4						
17	Налайх АЗЗА ТӨХК	2	25.1					2	25.1						
18	Багануур АЗЗА ТӨХК	5	12.7	2	2.7			3	10.0						
19	Архангай АЗЗА ТӨХК	2						2							
20	Төв АЗЗА ТӨХК	4	102.5			1	66.0	3	36.5						

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

21	Увс АЗЗА ТӨХК	1	1.1			1	1.1							
22	Ховд АЗЗА ТӨХК	2	29.8					2	29.8					
23	Дорноговь АЗЗА ТӨХК	6	2.9	1	2.9			5	-					
24	Орхон АЗЗА ТӨХК	6	28.1			4	28.1	2	-					
25	Хөвсгөл АЗЗА ТӨХК	6	20.4	1	1.1	1	1.2	4	18.1					
26	Говь-Алтай АЗЗА ТӨХК	1	-			1	-							
27	Харгуй ТӨХК	3	13.4	1	1.0	1	7.4	1	5.0					
28	Авто импекс ХК	1	455.9			1	455.9							
29	Шивээ хүрэн төмөр зам ХХК	5	104.7	1	0.8	2	18.4	2	85.5					
30	Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХК	1	-					1	-					
	Дүн	160	32,721.6	26	165.8	44	30,603.4	89	1,952.5	1				
	Тусгай сан													
31	Улсын авто замын сан	10	244.4	1	149.5	4	94.9	5	-					
	Дүн	10	244.4	1	149.5	4	94.9	5	-					
32	Зам, тээврийн хөгжлийн яам	10	154.3	3	19.1	4	135.2	3	-					
33	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах нэгдсэн төв	3	8.4			1	8.4	2	-					
34	ЗТХЯ-ны хөрөнгө оруулалт, их засвар	1	-					1	-					
35	АЗНН-ын сан	1	68.0					1	68.0					
	Дүн	15	230.7	3	19.1	5	143.6	7	68.0					
	НИЙТ ДҮН	195	35,926.4	31	384.1	57	30,859.8	106	4,682.5	1				

01
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГ,
ХЯЗГААРЛАЛТАЙ
САПАЛ ДҮГНӨЛТ

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

/сая төгрөг/

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн зөрчлийн нэгтгэл

№	Байгууллагын нэр	Өмчийн хэлбэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны хууль тогтоомжтой холбоотой зөрчил														
1	Зам, тээврийн хөгжлийн яам	ТШЗ	1	-										
2	Архангай АЗЗА ТӨХК	ТӨҮГ	1	-										
3	Төв АЗЗА ТӨХК	ТӨҮГ	1	-										
4	Ховд АЗЗА ТӨХК	ТӨҮГ	1	-										
5	Эрдэнэсант АЗЗА ТӨХК	ТӨҮГ	1	-										
6	Өвөрхангай АЗЗА ТӨХК	ТӨҮГ	1	1,703.4			1	1,703.4						
7	Хархорин АЗЗА ТӨХК	ТӨҮГ	1	58.8			1	58.8						
8	Багануур АЗЗА ТӨХК	ТӨҮГ	1	964.7			1	964.7						
9	Дорноговь АЗЗА ТӨХК	ТӨҮГ	1	91.1			1	91.1						
10	Монголын темер зам ТӨХК	ТӨҮГ	1	28,603.6							1	28,603.6		
11	Авто тээврийн үндэсний төв	ТӨҮГ	1	9,090.8			1	9,090.8						
12	Зам тээврийн хөгжлийн төв	ТӨҮГ	1	9,401.4							1	9,401.4		
13	Налайх АЗЗАТӨХК	ТӨҮГ	1	-							1			
14	Улсын авто замын сан	ТӨҮГ	1	-							1			
15	Хөвсгөл АЗЗА ТӨХК	ТӨҮГ	1	-							1			
16	Сэлэнгэ АЗЗА ТӨХК	ТӨҮГ	1	-							1			
17	Булган АЗЗА ТӨХК	ТӨҮГ	1	40.5			1	40.5						
18	Талын зам АЗЗА' ТӨХК	ТӨҮГ	1	-							1			
19	МИАТ ТӨХК	ТӨҮГ	1	182,910.8							1	182,910.8		
20	Монгол улсын Далайн захиргаа	ТӨҮГ	1	1,277.8			1	1,277.8						
Шилэн дансны хууль тогтоомжтой холбоотой зөрчлийн дүн			20	234,142.9	-	-	7	13,227.1	11	182,910.8	2	38,005.0	-	-
Бусад хууль тогтоомжийн хүрээнд														
1	Иргэний нисэхийн үндэсний төв	ТӨҮГ	6	-							6			

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2	Улсын авто замын сан	ТӨҮГ	1	24,812.7					1	24,812.7			
3	Зам, тээврийн хөгжлийн яам	ТШЗ	1	-					1				
4	"УВС АЗЗА" ТӨХК	ТӨҮГ	1	144.9					1	144.9			
5	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулах нэгдсэн төв	ТШЗ	2	-					1			1	-
6	Авто тээврийн үндэсний төв	ТӨҮГ	3	167.3					3	167.3			
7	Авто тээврийн үндэсний төвийн харьяа салбар	ТӨҮГ	1	713.8					1	713.8			
8	Дорноговь АЗЗА ТӨХК	ТӨҮГ	1	-					1	-			
9	Налайх АЗЗАТӨХК	ТӨҮГ	3	305.7					3	305.7			
10	Говь-Алтай АЗЗА ТӨХК	ТӨҮГ	1	56.9			1	56.9					
11	Иргэний нисэхийн ерөнхий газар	ТТЗ	3	-					3	-			
12	Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	ТӨҮГ	1	26.4					1	26.4			
13	Булган АЗЗА ТӨХК	ТӨҮГ	2	30.8		1	0.043		1	30.8			
14	Талын зам АЗЗА" ТӨХК	ТӨҮГ	1	-					1	0			
15	Монгол улсын Далайн захиргаа ТӨҮГ	ТӨҮГ	1	2.6					1	2.6			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчлийн дүн			28	26,261.1	1	0.0	4	114.1	22	26,147.0	1	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 дугаар сарын 25 № 971/АД121241

Улаанбаатар хот

СНАГ-2024/08/НА-СТА-ТЭЗ
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сүл байгаагаас тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн 35,926,371,000.00 /гучин таван тэрбум есөн зуун хорин зургаан сая гурван зуун далан нэгэн мянган/ төгрөгийн, нийцлийн аудитын 26,261,104,520.00 /хорин зургаан тэрбум хоёр зуун жаран нэгэн сая нэг зуун дөрвөн мянга таван зуун хорин/ төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2 "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.3 "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ..., Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", 14.2.10 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69 дүгээр зүйлийн 69.1 "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад тавих дотоод хяналтыг сайжруулан зөрчлийг 20-иос доошгүй хувиар бууруулах тодорхой арга хэмжээ авч ажиллаж биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд /С.Бямбацогт/, Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /А.Мөнхбат/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг-4-р хороо, Бага тойруу-3 Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

Z:\Alban Shaardlaga\2024\0425 SNAG-37.Docx

0001981673

82



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 дугаар сарын 25 № 942/A0121241

Улаанбаатар хот

СНАГ-2024/08/НА-СТА - ТЭС
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж харьяа байгууллагууд 722,252,000.00 /Долоон зуун хорин хоёр сая хоёр зуун тавин хоёр мянган/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "үр ашигтай байх", 5 дугаар зүйлийн 5.4 "Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно", 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.4 "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын ... шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх", 15.2.3 "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх", 15.2.6 "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг арилган, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд /С.Бямбацогт/, Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /А.Мөнхбат/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



(Handwritten signature)
Д.ЗАГДЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264250

Z:\Alban Shaardlaga\2024\0425 SNAG-37.Docx

0001081669



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 01 дугаар сарын 25 № 970/А0170460

Улаанбаатар хот

СНАГ-2024/8/НА-СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Авто импекс ХК нь тайлант онд 148,494,797.00 /нэг зуун дөчин найман сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга долоон зуун ерэн долоон/ төгрөгийн алдагдалтай ажилласан, Сангийн яаманд төлөх хугацаа хэтэрсэн, шүүхийн шийдвэртэй 4,289,500,000.00 /дөрвөн тэрбум хоёр зуун наян есөн сая таван зуун мянган/ төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Тайлант онд түрээсийн орлогын 87,638,891.00 /наян долоон сая зургаан зуун гучин найман мянга найман зуун ерэн нэг/ төгрөгийг гүйцэтгэх захирлын хувийн дансаар, 26,792,864.00 /хорин зургаан сая долоон зуун ерэн хоёр мянга найман зуун жаран дөрвөн / төгрөгийг бичиг хэргийн ажилтны хувийн дансанд төвлөрүүлсэн, түрээслэгчээс авах болон бусад авлагын 341,495,985.00 /гурван зуун дөчин нэгэн сая дөрвөн зуун ерэн таван мянга есөн зуун наян таван/ төгрөгийн үлдэгдлийг барагдуулаагүй, санхүүгийн тайланг хугацаа хоцроож ирүүлсэн, өмнөх оны аудитаар өгсөн 2 зөвлөмж, 1 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", 83 дугаар зүйлийн 83.1 "Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19 дүгээр зүйлийн 19.1 "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах", 19.2 "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харьяа байгууллагад дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, түрээсийн болон бусад авлагыг барагдуулах, хувийн дансаар дамжуулан гүйлгээ хийдэг, өмнөх оны аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцож, зөрчлийг арилган биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн дарга /С.Батболд/, Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /А.Мөнхбат/, Автоимпекс ХК-ийн гүйцэтгэх захирал /С.Отгонбаатар/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Д.ЭРДЭНЭЧИМЭГ



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН
ТУШААЛ

2024 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/1124

Улаанбаатар хот

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Үндэсний аудитын газраас Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн аудитын дүгнэлт, зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн тайланд өгсөн Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу зарцуулж, нягтлан бодох бүртгэлийн ажлыг сайжруулах зорилгоор Зам, тээврийн хөгжлийн сайдын төсвийн багцын нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллагуудын дарга (төсвийн шууд захирагч) нарт дор дурдсан ажлыг зохион байгуулахыг даалгасгай.

1.1.Санхүүгийн сахилга батыг чанд сахих, Төрийн хэмнэлтийн тухай болон холбогдох хуулийн заалтыг мөрдөж ажиллах, нягтлан бодох бүртгэлийн хувьд аудитын шалгалтаар “хязгаарлалттай” дүгнэлт үүсгэсэн, цаашид үүсгэж болзошгүй асуудлыг нэг бүрчлэн илрүүлэх, хууль тогтоомжид нийцүүлэн засах, 2023 оны санхүүгийн тайланд гаргасан алдаа, зөрчлийг 30 хувь хүртэл хэмжээгээр бууруулах.


1.2.Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллаж, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 25–ны өдрийн дотор тус яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст ирүүлэх.

2.Сайдын төсвийн багцын 2023 оны санхүүгийн тайланд өгсөн албан шаардлагын дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж чадаагүй зөрчлийг арилгах, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааг сайжруулах, харьяа байгууллагуудын акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавихыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (А.Мөнхбат)-т үүрэг болгосугай.

3.Санхүүгийн 2023 оны тайлангийн аудитын дүгнэлтээр “Өөрчлөлтгүй” үнэлгээ авсан байгууллагуудын санхүү, бүртгэлийн ажилтнуудад урамшуулал олгохыг төсвийн шууд захирагч нарт зөвшөөрсүгэй.

4.Сайдын төсвийн багцын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын шалгалтаар илэрсэн алдаа, зөрчлийг засаж залруулах ажлыг удирдан зохион байгуулах, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга С.Батболдод даалгасугай.

САЙД



С.БЯМБАЦОГТ

030000644

БАТЛАВ.
ДЭД САЙД

Handwritten signature
24.12.24
Л.ХАЛТАР

Зам, тэвэрийн хөгжлийн сайдын төсвийн багцын 2023 оны жилийн эцсийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын шалгалтын шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын шийдвэр	Хариуцах нэгж, байгууллага	Зөрчлийг арилгах асуудлыг		Биелэлт ирүүлэх хугацаа
					Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх арга хэмжээ	
A	3	4	5	6	7	8	9
1	Аудитаар нийт 35,926.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 234.6 сая төгрөгийн зөрчилд 30 төлбөрийн акт тогтоож, 30,765.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах 49 албан шаардлага хүргүүлж, 4,926.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 103 зөвлөмж 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах, харьяа Байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг 20-иос доошгүй хувиар бууруулж ажиллах	35,926.4 сая төгрөг	албан шаардлага	Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	2024.12.31	Харьяа байгууллагуудад сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн явцад хяналт тавих, зөрчлийг 50 хувь бууруулах ажлыг зохион байгуулах, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 25-ны дотор нэгтгэж, УАГ-т хүргүүлэх	2024.09.30
2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг арилгах	722.2 сая төгрөг	албан шаардлага	Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	2024.12.31	Харьяа байгууллагуудад сайдын тушаалаар өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг хянах, зөрчлийг бууруулах үүрэг өгөх, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 25-ны дотор нэгтгэж, УАГ-т хүргүүлэх	2024.09.30
3	Авто импэкс ХК: 1. Харьяа байгууллагад дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, түрээсийн болон бусад авлагыг барагдуулах, хувийн дансаар дамжуулан гүйлгээ хийдэг, өмнөх оны аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцох 2. Цаашд алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах	4745.4 сая төгрөг	албан шаардлага	Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Автоимпэкс компанийн захирал С.Отгонбаатар	2024.12.31	Автоимпэкс компанид зөрчлийг арилгах тодорхой хугацаатай үүрэг өгөх, биелэлтийн явцад хяналт тавих, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 25-ны дотор гаргах, УАГ-т хүргүүлэх	2024.09.30

85

4	Аудитын шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргасан ч хэрэгжилт хангалтгүй байгаад дүгнэлт хийх.	-	Албан бичгээр өгсөн үүрэг	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	2024.06.15	2024.09.30	Хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргах, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар харъяа байгууллагуудад сайдын тушаалаар үүрэг өгөх, тушаалыг албан бичгээр хүргүүлэх
5	Авто замын норм, нормативийн сангаас сурталчилгааны ажлыг 8 компанитай шууд гэрээ байгуулан ажилласан байна.	68.0 сая төгрөг	зөвлөмж	ЗТХТөв	2024.12.31	2024.09.30	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, үйлчилгээ худалдан авахдаа хууль, тогтоомжийг мөрдөн ажиллах, төрийн өмчийн үр ашгийг сайжруулах
6	АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй төслийн барилгын ажлын гэрээг цуцалсан боловч гүйцэтгэлийн баталгааны төлбөрийг төсөвт төвлөрүүлээгүй, төслийн барилгын ажилд зарцуулах талаар тооцоолол хийгдээгүй байна.	2,548.8 сая доллар	зөвлөмж	Авто замын бодлого, зохицуулалтын газар	2024.09.30	2024.09.30	Төслийн дутуу хийсэн барилгын ажилд баталгааны мөнгийг зарцуулах талаар үндэслэлтэй тооцооллыг гаргах, гүйцэтгэлийг нээлттэй сонгон шалгаруулах,
7	Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК нь зорилгот түвшний төлөвлөгөө батлуулаагүй, дүрмийн сан нь орон нутгийн АЗЗА-ын компаниудын дүрмийн сантай давхардсан, чиг үүрэг нь тодорхойгүй байна.		зөвлөмж	Авто замын бодлого, зохицуулалтын газар	2024.09.30	2024.09.30	Орон нутгийн авто замын засвар арчлалтын үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчит компаниудын бүтэц, зохион байгуулалтын талаар холбогдох газраас санал авч, чиг үүрэг, дүрмийн санг давхардуулсан зөрчлийг арилгах.
8	Хөшгийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК 229.4 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, 3111 иргэнд 747.8 сая төгрөгийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлсэн нь алдагдалтай ажиллахад нөлөөлсөн байна		зөвлөмж	Иргэний нисэхийн бодлого, зохицуулалтын газар	2024.09.30	2024.09.30	Холбогдох байгууллагуудаар батлуулсан "Чингис хаан" Олон улсын нисэх буудлын "Төрийн хүндэт зочны танхимаар үйлчлүүлэх журам"-д өөрчлөлт оруулах, хөнгөлөлт, чөлөөлтийг бууруулах, компани өөрийн үйл ажиллагааны хүрээнд алдагдалгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх

Хянасан:

ХШУДАГ-ын дарга -с *А. Мөнхбат*

АЗБЗГ-ын дарга

Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга *Н.Цэвэлмаа*

Боловсруулсан: СХОХ-ийн ахлах шинжээч *Г. Алтангэрэл*

А. Мөнхбат
Ч. Сугармаа
Н. Цэвэлмаа
Г. Алтангэрэл

2024/09/30

Handwritten mark



Г ЗАМ ТЭЭВРИЙН, ХӨГЖЛИЙН САЙД С.БЯМБАЦОГТ ТАНАА Г

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024. 04. 29 № 1183

танай _____ -ны № _____ -т

Г Аудитын тайлан хүргүүлэх тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, гэрчилгээг хүргүүлж байна.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу Үндэсний аудитын газарт ирүүлж, биелэлтийг ханган ажиллахыг зөвлөж байна.

Хавсралт ... хуудастай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Handwritten signature and official stamp of the Mongolian State Audit Agency

Д.ЗАГДЖАВ



88

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 дугаар сарын 25 № 970/А0140460

Улаанбаатар хот

СНАГ-2024/8/НА-СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Авто импекс ХК нь тайлант онд 148,494,797.00 /нэг зуун дөчин найман сая дөрвөн зуун ерэн дөрвөн мянга долоон зуун ерэн долоон/ төгрөгийн алдагдалтай ажилласан, Сангийн яаманд төлөх хугацаа хэтэрсэн, шүүхийн шийдвэртэй 4,289,500,000.00 /дөрвөн тэрбум хоёр зуун наян есөн сая таван зуун мянган/ төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Тайлант онд түрээсийн орлогын 87,638,891.00 /наян долоон сая зургаан зуун гучин найман мянга найман зуун ерэн нэг/ төгрөгийг гүйцэтгэх захирлын хувийн дансаар, 26,792,864.00 /хорин зургаан сая долоон зуун ерэн хоёр мянга найман зуун жаран дөрвөн / төгрөгийг бичиг хэргийн ажилтны хувийн дансанд төвлөрүүлсэн, түрээслэгчээс авах болон бусад авлагын 341,495,985.00 /гурван зуун дөчин нэгэн сая дөрвөн зуун ерэн таван мянга есэн зуун наян таван/ төгрөгийн үлдэгдлийг барагдуулаагүй, санхүүгийн тайланг хугацаа хоцроож ирүүлсэн, өмнөх оны аудитаар өгсөн 2 зөвлөмж, 1 албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", 83 дугаар зүйлийн 83.1 "Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Монгол Улсын Ерөнхий аудитормын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19 дүгээр зүйлийн 19.1 "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах", 19.2 "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.


Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2024\0125 SNAG-37.Docx

0001081667

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харьяа байгууллагад дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, түрээсийн болон бусад авлагыг барагдуулах, хувийн дансаар дамжуулан гүйлгээ хийдэг, өмнөх оны аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцож, зөрчлийг арилган биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн дарга /С.Батболд/, Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /А.Мөнхбат/, Автоимпекс ХК-ийн гүйцэтгэх захирал /С.Отгонбаатар/ нарт даалгав.



САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Д.ЭРДЭНЭЧИМЭГ



20

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 дугаар сарын 25

№ 971/А0121241

Улаанбаатар хот

СМАГ-2024/08/НА-СТА-ТЭС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул байгаагаас тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн 35,926,371,000.00 /гуучин таван тэрбум есөн зуун хорин зургаан сая гурван зуун далан нэгэн мянган/ төгрөгийн, нийцлийн аудитын 26,261,104,520.00 /хорин зургаан тэрбум хоёр зуун жаран нэгэн сая нэг зуун дөрвөн мянга таван зуун хорин/ төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 14 дүгээр зүйлийн 14.2 "Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.3 "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, ..., Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна", 14.2.10 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", 69 дүгээр зүйлийн 69.1 "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад тавих дотоод хяналтыг сайжруулан зөрчлийг 20-иос доошгүй хувиар бууруулах тодорхой арга хэмжээ авч ажиллаж биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд /С.Бямбацогт/ Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /А.Мөнхбат/ нарт даалгав.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ЗАГДЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2024\0425 SNAG-37.Docx

0001981673



91

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 дугаар сарын 25 № 972/A0121241

Улаанбаатар хот

СНАГ-2024/08/НА-СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж харьяа байгууллагууд 722,252,000.00 /Долон зуун хорин хоёр сая хоёр зуун тавин хоёр мянган/ төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "үр ашигтай байх", 5 дугаар зүйлийн 5.4 "Энэ хуульд заасныг зөрчиж тэргүүн дэд, дэд, орлогч дарга, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно", 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.4 "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын ... шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх", 15.2.3 "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх", 15.2.6 "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн үр ашигтай нь уялдуулан олгох" гэж тус тус заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүү, төсвийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг арилган, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд /С.Бямбацогт/, Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /А.Мөнхбат/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ЗАГДЖАВ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тэргүү-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2024\0425 SNAG-37.Docx

0001081669



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

92
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙД С.БЯМБАЦОГТ ТАНАА

2024.04.25 № 1167
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь аудитын дүгнэлт өгөх үндэслэл болно.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 35,926.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, иж бүрэн байх, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Тухайлбал:

- Санхүүгийн тайланд бүртгэлтэй 8 байгууллагын 11,989.2 сая төгрөгийн авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Олон жилийн насжилттай, он дамжсан 2,472.4 сая төгрөгийн авлага, өглөгийг барагдуулах үр дүнтэй арга хэмжээ аваагүй;
- Шүүхийн шийдвэрийн дагуу Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын хохиролд 6,823.0 сая төгрөг төлснийг улсын төсөвт төвлөрүүлээгүй, нэмэлт санхүүжилтийн данснаас зам засварын ажилд зарцуулахаар Авто замын санд шилжүүлсэн;

- 93
- Төлбөрийн чадваргүй болсон Чингис хаан банканд байршуулсан 2,661.9 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монголын төмөр зам ТӨХК нь Шивээ хүрэн-Сэхээ хилийн боомтын төмөр замын төслийн барилгын ажлыг 2023 онд эхлүүлж, Шивээ хүрэн боомтын хил дамнасан нарийн царигийн төмөр замыг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК нь үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр агаарын тээврийн түрээсийн АегСар компаниас В787-9 төрлийн 2 онгоц урт хугацааны түрээсээр ашиглах гэрээ байгуулж, эхний онгоцыг 2023 оны 8 дугаар сард хүлээн авч Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт 16-д нийцүүлэн тайлагнасан байна.

Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбоотой Засгийн газрын 2023 оны 201 дүгээр тогтоолоор “Орон нутгийн нислэгийг сэргээн тогтворжуулах” шийдвэр гарч, шинэ үйл ажиллагааны чиглэл батлагдсантай холбоотой гүйцэтгэх захирлын 2023 оны А/267 дугаар тушаалаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулсан байна.

Агаарын харилцааны чиглэлээр Катар, Грек, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард улсуудын төлөөлөлтэй агаарын харилцааны хэлэлцээрт гарын үсэг зурсан бөгөөд Америкийн Нэгдсэн Улстай Open Sky хэлэлцээрт гарын үсэг зурснаар 2 улс хооронд шууд нислэгтэй болох асуудал шийдэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Зам, тээврийн хөгжлийн сайдын багцын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан 4 зорилт, 24 арга арга хэмжээний биелэлт 72.5 хувьтай байна.

Үндэсний төмөр замын сүлжээг 2023 онд 416.1 километрээр өргөтгөж, Тавантолгой Зүүн-Баян чиглэлийн төмөр замыг улсын комисс байнгын ашиглалтад хүлээж авсан байна. Тус төмөр зам нь 1 өртөө 6 зөрлөгтэй жилд 15 сая тонн ачаа тээвэрлэх хүчин чадалтай байна.

Өмнөх онд Монголын төмөр зам ТӨХК-ийн орлогын 67.2 хувийг түрээсийн орлого эзэлж байсан бол тайлант онд ачаа, тээвэрлэлтийн хэмжээ 2.5 дахин нэмэгдэж 1.8 сая тоннд хүрснээр, нийт орлогын 88.3 хувийг ачаа тээврийн орлого эзэлж байна.

Бусад асуудлын хэсэг

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 онд хэрэгжүүлэх 13 зорилтын хүрээнд 141 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 85.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

24

Санхүүгийн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ЗАГДЖАВ

БАТЛАВ:
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

ЗАМ ТЭЭВРИЙН ХӨРӨГЖИЛТИЙН ДЭМЖЭЛТ, АШИГААРТАЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ДҮГНӨЛТ,
ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зөрчлийн төрөл, үйл ажиллагааны төрөл	Аудитын дүгнэлт	Зөрчлийн дүн (мянган төгрөг)	Хариуцах нэгж	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Биелэлт ирүүлэх хугацаа
4	Үйл ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж зарим төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйгээс үлдсэн 625,000.0 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлснээр, хэвлэл, мэдээллийн зэрлэл, судалгааны ажлыг байгууллага, хувь хүмүүсээр гүйцэтгүүлэн гэрээт ажлын төлбөрт зарцуулсан байна.	Зөвлөмж		Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	Төсвийн тухай хууль, бусад хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх	Байнга	2024.07.25
6	3Г-ын 2023 оны 80 дугаар тогтоолын дагуу зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн баталж, Судалгаа, стандарт, статистикийн хэлтсийг шинээр байгуулан чиг үүргийг баталсан байна. Тухайн хэлтсийн чиг үүрэгт хамаарах ажлын 9 хувь хүн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлж 163,300.0 мянган төгрөгийн гэрээ байгуулан салбарын бодлогыг салбарын бус судалгааны багаар гүйцэтгүүлэн үр дүнтэй зэрлэл гаргасан байна. /Гүйцэтгэл хүлээн аваагүй судалгааны 5 ажилд 93,400.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна/	Зөвлөмж		Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа, стандарт, статистикийн хэлтэс	Судалгааны ажлын жилийн төлөвлөгөө батлуулж, тухайн чиглэлээр мэргэшсэн мэрэгжлийн судлаач, байгууллагаар гүйцэтгүүлэх	2024.04.30	2024.07.25
5	Урсгал зардлаас 135,177.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэхдээ худалдан авалтад гүйцэтгэлийг харьцуулалтын болон нээлттэй тендер сонгон шалгуулах журмаар сонгон шалгаруулаагүй, шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн байна.	Албан шаардлага	135,177.0	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	Төрийн болон орон, нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, бусад хууль журмыг хэрэгжүүлж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх	Байнга	2024.07.25
7	Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын гэрчилгээг цахимжуулах 10.0 тэрбум төгрөгийн арга хэмжээг 2023 онд бүрэн дуусгах байсан ч ажлын хэсгийн уялдаа холбоо муу байгаагаас 43.5 хувийн хэрэгжилттэй байна. МУЗГ-ын хуралдааны 2022 оны 47 дугаар тэмдэглэл, МУ-ын замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн 2022 оны 04 дүгээр тогтоолоор өгөгдсөн чиглэлийн дагуу ЗТХС, МУС, Нийслэлийн Улаанбаатар хотын авто замын түржээлийг бууруулах үндэсний хорооны дэргэйн хамтарсан 2022 оны А/287, А/02 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулсан бөгөөд, эх үүсвэрийг Жолоочийн Даатгалын сангаас шийдвэрлэж тус арга хэмжээг Улаанбаатар хотод 2022 онд, орон нутагт 2023 онд бүрэн хэрэгжүүлж дуусгахар төлөвлөсөн байна.	Албан шаардлага		Авто тээврийн бодлого зохицуулалтын газар	Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын гэрчилгээг цахимжуулах ажлын төлөвлөгөө, төсвийг шинэчлэн батлуулах, салбар хоорондын уялдаа холбоогүй байх, төлөвлөгөөнд заасан хугацаанд хэрэгжүүлж дуусгах	2024.04.30	2024.07.25

8	Тус яам нь Авто замын тусгай зөвшөөрөл, Төмөр замын тусгай зөвшөөрөл, Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзэг хийх, улсын дугаарын үйлдвэр эрхтэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгож орон нутгийн төсөвт /Сүхбаатар дүүргийн ХХБ-ны 495089309 дансанд/ тэмдэгтийн хураамжийн орлого 578,700.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн боловч бүртгэлээр тавих хяналт хангалтгүй, орлогын бүрдүүлэлтийн тооцоог нийлж, актаар баталгаажуулаагүй байна.	Албан шаардлага	-	Авто тээврийн бодлого зохицуулалтын газар, Авто замын бодлого зохицуулалтын газар, Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газар	Улсын тэмдэгтийн хураамжийг татварын системд төлбөрийн нэхэмжлэл үүсгүүлж, нэхэмжлэлийн дагуу төлбөрийг төлөх, улирал тутам тооцоо нийлж баталгаажуулах	2024.07.05	2024.07.25
9	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элгдлээрээ анхны өртөө нөхсөн нийт 225 төрлийн 729,031,231.0 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байгааг ашиглах болон дахин үнэлүүлэн, бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.	Албан шаардлага	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	Элгдлээрээ өртөө нөхсөн хөрөнгийг ашиглалтын байдлыг тодорхойлон дахин үнэлэх эсхүл актлах, бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн ТӨБЗГ-г тавьж шийдвэрлүүлэх	2024.07.05	2024.07.25	
10	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын шийдвэрийн дагуу Чайна гео инженеринг корпораци ХХК-аас авах Өндөрхаан-Цойбалсан чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын хохирол барагдуулах ажлын төлбөр 6,822,962.6 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлснийг улсын төсөвт төвлөрүүлснийг, Налайх АЗЗА ТӨХК, Ховд АЗЗА ТӨХК, Хөргүй АЗЗА ТӨХК, Архангай АЗЗА ТӨХК-ийдтай шууд гэрээ байгуулан зам засварын ажилд зарцуулахаар Авто замын санд шилжүүлсэн байна.	Албан шаардлага	Авто замын бодлого зохицуулалтын газар	Төсвийн тухай хууль, бусад хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх	Байнга	2024.07.25	
1	Тус яамны салбарын хяналтын газрын эрх бүхий албан тушаалтнууд нь Зөрчлийн тухай хуулийн дагуу оногдуулсан торгуулийн 108,550.0 мянган төгрөгийн орлогыг Төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн боловч Сангийн яамтай тооцоо нийлж баталгаажуулаагүй, шийтгэлийн хуудсаар оногдуулсан 2,700.0 мянган төгрөгийн торгуулийн орлогыг төсөвт төвлөрүүлээгүй, бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна.	Акт	2,700.0	Салбарын хяналтын газар	Аудитын актэд заасны дагуу төлбөрийг зохих дансанд шилжүүлэх	2024.04.15	2024.07.25
2	Хэрэгжих боломжгүй болсон 5 нэр төрлийн барилтын ажлын зураг, төсвийн зардлаас урьдчилан 12,172.9 мянган төгрөгийн техник, хяналтын зардлыг суутган авсан ч үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна.	Акт	12,172.9	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс	Аудитын актэд заасны дагуу төлбөрийг зохих дансанд шилжүүлэх	2024.04.15	2024.07.25
3	МУЗГ-ын 2023 оны 490 дүгээр "Улсын чанартай авто замд хийгдсэн өвлийн ариалтын онцгой ажилд зарцуулах хөрөнгийн жагсаалт батлах тухай" тогтоолын дагуу Зам тээврийн хөгжлийн төрд 59,886.7 мянган төгрөгийн техник хяналтын зардал олгосон боловч хойд бус нутагт хамаарах аймагуудад техник хяналт ажлын төлбөрт хэрэгжүүлээгүй байхөд 4,259.1 мянган төгрөг олгосон байна.	Акт	4,259.1	Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮТ	Аудитын актэд заасны дагуу төлбөрийг зохих дансанд шилжүүлэх	2024.04.15	2024.07.25
				154,509.0	Нийт дүн		

Хянасан:



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2023 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 6/55

Улаанбаатар хот

Ажлын байрны жагсаалт, орон тоог
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, “Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 80 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 487 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Зам, тээврийн хөгжлийн яамны зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт өөрчлөлт орсонтой холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн ажлын байрны жагсаалт, орон тоог хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын “Ажлын байрны жагсаалт, орон тоог шинэчлэн батлах тухай” 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн Б/18 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Ц.Одхүү)-т даалгасугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

С.БАТБОЛД



080000332

Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 6/55 дугаар тушаалын хавсралт

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН АЖЛЫН БАЙРНЫ ЖАГСААЛТ, ОРОН ТОО

№	Ажлын байр/ Албан тушаалын нэр/ санал	Орон тоо	Албан тушаалын ангилал зэрэглэл
1.	Сайд	1	ТӨ-4
2.	Дэд сайд	1	ТӨ-6
3.	Төрийн нарийн бичгийн дарга	1	ТЗ-1
4.	Сайдын зөвлөх	1	АА-5
5.	Сайдын туслах	1	АА-9
6.	Сайдын хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан	1	АА-9
7.	Дэд сайдын туслах	1	АА-9
Нэг. Бодлого, төлөвлөлтийн газар- 20			
8.	Бодлого, төлөвлөлтийн газрын дарга	1	ТЗ-2
9.	Нэгдсэн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч	1	ТЗ-4
10.	Тээвэр логистикийн бодлого төлөвлөлт хариуцсан шинжээч	1	ТЗ-5
11.	Нэгдсэн бодлого, төлөвлөлт, төлөвлөгөө хариуцсан ахлах мэргэжилтэн	1	ТЗ-6
12.	Салбарын дэд бүтцийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн	1	ТЗ-6
13.	Бодлогын хэрэгжилт, төр хувийн хэвшлийн түншлэл хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-7
14.	Салбарын хүний нөөцийн бодлого, дотоод үйл ажиллагааны зохицуулалт хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-7
Судалгаа, стандарт, статистикийн хэлтэс-7			
15.	Судалгаа, стандарт, статистикийн хэлтсийн дарга	1	ТЗ-3
16.	Салбарын стандартчилал, норм, норматив техникийн зохицуулалт хариуцсан ахлах шинжээч	1	ТЗ-4
17.	Судалгаа шинжилгээ, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-7
18.	Салбарын эдийн засаг, судалгаа шинжилгээ хариуцсан мэргэжилтэн	2	ТҮ-7
19.	Салбарын статистик хариуцсан ахлах мэргэжилтэн	1	ТЗ-6
20.	Салбарын статистик, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн	1	ТЗ-7
Мэдээллийн технологийн хэлтэс-6			
21.	Мэдээллийн технологийн хэлтсийн дарга	1	ТЗ-3
22.	Салбарын мэдээллийн технологийн бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч	1	ТЗ-5

23.	Салбарын мэдээллийн нэгдсэн систем, цахим үйлчилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
24.	Мэдээллийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
25.	Салбарын мэдээллийн сан, системийн хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн	1	TУ-7
26.	Мэдээллийн сүлжээ, техник хангамж хариуцсан мэргэжилтэн	1	TУ-7
Хоёр. Төрийн захиргааны удирдлагын газар-37			
27.	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга	1	T3-2
28.	Хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах шинжээч	1	T3-4
29.	Сургалт, салбарын шагналын асуудал хариуцсан шинжээч	1	T3-5
30.	Сайдын зөвлөл, шуурхай хуралдаан хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
31.	Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
32.	Хүний нөөцийн асуудал, өргөдөл гомдол, дотоод үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
33.	Олон нийттэй харилцах ажилтан	1	TУ-7
34.	Төрийн нарийн бичгийн даргын туслах	1	T3-8
35.	Бичиг хэргийн эрхлэгч	1	TУ-7
36.	Архивын эрхлэгч	1	TУ-7
37.	Бичиг хэргийн ажилтан	1	TУ-7
38.	Бичээч-операторчин	1	TУ-7
39.	Эмч	1	TУ-7
40.	Жолооч	1	TУ-7
Хуулийн хэлтэс-6			
41.	Хуулийн хэлтсийн дарга	1	T3-3
42.	Салбарын хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах шинжээч	1	T3-4
43.	Салбарын хууль, эрх зүйн асуудал хариуцсан шинжээч	1	T3-5
44.	Хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн	3	T3-7
Гадаад хамтын ажиллагааны хэлтэс-6			
45.	Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга	1	T3-3
46.	Гадаад харилцаа хариуцсан ахлах шинжээч	1	T3-4
47.	Гадаад харилцаа хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
48.	Гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн	3	T3-7
Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс-11			
49.	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга	1	T3-3
50.	Санхүүгийн ахлах шинжээч, сайдын төсвийн ерөнхий нягтлан бодогч	1	T3-4
51.	Салбарын хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан ахлах шинжээч	1	T3-4
52.	Төсвийн төлөвлөлт хариуцсан шинжээч	1	T3-5
53.	Төрийн сан хариуцсан шинжээч	1	T3-5



54.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, санхүүжилт хариуцсан шинжээч	1	T3-5
55.	Яамны урсгал төсвийн гүйцэтгэл, тайлан, нягтлан бодох бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
56.	Худалдан авах ажиллагаа, авто замын сангийн санхүүжилт хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
57.	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл, санхүүжилт хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
58.	Авто замын сангийн гүйцэтгэл, Төрийн сангийн гүйлгээ хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
59.	Нярав	1	TУ-6
Авто замын бодлого зохицуулалтын газар-19			
60.	Авто замын бодлого зохицуулалтын газрын дарга	1	T3-2
61.	Авто замын салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах шинжээч	1	T3-4
62.	Гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр хариуцсан ахлах шинжээч	1	T3-4
63.	Авто замын бодлогын хэрэгжилт, зохицуулалт хариуцсан шинжээч	1	T3-5
64.	Авто замын салбарын стандарт, зураг төсөл, төсөв үнэ бүрдэлт, судалгаа шинжилгээний асуудал хариуцсан шинжээч	1	T3-5
65.	Авто зам, замын байгууламжийн барилга, үйлдвэрлэл хариуцсан ахлах мэргэжилтэн	2	T3-6
66.	Тусгай зориулалтын авто зам болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөлт, барилга, үйлдвэрлэл хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
67.	Авто зам, замын байгууламжийн барилга, үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн	3	T3-7
68.	Гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
69.	Авто замын тусгай зөвшөөрөл, дотоод үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
Замын ашиглалт, засварын хэлтэс-6			
70.	Замын ашиглалт, засварын хэлтсийн дарга	1	T3-3
71.	Авто зам, замын байгууламжийн ашиглалт, засварын төлөвлөлт хариуцсан шинжээч	1	T3-5
72.	Авто зам, замын байгууламжийн ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
73.	Авто зам, замын байгууламжийн арчлалт, засвар хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
74.	Авто зам, замын байгууламжийн их засвар, шинэчлэлт хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
75.	Авто замын мэдээллийн сан, сүлжээний бүртгэл хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
Автотээврийн бодлого зохицуулалтын газар-14			
76.	Автотээврийн бодлого зохицуулалтын газрын дарга	1	T3-2



77.	Автотээврийн салбарын бодлого хариуцсан ахлах шинжээч	1	T3-4
78.	Автотээврийн салбарын олон улсын гэрээ хариуцсан шинжээч	1	T3-5
79.	Автотээврийн хэрэгслийн техникийн хяналт, бүртгэл хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
80.	Автотээврийн салбарын стандарт, техникийн зохицуулалт, сургалт хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
81.	Тээврийн төлөвлөлт, тээврийн үнэ тариф хариуцсан яамны ахлах зохион байгуулагч	1	T3-8
Тээвэр зохион байгуулалтын хэлтэс-5			
82.	Тээвэр зохион байгуулалтын хэлтсийн дарга	1	T3-3
83.	Улс хоорондын тээвэр хариуцсан шинжээч	1	T3-5
84.	Тээвэр логистик, уул уурхайн тээврийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
85.	Дотоодын тээвэр хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
86.	Автотээврийн хэрэгслийн ашиглалт, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн ажлын алба-3			
87.	Ажлын албаны дарга	1	T3-5
88.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын боловсрол, эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
89.	Замын хөдөлгөөний аюулгүй байдал, дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газар-20			
90.	Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга	1	T3-2
91.	Төмөр замын салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан ахлах шинжээч	1	T3-4
92.	Төмөр замын салбарын эрх зүйн зохицуулалт, стандарт хариуцсан шинжээч	1	T3-5
93.	Төмөр замын эдийн засаг, тарифын бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
94.	Төмөр замын газрын харилцаа, байгаль орчин хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
95.	Төмөр замын тусгай зөвшөөрөл, гэрчилгээжүүлэлт хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
96.	Төмөр замын зураг төсөл, хиймэл байгууламж хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
97.	Төмөр замын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
98.	Төмөр замын боомт, дотоод үйл ажиллагаа хариуцсан яамны ахлах зохион байгуулагч	1	T3-8
Төмөр замын тээврийн хэлтэс-8			
99.	Төмөр замын тээврийн хэлтсийн дарга	1	T3-3
100.	Төмөр замын суурь бүтэц хариуцсан шинжээч	1	T3-5
101.	Төмөр замын ачаа тээвэр хариуцсан шинжээч	1	T3-5
102.	Төмөр замын дохиолол, холбоо, эрчим хүч, ус хангамж хариуцсан шинжээч	1	T3-5



103.	Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
104.	Төмөр замын барилгын ажил хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
105.	Төмөр замын зорчигч тээвэр хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
106.	Төмөр замын олон улсын тээвэр, логистик хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
Далай ашиглалт, усан замын тээврийн хэлтэс-3			
107.	Хэлтсийн дарга	1	T3-3
108.	Усан замын тээврийн асуудал хариуцсан шинжээч	1	T3-5
109.	Далайн тээвэр, боомт ашиглалт хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар-12			
110.	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга	1	T3-2
111.	Салбарын стратегийн зорилт, бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах шинжээч	1	T3-4
112.	Иргэний нисэхийн салбарын бодлого, хөтөлбөр, төслийн хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан шинжээч	1	T3-5
113.	Авто замын салбарын бодлого, хөтөлбөр, төслийн хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан шинжээч	1	T3-5
114.	Автотээврийн салбарын бодлого, хөтөлбөр, төслийн хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан шинжээч	1	T3-5
115.	Санхүүгийн хяналт шалгалт хариуцсан шинжээч	1	T3-5
116.	Дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
117.	Санхүүгийн хяналт шалгалт хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
118.	Төмөр зам, далай, усан замын тээврийн бодлого, хөтөлбөр, төслийн хяналт-шинжилгээ үнэлгээ хариуцсан шинжээч	1	T3-5
119.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
120.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
121.	Салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
Салбарын хяналтын газар-15			
122.	Салбарын хяналтын газрын дарга	1	T3-2
123.	Автотээврийн хяналт хариуцсан ахлах шинжээч	1	T3-4
124.	Авто замын гүүр, инженерийн хиймэл байгууламжийн хяналт хариуцсан ахлах шинжээч	1	T3-4



125.	Автотээврийн хэрэгслийн бүртгэл, авто үйлчилгээ, техникийн хяналтын үзлэгийн хяналт хариуцсан шинжээч	1	T3-5
126.	Төвийн бүсийн авто замын хяналт хариуцсан шинжээч	1	T3-5
127.	Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний хяналт хариуцсан шинжээч	1	T3-5
128.	Автотээврийн зорчигч тээвэр, усан замын хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
129.	Дотоодын ачаа тээврийн хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
130.	Эрсдэлийн удирдлага, улсын байцаагчийн эрх олгох, цуцлах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
131.	Зөрчлийн бүртгэл, гэрээ эрх зүйн хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
132.	Баруун бүсийн авто замын хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
133.	Зүүн болон говийн бүсийн авто замын хяналт хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
134.	Төмөр замын тээврийн ачаа тээвэр, галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулалтын хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
135.	Төмөр замын тээврийн дохиолол холбооны хяналт хариуцсан шинжээч	1	T3-5
136.	Төмөр зам, замын байгууламж, гүүр, инженерийн хиймэл байгууламжийн хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газар-7			
137.	Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газрын дарга	1	T3-2
138.	Иргэний нисэхийн салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч	1	T3-5
139.	Агаарын тээврийн бодлогын хэрэгжилт, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
140.	Агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалт, хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн	1	T3-6
141.	Иргэний нисэхийн бодлогын хэрэгжилт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
142.	Иргэний нисэхийн салбарын эрх зүй, дүрэм журмын бодлого зохицуулалт, нисэхийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн	1	T3-7
143.	Нисэх буудлын бодлого, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа хариуцсан яамны ахлах зохион байгуулагч	1	T3-8
НИЙТ		151	

--oOo--





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 04 өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

Зам, тээврийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг батлах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Зам, тээврийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. “Зам, тээврийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийг батлагдсан орон тоо, төсөвтөө багтаан зохион байгуулж, хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайханд даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Засгийн газрын 2024 оны 09 дүгээр
сарын 04-ний өдрийн 69 дүгээр
тогтоолын хавсралт

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Оршил

Зам, тээврийн яам (цаашид “яам” гэх)-ны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр (цаашид “хөтөлбөр” гэх)-т Зам, тээврийн сайд (цаашид “сайд” гэх)-ын эрхлэх асуудлын хүрээнд тээврийн салбарын удирдлага, хяналтын тогтолцоог хөгжүүлэх, салбарын бодлого, зохицуулалтыг уялдуулах, тээвэр, логистикийн сүлжээг өргөжүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэх, салбарын мэргэжлийн хяналт, төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах, зам, тээврийн салбараас үүдэлтэй агаар, орчны бохирдлыг бууруулахад мэргэжил, арга зүйгээр хангах, санхүүжүүлэх, хөрөнгө оруулалт, гадаад, дотоод хамтын ажиллагааг хамарсан стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлоход оршино.

1.2.Үндэслэл

Хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан Зам, тээврийн яамны зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг үндэслэл болгов.

1.3.Хууль, эрх зүйн орчин

Хөтөлбөрийг доор дурдсан хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль;
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Авто замын тухай хууль;

- Автотээврийн тухай хууль;
- Төмөр замын тээврийн тухай хууль;
- Иргэний нисэхийн тухай хууль;
- Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль;
- Далай ашиглах тухай хууль;
- Усан замын тээврийн тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
- Шинжлэх ухаан, технологийн тухай хууль;
- Хөрөнгө оруулалтын тухай хууль;
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль;
- Олон улсын гэрээний тухай хууль;
- Зөвшөөрлийн тухай хууль;
- Төрийн болон албаны нууцын тухай хууль;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Бусад холбогдох хууль тогтоомж.

1.4.Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад хууль, эрх зүйн өөрчлөлт, сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах чиг үүргүүдэд дүн шинжилгээ хийж, зорилго, үр дүнд чиглүүлэн, засаглал, төрийн захиргааны шинэчлэлийн бодлого, үйл ажиллагааны төлөвлөлт, байгууллагын өөрчлөлтөд үндэслэн олон улсын туршлага, бусад төрийн захиргааны төв байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрүүдэд харьцуулалт хийх замаар нийтлэг арга зүйг ашиглаж, тус яамны үйл ажиллагааны мөн чанар, тэргүүлэх чиглэл, эрхэм зорилго, стратегийн гол зорилт болон зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн чиг үүргийг тодорхойлох арга зүйг ашиглав.

1.5.Яамны үүрэг, хариуцлагын ерөнхий хуваарь

Яам нь эрхлэх асуудлынхаа хүрээнд хамаарах хууль тогтоомж, бодлого, стратегийг төлөвлөх, боловсруулах, салбарын хөгжлийн бодлогыг үндэсний


хэмжээнд нэгдсэн уялдаагаар хангах үүрэг, хариуцлага хүлээж, сайд болон Засгийн газарт мэргэжлийн зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлнэ.

Яам нь салбарын бодлогын төлөвлөлтийг улс, салбар хооронд болон бүс нутаг, орон нутгийн хэмжээнд нэгдсэн бодлого, уялдаагаар хангах, салбарын мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх, асуудалд өргөн цар хүрээтэй, шинжлэх ухааны судалгаа, үндэслэлтэй хандаж, зөв зохистой удирдана.

1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр нь яамны ажил, үйлчилгээг хэрэглэгчийн эрэлт, захиалга, даалгавар байхаар тодорхойлов. Эдгээр хэрэгцээний эх үүсвэрт доор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана:

Яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр



Яамны үндсэн үйлчлүүлэгч нь сайд, Засгийн газар байна.

Яамны стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх харилцааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохицуулахад чиглэгдэнэ. Яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

Хоёр. Яамны үйл ажиллагааны стратеги

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар:

Яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, тэргүүлэх чиглэлд тусгагдсан сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлого, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн мэргэжил, арга зүйн бүх талын зөвлөгөө, тухай бүр оновчтой, мэдээ мэдээлэл, дэмжлэг үзүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн үйл ажиллагааны ил тод, шуурхай байдлыг хангахад оршино.

2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

Яам нь үйл ажиллагааны доор дурдсан тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

2.2.1. зам, тээврийн салбарын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийг тодорхойлох, гадаад улс, олон улсын байгууллагаас санхүүжих төсөл, хөтөлбөр боловсруулах, салбарын хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх ажлын байрыг нэмэгдүүлэх, стандарт, норм, норматив, статистикийн мэдээллийг боловсронгуй болгох, дүн шинжилгээ хийх, хянах, тайлагнах;

2.2.2. салбарын удирдлагын манлайллыг хангах, яамны хүний нөөцийн чадавхыг сайжруулах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх, баримт бичгийн эрх зүйн үндэслэлийг хянах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, санхүүгийн удирдлагыг хэрэгжүүлэх, тайлагнах;

2.2.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн эрэлтийг хангахуйц авто замын сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, бодлого төлөвлөлт, журам, дүрэм, аргачлал, удирдамж, эрх зүйн баримт бичгийг боловсруулах, батлуулах, бодлого, төлөвлөгөөний биелэлтийг удирдлага, зохицуулалтаар хангах, тайлагнах;

2.2.4. дэвшилтэт шинэ технологи, инновац бүхий автотээвэр логистикийн тогтолцоог нэвтрүүлэх, автотээврийн салбараас үүдэлтэй агаар, орчны бохирдлыг бууруулах, автотээврийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэх, бодлого төлөвлөлт, журам, дүрэм, аргачлал, удирдамж, эрх зүйн баримт бичгийг боловсруулах, батлуулах, бодлого төлөвлөгөөний биелэлтийг удирдлага, зохицуулалтаар хангах, тайлагнах;

2.2.5. эдийн засаг, нийгмийн хөгжлийн эрэлтийг хангахуйц тасралтгүй үйл ажиллагаа явуулах, аюулгүй ажиллагааг хангасан төмөр зам, далай ашиглалт болон усан замын тээврийн бодлого төлөвлөлт, журам, дүрэм, аргачлал, удирдамж, эрх зүйн баримт бичгийг боловсруулах, батлуулах, бодлого, төлөвлөгөөний биелэлтийг удирдлага, зохицуулалтаар хангах, тайлагнах;

2.4.6. эдийн засаг, нийгмийн хөгжлийн эрэлтийг хангахуйц тасралтгүй үйл ажиллагаа явуулах, аюулгүй ажиллагааг хангасан иргэний нисэхийн тээврийн бодлого төлөвлөлт, журам, дүрэм, аргачлал, удирдамж, эрх зүйн баримт бичгийг боловсруулах, батлуулах, бодлого төлөвлөгөөний биелэлтийг удирдлага, зохицуулалтаар хангах, тайлагнах;

2.2.7. яамны үйл ажиллагааны дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээг сайжруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, дүн шинжилгээ хийх, бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх,

хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад хяналт, шалгалт хийх, эрсдэлийн удирдлага, зөвлөмжөөр хангах;

2.2.8.салбарын стандартын хэрэгжилтийг хангуулах, стандарт, техникийн зохицуулалтын баримт бичгийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх, салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх.

2.3.Үйл ажиллагааны эрхэм зорилго:

Эдийн засгийн өсөлтийг тэтгэх, эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрийг хангах, дэвшилтэт шинэ технологид суурилсан оновчтой тээвэр, логистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлж, төрийн үйл ажиллагааны ил тод байдлыг ханган хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн аюулгүй, ая тухтай, хямд, өрсөлдөхүйц чанартай, өндөр бүтээмжтэй, үр ашигтай, байгаль орчинд ээлтэй тээврийн үйлчилгээг бий болгоход оршино.

2.4.Үйл ажиллагааны стратегийн зорилт:

Яам нь эрхэм зорилгынхоо хүрээнд доор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ:

2.4.1.судалгаа, шинжилгээ, өндөр технологид суурилсан зам, тээврийн салбарын нэгдсэн бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, хуурай боомт, тээвэр логистикийн бодлогын уялдааг хангах, хамтын ажиллагаа, салбарын хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, ажлын байр нэмэгдүүлэх, салбарын хүний нөөцийг бүрдүүлэх чиглэлээр нэгдсэн бодлого төлөвлөх, салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, стандарт, норм, нормативыг боловсронгуй болгох, боловсруулах, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах;

2.4.2.төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, яамны албан хаагчдын ажиллах нөхцөлийг хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, яамны хүний нөөцийн хөгжлийг удирдлагаар хангах, салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгоход арга зүйгээр хангах, зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, баримт бичгийн эрх зүйн үндэслэлийг хянах, салбарын гадаад хамтын ажиллагааны бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, төсөв санхүүгийн удирдлага, зарцуулалт, зохицуулалтад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах;

2.4.3.авто замын салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, батлуулах, бодлогын удирдамжаар хангах, салбарын хөрөнгө оруулалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, авто замын ашиглалтын бэлэн байдал, хүний нөөц бэлтгэх, мэргэшүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, агаар, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааг салбарын нэгдсэн бодлоготой уялдуулан зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;

2.4.4.автотээврийн салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, батлуулах, бодлогын удирдамжаар хангах, салбарын хөрөнгө оруулалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, автотээврийн салбарын аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангах, хүний нөөц бэлтгэх, мэргэшүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, агаар, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааг салбарын нэгдсэн бодлоготой

уялдуулан зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;

2.4.5.төмөр зам, далай ашиглалт болон усан замын тээврийн салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, батлуулах бодлогын удирдамжаар хангах, салбарын хөрөнгө оруулалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, төмөр зам, далай ашиглалт болон усан замын тээврийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангах, хүний нөөц бэлтгэх, мэргэшүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, агаар, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааг салбарын нэгдсэн бодлоготой уялдуулан зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;

2.4.6.иргэний нисэхийн салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, батлуулах, бодлогын удирдамжаар хангах, салбарын хөрөнгө оруулалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангах, хүний нөөц бэлтгэх, мэргэшүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, агаар, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааг салбарын нэгдсэн бодлоготой уялдуулан зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;

2.4.7.салбарын хууль тогтоомж, бодлогын төлөвлөлт, хэрэгжилтэд шинжилгээ хийх, харьяа байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдолд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх, дүгнэлт, зөвлөмж өгөх, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, хэрэгжилтийг зохион байгуулах, байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;

2.4.8.салбарын хэмжээнд эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг төлөвлөх, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ, техникийн баримт бичиг, техникийн зохицуулалт, стандартын хэрэгжилтийг хангуулах, зам, тээврийн салбарын үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээнээс учирч болзошгүй эрсдэл, аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийн удирдлагаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.

2.5.Үйл ажиллагааны гол зорилт:

Яамны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд доор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг хэрэгжүүлнэ:

2.5.1.Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.1.1.зам, тээврийн салбарын нэгдсэн бодлого төлөвлөлт, тээвэр логистикийн сүлжээ, хуурай боомтын төлөвлөлтийг боловсруулах, хэрэгжилтийг бодлогын нэгдсэн арга зүй, удирдамжаар хангах;

2.5.1.2.эрхлэх асуудлын хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийг салбарын бодлоготой уялдуулах, төлөвлөх, гадаад хамтын ажиллагааны бодлоготой уялдуулж хөрөнгө оруулалт татах асуудлыг төлөвлөх, хөрөнгө

оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, салбар дундын уялдааг хангах, төсөл, хөтөлбөрийг боловсруулах, нэгдсэн бодлогын удирдамжаар хангах;

2.5.1.3.эрхлэх асуудлын хүрээнд судалгаа, эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг салбарын бодлогод нийцүүлэн боловсруулах, төлөвлөх, судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг бодлого төлөвлөлтөд ашиглах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, салбарын стандарт, норм, нормативыг боловсронгуй болгох, боловсруулах, үйл ажиллагааг зохион байгуулах, бодлогын удирдамжаар хангах;

2.5.1.4.дэвшилтэт шинэ технологид суурилсан тээврийн удирдлага, хяналтын нэгдсэн системийг хөгжүүлэх, салбарын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, үйл ажиллагааг цахимжуулах, төрийн цахим нэгдсэн системд нийцүүлэх, иргэд, олон нийтэд үйлчлэх, мэдээллийн аюулгүй байдал, хэвийн ажиллагааг хангах, хамгаалах, хөгжүүлэх;

2.5.1.5.салбарын хүний нөөцийн нэгдсэн бодлого, хөтөлбөр боловсруулах, хүний нөөцийн сургалтыг зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих, бодлогын удирдамжаар хангах;

2.5.1.6.яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагуудын хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах;

2.5.1.7.салбарын үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;

2.5.1.8.зам, тээврийн салбараас үүдэлтэй агаар, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааг нэгдсэн удирдамжаар хангах.

2.5.2.Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.5.2.1.яамны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах, төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, яамны албан хаагчдын ёс зүйтэй ажиллах нөхцөл, албан хаагчдын чадавхыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах;

2.5.2.2.яамны хүний нөөцийн хөгжлийн бодлого, сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилтийг хангах;

2.5.2.3.салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгоход арга зүйгээр хангах, зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, салбарын баримт бичгийн эрх зүйн үндэслэлийг хянах;

2.5.2.4.салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, үйл ажиллагааг зохицуулах;

2.5.2.5.төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг боловсруулах, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, хэрэгжилтийг зохион байгуулах;

2.5.2.6.яамыг төлөөлж шүүх, прокурор, холбогдох хууль, хяналтын байгууллагатай харилцах;

2.5.2.7.эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтийг хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

2.5.2.8.салбарын шагнал, урамшууллын асуудлыг эрхлэх, мэдээллийн санг бүрдүүлэх;

2.5.2.9.иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих.

2.5.3.Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

2.5.3.1.авто замын салбарын урт, дунд хугацааны стратеги, хөгжлийн бодлого, чиглэл тодорхойлох, хууль тогтоомжийн төсөл, журам, дүрэм, аргачлал, норм норматив, удирдамж, эрх зүйн баримт бичгийг боловсруулах, батлуулах;

2.5.3.2.авто замын салбар хоорондын бодлогын уялдааг хангаж, нэгдсэн төлөвлөлт хийх, удирдамжаар хангах;

2.5.3.3.авто замын салбарын тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтийг хангах;

2.5.3.4.авто замын барилга, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дэвшилтэт шинэ технологи нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх;

2.5.3.5.авто замын засвар, ашиглалтын аж ахуйн нэгжийн засаглалыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах;

2.5.3.6.авто замын засвар, арчлалтын төлөвлөгөө боловсруулах, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

2.5.3.7.авто зам, барилга байгууламжийг хууль тогтоомжийн дагуу эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад хүлээн авах, үйл ажиллагааны үндсэн шаардлага, авто замын ашиглалтын бэлэн байдлыг хангуулах, зохион байгуулах;

2.5.3.8.салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлого, ажлын байрыг нэмэгдүүлэх төлөвлөлт, хэрэгжилтийг салбарын нэгдсэн бодлоготой уялдуулж, зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;

2.5.3.9.агаар, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааг салбарын бодлоготой уялдуулах, хэрэгжилтийг хангах;

2.5.3.10.Авто замын салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, хөгжүүлэх.

2.5.4.Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

2.5.4.1.автотээврийн салбарын урт, дунд хугацааны стратеги, хөгжлийн бодлого, чиглэл тодорхойлох, хууль тогтоомжийн төсөл, журам, дүрэм,

аргачлал, удирдамж, эрх зүйн баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

2.5.4.2.олон улсын болон дотоодын автотээвэрлэлтийн сүлжээг өргөтгөх, дамжин өнгөрөх тээврийг дэмжих, салбарын хөрөнгө оруулалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх;

2.5.4.3.авто үйлчилгээ, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулахад чиглэсэн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах;

2.5.4.4.автотээврийн салбарын тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтийг хангах;

2.5.4.5.эрэлтэд нийцсэн тогтвортой, хүртээмжтэй, тээврийн нэгдсэн үйлчилгээг үзүүлэхэд чиглэсэн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, мэргэжлийн удирдлагаар хангах;

2.5.4.6.замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого, хөтөлбөр боловсруулахад холбогдох байгууллагуудыг татан оролцуулах, зөвлөмж гаргах, хэрэгжилтийг зохион байгуулах;

2.5.4.7.салбарын мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх ажлыг салбарын нэгдсэн бодлоготой уялдуулж, зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;

2.5.4.8.агаар, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааг салбарын бодлоготой уялдуулах, хэрэгжилтийг хангах, цахилгаан болон хийн хөдөлгүүрт тээврийн хэрэгслийн хэрэглээг дэмжих;

2.5.4.9.автотээврийн салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, хөгжүүлэх.

2.5.5.Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд:

2.5.5.1.төмөр зам, далай ашиглалт, усан замын тээврийн салбарын урт, дунд хугацааны стратеги, хөгжлийн бодлого, чиглэлийг тодорхойлох, хууль тогтоомжийн төсөл, журам, дүрэм, аргачлал, удирдамж, эрх зүйн баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

2.5.5.2.төмөр зам, далай ашиглалт болон усан замын тээвэр, далайн боомт, хуурай боомтын төлөвлөлтийг хангах, хөрөнгө оруулалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх;

2.5.5.3.төмөр зам, далай ашиглалт болон усан замын тээврийн аюулгүй үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн зохион байгуулах, зохицуулах, биелэлтийг хангуулах, удирдлагаар хангах;

2.5.5.4.төмөр замын зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ, зөвшөөрөл олгох, бүртгэлжүүлэх;

2.5.5.5.усан замын тээврийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл олгох, бүртгэл хөтлөх, зохицуулах;

2.5.5.6.салбарын мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх ажлыг салбарын нэгдсэн бодлоготой уялдуулж, зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;

2.5.5.7.агаар, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааг салбарын бодлоготой уялдуулах, хэрэгжилтийг хангах;

2.5.5.8.салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, хөгжүүлэх.

2.5.6.Үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд:

2.5.6.1.иргэний нисэхийн салбарын урт, дунд хугацааны стратеги, хөгжлийн бодлого, чиглэлийг тодорхойлох, хууль тогтоомжийн төсөл, журам, дүрэм, аргачлал, удирдамж, эрх зүйн баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

2.5.6.2.агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалт, агаарын харилцааны эрх зүйн зохицуулалтад чиглэсэн бодлого хэрэгжүүлэх, зохицуулах, удирдлагаар хангах;

2.5.6.3.иргэний нисэхийн тогтвортой, хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэхэд чиглэсэн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах;

2.5.6.4.нислэгийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангуулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг хангуулах;

2.5.6.5.салбарын мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх ажлыг салбарын нэгдсэн бодлоготой уялдуулж, зохион байгуулах, хэрэгжилтийг хангах;

2.5.6.6.иргэний нисэхийн салбарын хөрөнгө оруулалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх;

2.5.6.7.агаар, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааг салбарын бодлоготой уялдуулах, хэрэгжилтийг хангах;

2.5.6.8.иргэний нисэхийн салбарын мэдээллийн санг бүрдүүлэх, хөгжүүлэх.

2.5.7.Үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд:

2.5.7.1.зам, тээврийн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, хэрэгжилтийг хангах;

2.5.7.2.зам, тээврийн салбарын бодлого, төлөвлөлт, холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, хэрэгжилтийг хангах;

2.5.7.3. яам, агентлаг, харьяа байгууллагын үйл ажиллагаа, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах, хэрэгжилтийг хангах;

2.5.7.4. яамны харьяа байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны тайлан, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад дотоод аудит хийж, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах, хэрэгжилтийг хангах;

2.5.7.5. байгууллагын үйл ажиллагааны дотоод аудит хийх, зөвлөмжөөр хангах, хэрэгжилтийг хангах.

2.5.8. Үйл ажиллагааны стратегийн 8 дугаар зорилтын хүрээнд:

2.5.8.1. авто зам, автотээвэр, усан зам, төмөр замын салбарын хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалт, норм, нормативын хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах;

2.5.8.2. аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, зөрчлийг таслан зогсоох, хариуцлага хүлээлгэх, эрсдэл, аюулаас урьдчилан сэргийлэх;

2.5.8.3. хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн ангилалд тулгуурлан салбарын хяналт шалгалтын бодлого, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, үр дүнд хяналт тавих;

2.5.8.4. аймаг, нийслэл, эрхэлсэн асуудлын хүрээнд хамаарах хяналтын нэгж, байгууллага, улсын байцаагчдыг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах, улсын байцаагчийн эрх олгох, цуцлах;

2.5.8.5. зам, тээврийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, ослоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих.

2.6. Үйл ажиллагааны зорилт:

Яамны үйл ажиллагааны гол зорилтын хүрээнд хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтуудыг тодорхойлж, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги болон албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод тусган хэрэгжүүлнэ.

2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар:

Яамны үйл ажиллагааны стратегийн загварыг дараах байдлаар тодорхойлж байна:

Яамны үйл ажиллагааны стратегийн загвар

Эрхэм зорилго

Эдийн засгийн өсөлтийг тэтгэх, эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрийг хангах, оновчтой тээвэр, логистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлж, төрийн үйл ажиллагааны ил тод байдалд тулгуурласан, хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцсэн аюулгүй, ая тухтай, өртөг багатай, өрсөлдөхүйц чанартай, өндөр бүтээмжтэй, дэвшилтэт шинэ технологид суурилсан, үр ашигтай, байгаль орчинд ээлтэй тээврийн үйлчилгээг бий болгох, хөгжүүлэхэд оршино.

Үйл ажиллагааны зорилт

Судалгаа, шинжилгээ, өндөр технологид суурилсан зам, тээврийн салбарын нэгдсэн бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, хуурай боомт, тээвэр логистикийн бодлогын уялдааг хангах, хамтын ажиллагаа, салбарын хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, ажлын байр нэмэгдүүлэх, салбарын хүний нөөцийг бүрдүүлэх нэгдсэн бодлого төлөвлөх, салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, стандарт, норм, нормативыг боловсронгуй болгох, боловсруулах, бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах.

Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, яамны албан хаагчдын ажиллах нөхцөлийг хангах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, яамны хүний нөөцийн хөгжлийг удирдлагаар хангах, салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгоход арга зүйгээр хангах, зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, баримт бичгийн эрх зүйн үндэслэлийг хангах, салбарын гадаад хамтын ажиллагааны бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, төсөв санхүүгийн удирдлага, захиралт, зохицуулалтад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах.

Авто замын салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, батлуулах, бодлогын удирдамжаар хангах, салбарын хөрөнгө оруулалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, авто замын ашиглалтын бэлэн байдал, хүний нөөц, бэлтгэж, мэргэжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, агаар орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааг салбарын нэгдсэн бодлоготой уялдуулан зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.

Автотээврийн салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, батлуулах, бодлогын удирдамжаар хангах, салбарын хөрөнгө оруулалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, автотээврийн салбарын аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангах, хүний нөөц, бэлтгэж, мэргэжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, агаар орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааг салбарын нэгдсэн бодлоготой уялдуулан зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.

Төмөр зам, далай ашиглалт болон усан замын тээврийн салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, батлуулах бодлогын удирдамжаар хангах, салбарын хөрөнгө оруулалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, төмөр зам, далай ашиглалт болон усан замын тээврийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангах, хүний нөөц, бэлтгэж, мэргэжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, агаар орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааг салбарын нэгдсэн бодлоготой уялдуулан зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.

Иргэний нисэхийн салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, батлуулах, бодлогын удирдамжаар хангах, салбарын хөрөнгө оруулалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангах, хүний нөөц, бэлтгэж, мэргэжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, агаар орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааг салбарын нэгдсэн бодлоготой уялдуулан зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.

Салбарын хууль тогтоомж, бодлогын төлөвлөлт, хэрэгжилтэд шилжилтээ хийж, харьяа байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдолд хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хийж, дүгнэлт, зөвлөмж өгөх, зөвлөмжийн дэвшилтэт хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийж, хэрэгжилтийг зохион байгуулах, байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.

Салбарын хэмжээнд эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг төлөвлөх, төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, хууль тогтоомж, нийтлэр дагал мөрдөж хэм хэмжээ, техникийн баримт бичэг, техникийн зохицуулалт, стандартын хэрэгжилтийг хангуулах, зам, тээврийн салбарын үйл ажиллагаа, удирдлагаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, удирдлагаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх.

Үйл ажиллагааны гол зорилт

- Нэгдсэн бодлого төлөвлөлт, тээвэр логистикийн сүлжээ, хуурай боомтын төлөвлөлтийг боловсруулах, салбарын стандарт, норм, нормативыг боловсронгуй болгох;
- Төр, хувийн хэвшлийн түншлэлийг салбарын бодлоготой уялдуулах, төлөвлөх, гадаад хамтын ажиллагааны бодлоготой уялдуулж хөрөнгө оруулалт татах асуудлыг төлөвлөх, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, салбар дундын уялдааг хангах;
- Эрхлэх асуудлын хүрээнд судалгаа, эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг салбарын бодлогод нийцүүлэн боловсруулах, төлөвлөх, судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг бодлого төлөвлөлтөд ашиглах;
- Дэвшилтэт шинэ технологид суурилсан тээврийн удирдлага, хяналтын нэгдсэн системийг хөгжүүлэх;
- Салбарын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, үйл ажиллагааг цахимжуулах, төрийн цахим нэгдсэн системд нийцүүлэх;
- Салбарын хүний нөөцийн нэгдсэн бодлого, хөтөлбөр боловсруулах, хүний нөөцийн сургалтыг зохион байгуулах, үйлдвэрлэл, үйлчилгээг өргөжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, зохицуулахад зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;

- Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;
- Яамны хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах;
- Яамны хүний нөөцийн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;
- Салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгоход арга зүйгээр хангах, зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, баримт бичгийн эрх зүйн үндэслэлийг хангах;
- Гадаадын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, үйл ажиллагааг нь зохицуулах;
- Төсвийн ерөнхийлөн захиралчийн төсвийн төслийг боловсруулах, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, хэрэгжилтийг зохион байгуулах;

- Авто замын салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, төлөвлөлт, урт, дунд хугацааны стратеги, бодлогын удирдамжаар хангах;
- Авто замын салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Авто замын салбарын тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтийг хангах;
- Авто замын барилга, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, технологийг шинэчлэх, авто замын засвар, ашиглалтын аж ахуйн нэгжийн засаглалыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, дэмжлэг үзүүлэх;
- Авто замын засвар, арчлалтын төлөвлөгөө батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- Авто зам, барилга байгууламжийг хууль тогтоомжийн дагуу ахиулах, үргэлжлүүлэх, ашиглалтад хүлээн авах, үйл ажиллагааны үндсэн шаардлага, авто замын ашиглалтын бэлэн байдлыг хангуулах, зохион байгуулах;

- Автотээврийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, төлөвлөлт, урт, дунд хугацааны стратеги, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах, хяналт тавих;
- Автотээврийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Авто үйлчилгээ, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, бүртгэлийн үйл ажиллагааг зохион байгуулахад чиглэсэн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах;
- Автотээврийн салбарын тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтийг хангах;
- Эрэлтэд нийцсэн тогтвортой, хүртээмжтэй, байгаль орчинд ээлтэй, тээврийн нэгдсэн үйлчилгээг үзүүлэхэд чиглэсэн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого, хөтөлбөр боловсруулахад холбогдох байгууллагуудыг татан оролцуулах, зөвлөмж гаргах, хэрэгжилтийг зохион байгуулах.

- Төмөр зам, далай ашиглалт, усан замын салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, төлөвлөлт, урт, дунд хугацааны стратеги, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах, хяналт тавих;
- Төмөр зам, далай ашиглалт болон усан замын тээврийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Төмөр зам, далай ашиглалт болон усан замын тээврийн аюулгүй үйл ажиллагааг тасралтгүй хэвийн зохион байгуулах, зохицуулах, биелэлтийг хангуулах, удирдлагаар хангах;
- Төмөр замын зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ, зөвшөөрөл олгох, бүртгэлжүүлэх, мэдээллийн сан бий болгож хөгжүүлэх;
- Усан замын тээврийн үйлчилгээг үзүүлэх тусгай зөвшөөрөл олгох, бүртгэл хөтөлх, зохицуулах.

- Иргэний нисэхийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, төлөвлөлт, урт, дунд хугацааны стратеги, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах, хяналт тавих;
- Иргэний нисэхийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалт, агаарын харилцааны эрх зүйн зохицуулалтад чиглэсэн бодлого хэрэгжүүлэх, зохицуулах, удирдлагаар хангах;
- Иргэний нисэхийн тогтвортой, хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэхэд чиглэсэн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах;
- Нислэгийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангуулах, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг хангуулах.

- Зам, тээврийн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, олон улсын гэрээ, хэлцлээрт хяналт-шинжилгээ хийж, байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, хэрэгжилтийг хангах;
- Зам, тээврийн салбарын бодлого, төлөвлөлт, холбогдох эрх зүйн актын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, хэрэгжилтийг хангах;
- яам, агентлаг, харьяа байгууллагын үйл ажиллагаа, гомдолд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, зөвлөмж гаргах, хэрэгжилтийг хангах;
- Сайдын эрхлэх асуудлын хүрээний яам, агентлаг, төрийн өмчит хуулийн этгээд, байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад дотоод аудит хийж, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах, хэрэгжилтийг хангах;
- Байгууллагын үйл ажиллагааны дотоод аудит хийж, зөвлөмж гаргах, хэрэгжилтийг хангах.

- Авто зам, авто тээвэр, усан зам, төмөр замын салбарын хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалт, норм, нормативын хэрэгжилтэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах;
- Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, зөрчлийг таслан зогсоох, харилцааг хүлээлгэх, эрсдэл, аюулаас урьдчилан сэргийлэх;
- Хяналт шалгалтын объектын эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийн ажиллалд тулгуурлан салбарын хяналт шалгалтын бодлого, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, үр дүнд хяналт тавих;
- Аймаг, нийслэл, эрхлэсэн асуудлын хүрээнд хамаарах хяналтын нэгж, байгууллага, улсын байцаагчдыг мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах, улсын байцаагчийн эрх олгох, цуцлах;
- Зам, тээврийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, ослоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих.

Гурав.Яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүрэг

3.1.Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим:

Яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад доор дурдсан зарчмыг баримтлав:

3.1.1.яамны стратегийн зорилтыг бүтцэд тусгасан байх зарчим (яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүний үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх);

3.1.2.эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим (зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх);

3.1.3.үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал яамны бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх);

3.1.4.бүтцийн хувьд энгийн байх зарчим (яамны Төрийн нарийн бичгийн даргаас хамгийн доод нэгжээ хүртэл гурваас дээшгүй шат дамжлагатай байх);

3.1.5.тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим (байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байх);


3.1.6.улс төрөөс ангид байх зарчим (яамны Төрийн захиргааны албан хаагч нь сайд, Засгийн газар (танхим), бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй, төвийг сахисан өндөр мэргэшлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх);

3.1.7.хангалттай чадавх, бодитой үйл ажиллагааны зарчим (үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхаа бүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).

3.2.Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар:

Яамны бүтэц нь дээрх зарчим болон үйл ажиллагааны загварыг үндэслэн доор дурдсан ерөнхий тогтолцооны загвартай байна.

Зам, тээврийн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар



3.3. Зохион байгуулалтын бүтэц:

Яамны үйл ажиллагааны стратегийн болон үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн яамны зохион байгуулалтын бүтцийн нэгж, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүргийг дараах байдлаар тодорхойлж байна:

3.3.1. Бодлого, төлөвлөлтийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд Салбарын хөрөнгө оруулалтын төлөвлөлт, судалгаа, шинжилгээ, өндөр технологид суурилсан зам, тээврийн салбарын нэгдсэн бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, хуурай боомт, тээвэр логикийн бодлогын уялдааг хангах, хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэл, ажлын байр нэмэгдүүлэх, салбарын хүний нөөцийг бүрдүүлэх, салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, стандарт, норм, норматив, техник, технологи нэвтрүүлэх, хөгжүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

Үүний тулд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд: зам, тээврийн салбарын нэгдсэн бодлого, төлөвлөлт, төсөл, хөтөлбөрийг боловсруулах, салбарын хүний нөөцийн бодлого, хөтөлбөр боловсруулах, хөрөнгө оруулалтын бодлого, үр өгөөжийг нэмэгдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, яам, агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллага хоорондын болон аймаг, нийслэлийн захиргааны байгууллагын ажиллагааг уялдуулан зохицуулах, Улсын Их Хурал болон Засгийн газартай харилцах, зам, тээврийн салбарын чиглэлээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлыг нэгтгэн зохион байгуулж удирдлагаар

хангах, судалгаа, шинжилгээ, салбарын мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, статистик мэдээлэл гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх, тээврийн ухаалаг нэгдсэн системийг хөгжүүлэх, цахим үйлчилгээг боловсронгуй болгох, салбарын стандарт, норм, нормативыг боловсронгуй болгох үйл ажиллагааг зохион байгуулах, салбарын хүрээнд судалгаа, эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг салбарын бодлогод нийцүүлэн боловсруулах, төлөвлөх, судалгаа, шинжилгээний үр дүнг практикт нэвтрүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, тээврийн салбараас үүдэлтэй агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр төсөл, хөтөлбөр боловсруулахад санал өгөх, тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд Судалгаа, стандарт, статистикийн нэгж, Мэдээллийн технологийн нэгж ажиллана.

Энэ нэгжийн үйл ажиллагаа зам, тээврийн салбарын нэгдсэн бодлого, яамны гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, төсөв, хөрөнгө оруулалтын төсөл боловсруулж, түүнийг хэлэлцүүлэн батлуулах замаар "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Шинэ сэргэлтийн бодлого", Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх бодлого, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, харьяа агентлаг, төв, байгууллага байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд хамтран ажиллах байгууллага нь сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд, холбогдох бусад яам, агентлаг, Үндэсний статистикийн хороо, гадаад улс, олон улсын байгууллага, хандивлагч, хөрөнгө оруулагчид байна.

3.3.2.Төрийн захиргааны удирдлагын нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгоход арга зүйгээр хангах, зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, баримт бичгийн эрх зүйн үндэслэлийг хянах, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, төсөв, санхүүгийн удирдлага, зарцуулалтад, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах үндсэн үүрэг хүлээж ажиллана.

Энэ хүрээнд яамны удирдлага, албан хаагчдын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хүний нөөцийг бүрдүүлэх, сургаж хөгжүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, олон нийттэй харилцах, салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгоход арга зүйгээр хангах, зөвлөгөө, туслалцаа үзүүлэх, баримт бичгийн эрх зүйн үндэслэлийг хянах, гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, зохицуулах, зохион байгуулах, төсөв, санхүүгийн удирдлага, зарцуулалт, хэрэгжилтийг зохион байгуулах, яам болон агентлаг, харьяа байгууллагуудад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд Хуулийн нэгж, Гадаад хамтын ажиллагааны нэгж, Санхүүгийн нэгж ажиллана.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь цомхон, чадварлаг төрийн албан хаагч бүхий мэргэшсэн албыг бүрдүүлж, яамны үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй, шуурхай байдлыг хангахад чиглэгдэнэ.

Энэ нь яамны дотоод үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах, гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах, түүний биелэлт, үр дүнг тооцох, яамны удирдлага, албан хаагчдын үйл ажиллагаанд эрх зүйн туслалцаа болон дотоод үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, байгууллагын соёл, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, албан хаагчид, сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь аж ахуйн нэгж, иргэд, бусад хэрэглэгч байна.

Энэ нэгжийн үйлчилгээ үзүүлэхэд хамтран ажиллах байгууллага нь Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Үндэсний аудитын газар, архивын болон боловсрол, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд, холбогдох бусад яам, агентлаг байна.

3.3.3.Авто замын бодлого зохицуулалтын нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд авто замын салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үндсэн үүрэг хүлээж ажиллана.

Энэ хүрээнд авто замын салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, авто замын барилга, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, шинэ дэвшилтэт технологийг ашиглах, авто зам, засвар арчлалтын аж ахуйн нэгжийн засаглалыг сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, стандарт, норм, нормативыг боловсруулах, авто зам, барилга байгууламжийг хууль тогтоомжийн дагуу эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад хүлээн авах, зохицуулах, авто замын сүлжээний ашиглалтын бэлэн байдлыг хангах, үйл ажиллагааны үндсэн шаардлага, авто замын ашиглалтын бэлэн байдлыг хангуулах, зохион байгуулах, засвар, арчлалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих, авто зам, замын байгууламжийн ашиглалт, аюулгүй байдлыг дээшлүүлэх, авто замын салбарын тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтийг хангах, зохицуулах, дэмжлэг үзүүлэх, чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд Замын ашиглалт, засварын нэгж ажиллана.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, харьяа байгууллага, авто замын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд хамтран ажиллах байгууллага нь сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд, холбогдох бусад яам, агентлаг байна.

3.3.4.Автотээврийн бодлого зохицуулалтын нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд автотээврийн салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үндсэн үүрэг хүлээж ажиллана.

Энэ хүрээнд автотээврийн хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, дэмжлэг үзүүлэх, салбарын хөрөнгө оруулалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх, улс, аймаг болон хот хоорондын тээврийн бодлого төлөвлөх, тээврийн аюулгүй байдлыг хангах, салбарын техникийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах, стандарт, норм, нормативыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хангуулах, олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, авто үйлчилгээ, тээврийн хэрэгслийн техникийн хяналт, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хэрэгжүүлэх, автотээврийн салбарын тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг зохион байгуулах, салбарын хүний нөөц бэлтгэх, мэргэшүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, агаар, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааг салбарын бодлоготой уялдуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, тээвэрлэлтийн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах бодлогын хэрэгжилтийг хангах, зөвлөмж гаргах, дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд Тээвэр зохион байгуулалтын нэгж болон Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн ажлын алба ажиллана.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Зам, тээврийн сайдаас автотээврийн салбарт хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, иргэдэд аюулгүй, хүртээмжтэй, тасралтгүй автотээврийн үйлчилгээг үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, харьяа байгууллага, автотээврийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд хамтран ажиллах байгууллага сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд, холбогдох бусад яам, агентлаг байна.

3.3.5.Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд төмөр зам, далай ашиглалт болон усан замын тээврийн салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үндсэн үүрэг хүлээж ажиллана.

Энэ үндсэн үүргийн хүрээнд төмөр зам, далай ашиглалт болон усан замын тээврийн салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх, далайн боомт, хуурай боомтын төлөвлөлтийг боловсруулах, ашиглалтыг сайжруулах, төмөр замын тээврийн үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах ажлыг зохион байгуулах, төмөр зам, усан замын тээврийн аюулгүй байдлыг хангах, төмөр замын сүлжээг нэмэгдүүлэх, стандарт, норм, нормативыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, төмөр замын суурь бүтэц барих, засварлах, хөдлөх бүрэлдэхүүний парк шинэчлэл, дохиолол, холбоонд дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, төмөр зам, далайн тээвэр, усан замын зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ, зөвшөөрөл олгох, бүртгэлжүүлэх, зурвас газрын ашиглалт, хамгаалалттай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, салбарын хүний нөөц бэлтгэх, мэргэшүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, агаар, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааг салбарын бодлоготой уялдуулах, мэдээллийн сан бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн чиг үүргийн хүрээнд Төмөр замын тээврийн нэгж болон Далай ашиглалт, усан замын тээврийн нэгж ажиллана.

Энэ нь Зам, тээврийн сайдыг төмөр зам, далай ашиглалт болон усан замын тээврийн салбарын бодлогыг хэрэгжүүлэхтэй холбогдсон шийдвэр гаргахад шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэгээр хангах, салбарын байгууллага, аж ахуйн нэгж, яамны удирдлага, аппаратыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, салбарын байгууллага, аж ахуйн нэгж, нутгийн захиргааны байгууллага, иргэд байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд хамтран ажиллах байгууллага нь сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага, холбогдох бусад яам, агентлаг байна.

3.3.6.Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 6 дугаар зорилтын хүрээнд иргэний нисэхийн салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохион

байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үндсэн үүрэг хүлээж ажиллана.

Энэ үндсэн үүргийн хүрээнд иргэний нисэхийн салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хөрөнгө оруулалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх, стандарт, норм, нормативыг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хангуулах, агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалт, агаарын харилцааны эрх зүйн зохицуулалтад чиглэсэн бодлого хэрэгжүүлэх, удирдлагаар хангах, иргэний нисэхийн тогтвортой, хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэхэд чиглэсэн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, нислэгийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангуулах, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг хангуулах салбарын боловсон хүчин бэлтгэх, мэргэшүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, агаар, орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааг салбарын бодлоготой уялдуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Зам, тээврийн сайдаас иргэний нисэхийн салбарт хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, аюулгүй байдлыг хангахад чиглэнэ.

Энэ нь Зам, тээврийн сайдыг иргэний нисэхийн салбарын бодлогыг хэрэгжүүлэхтэй холбогдсон шийдвэр гаргахад шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэгээр хангах, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, харьяа агентлаг, байгууллага байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд хамтран ажиллах байгууллага нь сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд, холбогдох бусад яам, агентлаг, иргэд байна.

3.3.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 7 дугаар зорилтын хүрээнд зам, тээврийн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, яам, харьяа байгууллагын үйл ажиллагаа, тэдгээрт ирүүлсэн өргөдөл, гомдолд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх үндсэн үүрэг хүлээж ажиллана.

Энэ хүрээнд хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгавар, хөгжлийн бодлогын баримт бичиг, хөтөлбөр, төсөл, олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргаж, гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, яам, харьяа байгууллагын үйл ажиллагаа, тэдгээрт ирүүлсэн өргөдөл, гомдолд, хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, санхүү, төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, дүгнэлт, зөвлөмж

гаргах, байгууллагын үйл ажиллагаанд чиглэсэн дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлага, мэргэжил, арга зүйн зөвлөгөө үзүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь яамны бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, төсөв, хөрөнгийн зарцуулалтын үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Энэ нь салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлтийг үнэлэх, дүн шинжилгээ хийх, мэдээллийг нэгтгэх, харьцуулан судлах, гарч байгаа хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, эрсдэлийн удирдлагаар хангаж үнэн зөв, бодит мэдээллээр удирдлага, яамны аппарат, хэрэглэгч, иргэдийг хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, сайдын эрхлэх ажлын хүрээний Засгийн газрын агентлаг, байгууллага байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь нутгийн захиргааны байгууллага байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд хамтран ажиллах байгууллага нь сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд, холбогдох бусад яам, агентлаг, иргэд, олон нийт, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага байна.

3.3.8. Салбарын хяналт шалгалтын нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 8 дугаар зорилтын хүрээнд зам, тээврийн салбарын хэмжээнд төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх үндсэн үүрэг хүлээж ажиллана.

Энэ хүрээнд зам, тээврийн салбарын хууль тогтоомж, дүрэм, журам, техникийн зохицуулалт, стандарт, норм, нормативын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, арга зүй, зохион байгуулалтаар хангах, зам, тээврийн салбарын техник, технологийн аюулгүй ажиллагаа, ослоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Мөн энэхүү нэгж нь хяналт шалгалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн санг хөтлөх, хяналт шалгалтын үйл ажиллагаанд шинжлэх ухаан, технологийн ололт, олон улсын дэвшилтэт арга, аргачлалыг нэвтрүүлэх, аймаг, нийслэл дэх хяналтын нэгж, улсын байцаагчдыг шуурхай удирдлага, зохион байгуулалтаар хангах, улсын байцаагчийн эрх олгох, цуцлах, салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг холбогдох мэдээ, мэдээллээр хангах, хамтран ажиллах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь авто зам, төмөр замын барилга байгууламжийн зураг төсөл, төсөв, барилга угсралт, засвар арчлалтын чанар, ашиглалт, төмөр зам, усан зам, автотээврийн хэрэгслийн ашиглалт, техникийн бүрэн бүтэн байдал, найдвартай ажиллагаа, тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангуулах, эрсдэл, ослоос урьдчилан сэргийлэх, хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг хамгаалахад чиглэнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь сайдыг зам, тээврийн салбарын бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой шийдвэр гаргахад шаардлагатай шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэгээр хангах, зам, тээврийн салбарын хяналтын бодлогыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн ажлын уялдаа холбоог хангах, салбарын техник, технологийг шинэчлэх, шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний төсөл хэрэгжүүлэхэд хамтран ажиллах, олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, яамны удирдлага, аппаратыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Сайдын эрхлэх ажлын хүрээний Засгийн газрын агентлаг, байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэн байх бөгөөд шууд бус хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд хамтран ажиллах байгууллага нь нутгийн захиргааны байгууллага, хяналтын бусад байгууллага, сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд, холбогдох бусад яам, агентлаг, иргэд, олон нийт, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага байна.

----o0o----



**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ**

2021 оны 12 сарын 30 өдөр

Дугаар ...08

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм"-ийн 7.7, Дотоод аудитын хорооны 2021 оны 12 дугаар сарын 25 -ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Зам, тээврийн хөгжлийн яамны Дотоод аудитын хорооны гишүүдийн 100 хувийн саналаар Зам, тээврийн хөгжлийн яамны 2022 онд харъяа байгууллага, газруудад санхүүгийн хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, дотоод аудитаар хийх ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар / М.Энхболд/-т үүрэг болгосугай.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД,
ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА



М.ЭНХБОЛД

Зам, тээврийн хөгжлийн яамны Дотоод аудлтын хорооны оны сарын өдрийн дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ХАРЪЯА БАЙГУУЛЛАГА, САН, ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРТ
2022 ОНД ХИЙХ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/А	Байгууллага, төслийн нэр	Хяналт шалгалтад хамрагдах он	Шалгалт хийх хугацаа	Хяналт шалгалтыг хариуцан явуулах албан тушаалтан	Тайлбар
1.	"МИАТ" ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	2021 он	4 сар	ХШУДАГ-ын дарга М.Энхболд шалгалтыг ахлах	
2.	"Завхан АЗЗА" ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	2020-2021	6 сар	ХШУДАГ-ын дарга М.Энхболд шалгалтыг ахлах	
3.	"Архангай АЗЗА" ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	2020-2021	5 сар	ХШУДАГ-ын дарга М.Энхболд шалгалтыг ахлах	

Зам, тээврийн хөгжлийн яамны Дотоод аудитын хорооны 2022 оны 12 сарын 30 өдрийн 18 дугаар тогтоолын 2 дугаар хэсэрт

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ХАРЪЯА БАЙГУУЛЛАГА, САН, ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРТ 2022 ОНД ХИЙХ ДОТООД АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Байгууллага, төслийн нэр	Дотоод аудитад хамрагдах он	Дотоод аудит хийх хугацаа	Дотоод аудитыг хариуцан явуулах албан тушаалтан	Тайлбар
1.	Иргэний нисэхийн ерөнхий газар /худалдан авах ажиллагаа/	2020 он	2 сар 18	ХШУДАГ-ын дарга М.Энхболд ахална	
2.	"МТЗ" ТӨХК-ийн албан хэрэг хөтлөлт, тушаал шийдвэрийн хэрэгжилтэд	2020 он	9 сар 18	ХШУДАГ-ын дарга М.Энхболд ахлах	
3.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд	2022 он	10 сар	ХШУДАГ-ын дарга М.Энхболд ахлах	



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН 2022 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ

- ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН -

Тайлангийн хамрах хугацаа

2022.01.01-2022.12.31

Тайлан илгээгч:

Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ,
дотоод аудитын газрын дарга

А.Мөнхбат

Боловсруулсан:

Санхүүгийн хяналт шалгалт
хариуцсан шинжээч

У.Эрдэнэчимэг

Улаанбаатар хот

2022.12.28

Үйл ажиллагааны тайлангийн талаархи МЭДЭГДЭЛ

2022 оны жилийн эцсийн санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагааны тайланг холбогдох хууль, дүрэм журмын дагуу бэлтгэсэн болно.

Тайлан нь Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тайлант хугацаанд хийгдсэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын 2022 оны Үр дүнгийн гэрээнд тусгагдсан үйл ажиллагааны үр дүнг иж бүрэн, үнэн зөв илэрхийлсэн гэж үзэж байна.

Тайлан илгээгч:

Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга

А.Мөнхбат

Тайлан хүлээн авагч:

Сангийн яамны Санхүүгийн хяналт, Эрсдэлийн удирдлагын газрын дарга

Б.Доржсэмбэд

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН 2022 ОНД САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД
АУДИТЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

Нэг. Ерөнхий мэдээлэл

Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас (цаашид ХШҮДАГ гэх) 2022 онд Зам, тээврийн салбарын хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, олон улсын гэрээ хэлэлцээрийн биелэлтэд хяналт шинжилгээ хийж, үр дүнд нь үнэлгээ өгөх, салбарын төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж эрсдэлийн удирдлагаар хангах, яамны болон харьяа агентлаг, байгууллагуудын төсөв санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, санхүүгийн үйл ажиллагааг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил дутагдлыг арилгуулах зорилтын хүрээнд ажиллаж үр дүнг тооцон ажиллалаа.

Тус газар нь Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм", Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн хяналт шалгалтын стандарт", "Улсын салбарын дотоод аудитын аргачлал зэргийг удирдлага болгон Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан удирдамжийн хүрээнд хэрэгжүүлж ирсэн.

Яамнаас дэвшүүлсэн 2022 онд хэрэгжүүлэх бодлогын зорилтыг хэрэгжүүлэх үүднээс ХШҮДАГ-аас *"Яам, харьяа агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, зөвлөмж гаргах, дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэх", "Салбарын төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад дотоод хяналт шалгалт хийх, эрсдлээс урьдчилан сэргийлэх"* гэсэн гол зорилтын хүрээнд:

2022 онд Сайд, Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжаар санхүүгийн хяналт шалгалтаар төлөвлөгөөт 1, төлөвлөгөөт бус 7, дотоод аудитаар төлөвлөгөөт 2, төлөвлөгөөт бус 3 ажил хийгээд байна. Тайлант жилд Дотоод аудитын хорооны хурал 2 удаа хуралдаж, Дотоод аудитын хорооны тогтоол гарч холбогдох байгууллагуудад хүргүүлж тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Хоёр. Төлөвлөгөөт хяналт шалгалт, дотоод аудит:

- Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 09-01/015 дугаар удирдамжаар "Архангай АЗЗА" ТӨХК-ийн 2020-2021 санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалт хийж, хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд 09-01/18 дугаар бүхий улсын ахлах байцаагчийн 7 заалттай албан шаардлага өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажилласнаас гадна Дотоод аудитын хорооны тогтоолоор 9 заалттай зөвлөмж өгч биелэлтийг тооцож ажиллав.

- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/318 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж Иргэний нисэхийн ерөнхий газрын 2020-2021 он, 2022 оны эхний хагас жилийн худалдан авах ажиллагаанд дотоод аудит хийв.

- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 09-01/049 дугаар удирдамжаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах болон эрхлэх асуудлын хүрээний байгууллага, хуулийн этгээдийн 2022 оны 1-3 дугаар улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийж Сайд, Төрийн нарийн бичгийн даргад танилцуулав.

Гурав. Төлөвлөгөөт бус хяналт шалгалт, дотоод аудит:

- Сангийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын хамтарсан 2022 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн Дугаар СХЭУГ-01 удирдамжаар “АТҮТ” ТӨҮГ-ын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж, хяналт шалгалтын бүрэлдэхүүнд орж ажлын 30 хоног ажилласан.

Хяналт шалгалт, дотоод аудитын дүнг Сангийн сайдын Дотоод аудитын хорооны хурлаар хэлэлцүүлсэн болно.

- Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 09-01/009 дугаар удирдамжаар Азийн хөгжлийн банкны МОН-3679/3786 зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажлын техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээний гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлтөд аудит хийж дүнг Зам, тээврийн хөгжлийн сайдад танилцуулав.

- Сангийн сайдын баталсан 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн СХШХ/01 дугаар удирдамжаар “Хууль бус шийдвэрийн улмаас төрийн албанаас халагдсан ажилтнуудад төсвөөс олгосон нөхөн олговор, түүнийг холбогдох хуулийн дагуу буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн эсэх асуудлаар хяналт шалгалт хийх тухай” хяналт шалгалтанд 12 байгууллага, хуулийн этгээдийг хамруулан хяналт шалгалттай холбоотой судалгааг нэгтгэж дүнг Сангийн яамны Санхүүгийн хяналт, Эрсдлийн удирдлагын газарт ХШҮДАГ-ын даргын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 10/1377 дугаар албан бичгээ хүргүүлсэн.

- Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/33 дугаар удирдамжаар “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ-ын албан хаагчдаас Зам, тээврийн хөгжлийн сайдад ирүүлсэн санал, гомдолтой холбогдуулан байгууллагын хүний нөөц, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг шалгах тодруулах, дүгнэлт гаргах аудит хийв. Аудитын дүнг удирдамжид заасан хугацаанд Сайдад танилцуулав.

- Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан удирдамжаар 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдрөөс Далайн захиргааны албан хэрэг хөтлөлт, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж, аудитын дүнг удирдамжид заасан хугацаанд Сайдад танилцуулав.

- “Говь-Алтай АЗЗА” ТӨХК, “Эрдэнэсант АЗЗА” ТӨХК-ийн ажилчдаас ирсэн гомдлын дагуу Төрийн нарийн бичгийн даргын баталсан удирдамжаар хяналт шалгалтыг хийж хариуг хүргүүлэн, удирдамжид заасан хугацаанд удирдлагад танилцуулав.

- Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан 2022 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/259 дугаар тушаалаар Авто замын норм, нормативын сангийн 2020-2021 он, 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд дотоод аудит хийв. Аудитаар илэрсэн зөрчилд улсын ахлах байцаагчийн 5 заалттай албан шаардлага өгч ажиллав. Аудитын дүнг Сайд, Төрийн нарийн бичгийн даргад танилцуулав.

- Төрийн нарийн бичгийн даргын баталсан 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 09-01/046 дугаар удирдамжаар Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн “Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/130 дугаар тушаал, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн “Салбарын өвөлжилтийн бэлтгэлийн хангах төлөвлөгөө батлах тухай” А/214 дугаар тушаалын дагуу төлөвлөгөө гарган, “Баянчандмань АЗЗА” ТӨХК, “Эрдэнэсант АЗЗА” ТӨХК, “Хархорин АЗЗА” ТӨХК, “Авто зам” ХХК-д хяналт шалгалт хийж, хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд зөвлөмж өгч, компанийн захирал, санхүүгийн болон инженер техникийн ажилтнуудад заавар зөвлөмж өгч ажиллав.

Дөрөв. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитаар гарсан нийтлэг зөрчил:

1. Гүйцэтгэх захирлын тушаалаар ажилтан, албан хаагчдад шагнал олгож зардал гаргасан байна. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3-д “... цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г м)-ын зардлыг гаргахгүй байх”, 1.6-д “Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх” гэж заасантай нийцээгүй;

2. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 хэсэг, Засгийн газрын 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 4.1.4 дэх “хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, хөдөлмөрийн дотоод журмын биелэлтэд тавих хяналт шалгалт” заалт, 4.1.5 дахь өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт” заалтыг хангалтгүй хэрэгжүүлсэн;

3. Тайлант онуудад шилэн дансны цахимд байршуулах мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын холбогдох заалтуудыг;

4. 2022 онд зарим нэг ТӨХК-нууд орлогын төлөвлөгөөг тасалдуулсан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Захирал дараах эрх, үүрэгтэй”, 20.1.3 “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулах, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” заалт, Контрактын гэрээний 3.3 “... тухайн жилийн үйл ажиллагааны зорилтот түвшинг контрактын хавсралтад тусгасан үзүүлэлтүүдээр биелүүлэн ашиг орлогыг нэмэгдүүлэх үндсэн үүргийг хүлээнэ” хэсгийг;

5. Албан томилолтын зардлаас анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарцуулалт хийсэн. Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.1

дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” хэсгийг;

6. Аж ахуй нэгж байгууллага, хувь хүмүүсээс худалдан авсан бараа материалын цахим и-баримтыг бүрдүүлээгүй. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” заалтыг;

7. Түлш, шатахууны зардлын анхан шатны баримтын бүрдэл дутуу байна. “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно” хэсгийг тус тус зөрчсөн.

8. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлтэд улсын төсвөөс хэрэгжиж буй Авто замын барилга, засвар, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсвийн ажлын төсөвт өртөгөөс 0.4 хувиар тооцсон орлогыг яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэст хянаж, төрийн санд төвлөрүүлдэг боловч нийслэл болон орон нутаг, мөн хувийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй ажлын өртөгөөс норм, нормативын сангийн 0.4 хувийн орлого дутуу төвлөрдөг байна. Авто замын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн Журам батлах тухай 142 дугаар тушаалаар баталсан “Авто замын норм, нормативын сангийн ажиллах журам”-ын 3.2 хэсгийн хэрэгжилт хангалтгүй байна.

Тав. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт:

Аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах болон эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит хувьцаат компаниудыг хамруулан нийт 88 төрийн байгууллага, хуулийн этгээдийн 2022 оны 1-4 дүгээр улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийснээс гадна Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 09-01/049 дугаар удирдамжийн хүрээнд 2022 оны 1-3 дугаар улирлын Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийв. Салбарын хэмжээнд хуулийн хэрэгжилт 97.1 хувийн биелэлттэй байна.

Харъяа газруудад гарсан нийтлэг зөрчил:

- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт;
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт;
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө;
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв;
- гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт;
- Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл;
- Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө; оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл;
- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл;

- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;
- Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт;
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн;
- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт;
- Санхүүгийн тайлан;
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтийн төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл;
- Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн;
- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг тендерийн хорооны дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор;
- Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбар зэргийг хугацаа хоцроож оруулсан нь Шилэн дансны тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Мөн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн тайланд өгсөн Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх үүднээс Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн “Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/130 дугаар тушаал гарч хугацаатай үүрэг чиглэл өгөв.

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, Үндэсний аудитын газрын 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн № 875/АО110001, АХГ-2022/05/НА-СТА-ТЕЗ албан шаардлагын дагуу Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, үйл ажиллагааны ил тод байдлыг бүрэн хангаж ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, албан шаардлагын биелэлтийг ирүүлэхээр ХШҮДАГ-ын даргын 2022 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн 10/2695 дугаар албан бичгийг холбогдох байгууллага, газруудад хүргүүлсэн.

Албан шаардлагын хэрэгжилтийг хангаж “Хөвсгөл АЗЗА” ТӨХК, “АТҮТ” ТӨҮГ-ын Цогтцэцэй салбар, “Завхан АЗЗА” ТӨХК, “Хархорин АЗЗА” ТӨХК, “Орхон АЗЗА” ТӨХК, “Увс АЗЗА” ТӨХК, “Эрдэнэсант АЗЗА” ТӨХК, ИНЕГ зэрэг байгууллагын шилэн данс хариуцсан холбогдох албан тушаалтнуудад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж хариу ирүүлсэн байна.

Зургаа. Дүгнэлт

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага, сан, төсөл хөтөлбөрт санхүүгийн холбогдолтой хууль тогтоомжийн биелэлт хэрхэн хангагдаж байгаа, үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд байнгын хяналт тавьж ажиллаж байна. Тайлангаар хууль тогтоомжийн биелэлтийн дундаж үзүүлэлт 89.5 хувийн биелэлттэй байна.

Долоо. Сангийн яаманд санал

Төсвийн ерөнхийлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний томоохон байгууллага, ТӨХК, ТӨҮГ-т Сангийн яамнаас санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийхдээ тухайн яамны санхүүгийн улсын /ахлах/ байцаагчид, дотоод аудиторыг оролцуулан хамтарсан ажлын хэсгээр хяналт шалгалтыг зохион байгуулж байх.

Хянасан:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын дарга



А.Мөнхбат

Тайлан бичсэн:

Санхүүгийн хяналт шалгалт
хариуцсан шинжээч



У.Эрдэнэчимэг



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251

Утас: (976-51) 26 71 68, Факс: (976-11) 31 23 15,

Цахим шуудан: info@mrtд.gov.mn,

Цахим хуудас: www.mrtд.gov.mn

додм-01-25 № 10/361

танай _____-ны № _____-т

**САНГИЙН ЯАМНЫ САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА Б.ДОРЖСЭМБЭД
ТАНАА**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах болон эрхлэх асуудлын хүрээний байгууллага, хуулийн этгээдийн 2023 оны жилийн эцсийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайлан, ХШУДАГ-ын 2023 оны санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын чиглэлээр хийсэн ажлын тайланг тус тус хүргүүлж байна.

Хавсралт 7... хуудастай.

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА**

А.МӨНХБАТ



60000400

Боловсруулсан:

Л. Д. Савдугал

Хянасан:

А. [Signature]

Хувь:

1

Огноо:

2024.01.30.

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСВИЙН БАГЦАД
ХАМААРАХ БОЛОН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА,
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН 2023 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН ШИЛЭН ДАНСНЫ
ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

Нэг. Аудит хийх үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ыг тус тус үндэслэн шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийн агуулга, стандартын хэрэгжилтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас аудит хийв.

Хоёр. Дотоод аудитын зорилго:

Улсын төсөв, төрийн өмчийн хөрөнгийг үр ашигтай, захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлага, шийдвэр, үйл ажиллагаа ил тод нээлттэй, ойлгомжтой түүнд олон нийт хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Төсвийн ерөнхийлөн захирагч Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийх, аудитаар мэдээллийн ил тод байдлыг хангуулж, хуулийн хугацаанд мэдээ, тайланг үнэн зөв, иж бүрэн байршуулж хэвшүүлэх, хууль, журмын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгч, илэрсэн зөрчлийг арилгах, засч залруулах, зөвлөмж өгөх, хуулийг хангалтгүй хэрэгжүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг холбогдох байгууллага албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг төсвийн ерөнхийлөн захирагч болон яамны удирдлагуудад танилцуулах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангахад аудитын зорилго оршино.

Гурав. Хамрах хүрээ:

Аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах болон эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит хувьцаат компаниудыг хамруулан нийт 89 байгууллагын 2023 оны 4 дүгээр улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийв. Үүнд:

- Улсын төсвийн байгууллага 3;
- Төсөл, арга хэмжээ 4;
- Төрийн өмчит аж ахуйн нэгж 80;
- Хувь нийлүүлсэн нийгэмлэг 1;
- Төрийн өмчит ХХК 1 байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах болон эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит хувьцаат компаниудыг хамруулан нийт 89 төрийн байгууллага, хуулийн этгээдийн 2023 оны жилийн эцсийн байдлаарх шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийхэд салбарын хэмжээнд 13,591 мэдээлэл байршуулахаас мэдээллэсэн 13,388, үүнээс хугацаа хоцроосон 192, мэдээлэл оруулаагүй 203, гүйцэтгэл 96.0 хувьтай байна.

Харьяа газруудад гарсан нийтлэг зөрчил:

- Дараа жилийн төсвийн төсөл;
- Худалдан авах ажиллагааны тайлан;
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө;
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл;
- Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт;
- Санхүүгийн тайлан;
- Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл;
- Дараа жилийн зорилтот түвшин;

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл- Хөтөлбөр, зориулалт;
- Их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээлэл;
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;
- Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт;
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт;
- Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл;
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэргийг хугацаа хоцроож оруулсан нь Шилэн дансны тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийг зөрчсөн байна.

Оны эхний хагас жилийн байдлаар шилэн дансны хэрэгжилт 95 хувьд хүрээгүй 9 байгууллагад шилэн дансны мэдээллийг хугацаандаа мэдээлэх, алдаа дутагдлаа засан сайжруулах, зөрчлийг давтан гаргасан тохиолдолд холбогдох хуулийн дагуу арга хэмжээ тооцох тухай албан бичиг хүргүүлэн ажилласан.

Дөрөв. Дүгнэлт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах болон эрхлэх асуудлын хүрээний 88 төрийн байгууллага, хуулийн этгээдийн 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийхэд 40 байгууллага Шилэн дансны цахим хуудсанд мэдээллээ хуулийн хугацаанд бүрэн байршуулсан, 26 байгууллага 1, 14 байгууллага 2, 15 байгууллага 3, 12 байгууллага 4-19 мэдээллийг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь салбарын дундаж үнэлгээ буурахад нөлөөлж байна.

Шилэн дансны мэдээлэлд 2023 оны байдлаар Хөндлөнгийн аудит хийхэд байгууллагууд мэдээлэл оруулах хүмүүсийг сонгоогүй, зарим маягтыг бөглөхгүй гэж сонгосноос шалтгаалан тухайн байгууллагын оруулах мэдээлэл дутах алдаа дутагдал маш их илэрсэн тул Сангийн яамнаас сонгоогүй байсан маягтуудыг ил гаргах тохиргоог систем дээр нэгдсэн байдлаар хийсэн байна. Энэ нь оруулаагүй мэдээллийн тоо нэмэгдэхэд нөлөөлжээ.

Иймд 2024 онд мэдээлэл оруулдаггүй маягт нэмэгдсэн тохиолдолд уг маягтуудад оруулах мэдээлэл байхгүй гэж сонгох, хэрэв оруулах мэдээлэл байгаа бол мэдээллээ үнэн зөв оруулан хадгалж, ил тод болгох шаардлагатай байна.

Тав. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

- Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээлэл нь Төсвийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуульд нийцсэн байх;

-“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах;

- Байгууллага тус бүрээр зөвлөмж, мэдэгдэл хүргүүлэн ажиллах.

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

А.МӨНХБАТ

ТАЙЛАН БИЧСЭН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Д.БЯМБАДУЛАМ

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСВИЙН БАГЦАД
ХАМААРАХ БОЛОН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА, ХУУЛИЙН
ЭТГЭЭДИЙН 2023 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

2023.01.25

д/д	Байгууллагын нэр	Оруу лах мэдээл лийн тоо	Оруул сан мэдээл лийн тоо	Үүнээс:		Гүйцэт гэлийн хувь
				Хуга цаан даа	Хоцор сон	
1.	Төсвийн ерөнхийлөн захирагч	142	142	128	14	90.1
2.	Зам, тээврийн хөгжлийн яам	166	166	147	19	88.6
3.	Иргэний нисэхийн ерөнхий газар	166	166	165	1	99.4
4.	Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв	157	157	153	4	97.5
5.	МИАТ ТӨХК	153	129	128	1	83.7
6.	Монголын төмөр зам ТӨХК	165	165	163	2	98.8
7.	Улаанбаатар төмөр зам ХНН	62	62	61	1	98.4
8.	Иргэний нисэхийн үндэсний төв	154	154	153	1	99.4
9.	Иргэний нисэхийн ерөнхий газрын Үйлдвэрлэл үйлчилгээ	154	154	153	1	99.4
10.	Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал	154	154	153	1	99.4
11.	Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын алба	154	154	154	-	100
12.	Нисэхийн эрүүл мэнд, сэргээн засах алба	154	154	154	-	100
13.	Булган аймгийн нисэх буудал	142	142	140	2	98.6
14.	Говь-Алтай аймгийн нисэх буудал	154	154	153	1	99.4
15.	Дорнод аймгийн нисэх буудал	166	166	165	1	99.4
16.	Дундговь аймгийн нисэх буудал	142	142	140	2	98.6
17.	Завхан аймгийн Доной нисэх буудал	154	154	151	3	98.1
18.	Өмнөговь аймгийн нисэх буудал	166	166	166	-	100
19.	Завхан аймгийн Тосонцэнгэл нисэх буудал	154	154	154	-	100
20.	Хэнтий аймгийн нисэх буудал	142	142	138	4	97.2
21.	Баянхонгор аймгийн нисэх буудал	130	130	127	3	97.7
22.	Баян-Өлгий аймгийн нисэх буудал	142	142	140	2	98.6
23.	Ховд аймгийн нисэх буудал	153	153	151	2	98.7
24.	Хөвсгөл аймгийн нисэх буудал	166	166	165	1	99.4
25.	Өвөрхангай аймгийн нисэх буудал	154	154	152	2	98.7
26.	Сүхбаатар аймгийн нисэх буудал	166	166	165	1	99.4
27.	Увс аймгийн нисэх буудал	154	154	152	2	98.7
28.	Нисэхийн мэдээлэл үйлчилгээний алба	154	154	154	-	100
29.	Холбоо, навигаци, ажиглалтын алба	154	154	153	1	99.4
30.	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба	154	154	153	1	99.4
31.	Аюулгүй байдал хамгаалалтын алба	154	154	152	2	98.7
32.	Зам тээврийн хөгжлийн төв	154	154	151	3	98.1
33.	Улсын авто замын сан	166	166	164	2	98.8
34.	Архангай АЗЗА ТӨХК	143	143	138	5	96.5
35.	Багануур АЗЗА ТӨХК	155	155	154	1	99.4
36.	Баянчандмань АЗЗА ТӨХК	167	167	166	1	99.4
37.	Булган АЗЗА ТӨХК	166	166	163	3	98.2
38.	Говь-Алтай АЗЗА ТӨХК	156	156	154	2	98.7
39.	Дархан АЗЗА ТӨХК	155	144	141	3	91
40.	Дорноговь АЗЗА ТӨХК	156	156	155	1	99.4
41.	Завхан АЗЗА ТӨХК	142	116	114	2	80.3
42.	Налайх АЗЗА ТӨХК	166	155	152	3	91.6
43.	Орхон АЗЗА ТӨХК	156	145	144	1	92.3
44.	Өвөрхангай АЗЗА ТӨХК	146	146	143	3	97.9

45.	Сэлэнгэ АЗЗА ТӨХК	140	139	136	3	97.1
46.	Талын зам ТӨХК	154	154	149	5	96.8
47.	Төв АЗЗА ТӨХК	143	142	134	8	93.7
48.	Увс АЗЗА ТӨХК	158	158	153	5	96.8
49.	Харгуй ТӨХК	155	155	152	3	98.1
50.	Хархорин АЗЗА ТӨХК	156	154	151	3	96.8
51.	Ховд АЗЗА ТӨХК	156	155	149	6	95.5
52.	Хөвсгөл АЗЗА ТӨХК	129	127	120	7	93
53.	Эрдэнэсант АЗЗА ТӨХК	156	156	156	-	100
54.	Авто Тээврийн үндэсний төв	167	167	167	-	100
55.	Архангай аймаг Автотээврийн төв	153	153	153	-	100
56.	Булган аймгийн Автотээврийн төв	165	165	165	-	100
57.	Дорнод аймгийн Автотээврийн төв	154	154	153	1	99.4
58.	Дундговь аймгийн Автотээврийн төв	153	153	152	1	99.3
59.	Баянгол техникийн хяналтын үзлэгийн төв	154	154	154	-	100
60.	Баянзүрх техникийн хяналтын үзлэгийн төв	154	154	150	4	97.4
61.	Баянзүрх зорчигч тээврийн төв	153	153	153	-	100
62.	Баянхонгор аймгийн Автотээврийн төв	153	153	152	1	99.3
63.	Баян-Өлгий аймгийн Автотээврийн төв	153	153	150	3	98
64.	Говь-Алтай аймгийн Автотээврийн төв	153	153	152	1	99.3
65.	Говьсүмбэр аймгийн Автотээврийн төв	154	154	151	3	98.1
66.	Орхон аймгийн Автотээврийн төв	154	154	152	2	98.7
67.	Өмнөговь аймгийн Автотээврийн төв	154	154	152	2	98.7
68.	Төв аймгийн Автотээврийн төв	153	153	153	-	100
69.	Увс аймгийн Автотээврийн төв	153	153	153	-	100
70.	Ховд аймгийн Автотээврийн төв	153	153	153	-	100
71.	Хөвсгөл аймгийн Автотээврийн төв	152	152	149	3	98
72.	Сонгинохайрхан зорчигч тээврийн төв	153	153	152	1	99.3
73.	Сонгинохайрхан техникийн хяналтын үзлэгийн төв	153	153	153	-	100
74.	Дорноговь аймгийн Автотээврийн төв	155	155	155	-	100
75.	Баянзүрх зорчигч тээврийн төв	158	158	158	-	100
76.	Замын-Үүд салбар Автотээврийн үндэсний төв	156	101	100	1	64.1
77.	Завхан аймгийн Автотээврийн төв	157	124	124	-	79
78.	Сэлэнгэ аймгийн Автотээврийн төв	153	153	153	-	100
79.	Сүхбаатар аймгийн Автотээврийн төв	154	154	154	-	100
80.	Өвөрхангай аймгийн Автотээврийн төв	153	153	153	-	100
81.	Хэнтий аймгийн Автотээврийн төв	153	153	153	-	100
82.	Дархан-уул аймаг Авто тээврийн төв	153	152	151	1	98.7
83.	Авто тээврийн үндэсний төв Цогтцэций салбар	143	119	118	1	82.5
84.	Далайн захиргаа ТӨҮГ	168	168	156	12	92.9
85.	Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал Төрийн өмчит ХХК	155	155	153	2	98.7
86.	Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчилалтын төсөл	166	166	165	1	99.4
87.	Баруун бүсийн авто замын коридор, хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2	154	154	151	3	98.1
88.	Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төсөл	170	170	169	1	99.4
89.	Улаанбаатар-Дарханы замд нэмэлт 2 эгнээ зам барих төсөл	95	95	92	3	96.8
Дүн		13,591	13,388	13,196	192	96.0

НЭГТГЭСЭН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Д.БЯМБАДУЛАМ

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН 2023 ОНД САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД
АУДИТЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

Нэг. Ерөнхий мэдээлэл

Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас (цаашид ХШУДАГ гэх) 2023 онд Зам, тээврийн салбарын хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, олон улсын гэрээ хэлэлцээрийн биелэлтэд хяналт шинжилгээ хийж, үр дүнд нь үнэлгээ өгөх, салбарын төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийж эрсдэлийн удирдлагаар хангах, яамны болон харъяа агентлаг, байгууллагуудын төсөв санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, санхүүгийн үйл ажиллагааг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил дутагдлыг арилгуулах зорилтын хүрээнд ажиллаж үр дүнг тооцон ажиллалаа.

Тус газар нь Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм", Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн хяналт шалгалтын стандарт", "Улсын салбарын дотоод аудитын аргачлал зэргийг удирдлага болгон Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Зам, тээврийн хөгжлийн сайд, баталсан удирдамжийн хүрээнд хамтран хэрэгжүүлж ирсэн.

Тайлант онд Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан баталсан удирдамжаар төлөвлөгөөт 2, төлөвлөгөөт бус 6 ажил хийгээд байна.

Нэг. Төлөвлөгөөт хяналт шалгалт, дотоод аудит:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/318 дугаар тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газрын 2020-2022 оны худалдан авах ажиллагаа, тус газрын удирдлагатай холбоотойгоор иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, хууль тогтоомжийн биелэлтийг шалгах үүрэг бүхий ажлын хэсэг ИНЕГ-т ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 35 дугаар хуралдааны тэмдэглэлээр "Авто замын сан"-ийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтыг шалгах үүрэг өгсөн бөгөөд энэ хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/325 дугаар тушаалаар тус санг шалгах ажлын хэсэг байгуулж, хяналт шалгалт, дотоод аудит хийж байна.

Хоёр. Төлөвлөгөөт бус хяналт шалгалт, дотоод аудит:

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 94 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Тавантолгой-Зүүнбаян", "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын төсөл, "Богдхан" төмөр замын төслийн хэрэгжилтэд болон "Зүүнбаян төмөр зам" ХХК, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх удирдамжийн хүрээнд Таван толгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн хэрэгжилт болон "Зүүнбаян төмөр зам" ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 36 дугаар тушаалын хүрээнд "Монголын төмөр зам" ТӨХК-ний хүний нөөцийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх ажлын хэсэгт ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын Авилгатай тэмцэх "Шүүр" ажиллагааны хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны 80 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ИНЕГ, "МИАТ" ТӨХК, "Улаанбаатар төмөр зам" ХНН-д тус тус ажилласан.

Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2023 оны 04/37 дугаар удирдамжийн хүрээнд "АТҮТ" ТӨҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн.

Гурав. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитаар гарсан нийтлэг зөрчил:

1. 2023 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн үлдэгдэл, хагас жилийн тооллогын үлдэгдлийг нягтлаагүй зөрүүтэй тайлагнасан байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1 дэх хэсэгт "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6 дахь хэсэгт "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7 дахь хэсэгт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"-д заасныг,
2. Улсын авто замын сан нь 2022 онд Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зуны болон ажлын хувцас нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлахдаа төсөвт өртгийг хувааж тендер шалгаруулалт явуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2 дахь хэсэг (Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ), хуулийн 8.5 дахь хэсэг (Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно)-т заасныг,
3. Зам тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/55 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тендерийн урилгыг цахим системд ажлын 5-с дээш хоног байршуулахаас ажлын 3 хоног байршуулж шалгаруулсан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг (Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална), хуулийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг (Хэлэлцээнд оролцох сонирхлоо илэрхийлэх хугацааг зарлал нийтэлж, урилга хүргүүлснээс хойш ажлын таван өдөр байхаар, хэлэлцээ эхлүүлэх хугацааг сонирхлоо илэрхийлэх эцсийн хугацаанаас хойш ажлын гурваас доошгүй өдөр байхаар зарлал, урилгад тус тус заана), 35.9 дэх хэсэг (Захиалагч хэлэлцээний үндсэн дээр баталсан тендер шалгаруулалтын баримт бичгийг цахим системд нийтэлж, тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын долоогоос доошгүй өдөр байхаар заана)-т заасныг,
4. Тайлант онд шилэн дансны цахимд байршуулах мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" заалт, Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Дөрөв. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт:

Аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хамаарах болон эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит хувьцаат компаниудыг хамруулан нийт 89 төрийн байгууллага, хуулийн этгээдийн 2023 оны жилийн эцсийн байдлаарх шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт хийхэд салбарын хэмжээнд 13,591 мэдээлэл байршуулахаас мэдээллэсэн 13,388, үүнээс хугацаа хоцроосон 192, мэдээлэл оруулаагүй 203, гүйцэтгэл 96.0 хувьтай байна.

Оны эхний хагас жилийн байдлаар шилэн дансны хэрэгжилт 95 хувьд хүрээгүй 9 байгууллагад шилэн дансны мэдээллийг хугацаандаа мэдээлэх, алдаа дутагдлаа засан сайжруулах, зөрчлийг давтан гаргасан тохиолдолд холбогдох хуулийн дагуу арга хэмжээ тооцох тухай албан бичиг хүргүүлэн ажилласан.

Тав. Өмнөх шалгалтаар илэрсэн зөрчлийн биелэлтийг хангуулах талаар:

1. Сангийн яамны Дотоод аудитын хорооны 2022 оны 10, 15 дугаар тогтоолоор өгсөн зөвлөмжийн хэрэгжилт,
2. ҮАГ-ын зөрчил арилгуулах тухай 1047/А0160091 дугаартай албан шаардлагын биелэлт,
3. ҮАГ-аас 2022-2023 онуудад хийсэн шалгалтаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг тус газрын www.fas.audit.mn цахим системд,
4. 01/1717 дугаартай албан бичгээр ирүүлсэн 2018-2022 онуудад хамаарах албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг нотлох баримтын хамт холбогдох харьяа байгууллага болон дотоод нэгжээс гаргуулан авсан биелэлтийн нэгтгэл зэргийг тус тус заасан хугацаанд холбогдох газруудад хүргүүлэн ажилласан.

Хянасан:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

А.МӨНХБАТ

Тайлан бичсэн:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Д.БЯМБАДУЛАМ